

А БҮЛЭГ — ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

121.1. Зорилго

Энэ дүрмийн зорилго нь шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна 30 буюу түүнээс дээш зорчигчийн суудалтай эсвэл төлбөрт ачаалал нь 3410кг-аас дээш онгоцоор гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

121.3. Тодорхойлолт ба товчлол

Агаарын тээврийн үйл ажиллагаа /Air operation гэж агаарын тээврийн, арилжааны агаарын тээврийн, эсхүл сонирхогчийн нисэхийн үйл ажиллагааг;

Монгол Улсын Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ /Mongolian Air Operator Certificate (АОС) гэдгийг Иргэний нисэхийн тухай хуульд зааснаар ойлгоно;

СМР гэж төлөв байдал, техник үйлчилгээ болон журмын стандарт бичиг баримт

EDTO гэж нөөц аэродромоос холдох хугацааг ихэсгэсэн нислэг

121.4. Хууль, дүрэм, журам

ИНД-119 -ийн дагуу олгогдсон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч (цаашид Гэрчилгээ эзэмшигч гэх) нь, тээвэрлэгчийн бүх ажилтнууд (хөдөлмөрийн гэрээгээр болон түр ажиллаж байгаа) иргэний нисэхийн хууль, дүрэм болон гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны ерөнхий заавар /цаашид ҮАЕЗгэх/-т тусгагдсан журмуудтай танилцсан гэдгийг бататгана.

121.6. Заавар, журмыг дагаж мөрдөх

Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа аливаа этгээд нь Гэрчилгээ эзэмшигчийн ҮАЕЗ-т тусгагдсан холбогдох журмуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

121.8. Багийн гишүүний шалгалтыг тооцох

Хэрэв багийн гишүүн энэ дүрмийн И, К, эсвэл Н бүлэгт шаардсаны дагуу шалгалт өгөх, нислэгт шалгуулах, эсвэл дүгнэлт гаргуулах ёстой байсан өдрийн өмнөх 60 хоногийн дотор шалгуулсан бол шалгуулах ёстой байсан өдрөө шалгуулсанд тооцно.

121.10. Хоосон үлдээв

121.12. Дүрмээс чөлөөлөх

(12.a) ИНЕГ – ын дарга дараах 121.381 эсвэл 121.383 –ийн дагуу агаарын хөлгийн тоноглолд тавигдах шаардлагаас нэг жилээс илүү хугацаагаар чөлөөлөхгүй.

12.a.1) 121.381 заасан зохих TAWS систем;

12.a.2) 121.383 заасан ACAS II систем.

(12.b) Энэ зүйлийн (a) хэсгийг үл харгалзан ИНЕГ –ын дарга дараах дүрмийн шаардлагуудаас чөлөөлж болохгүй.

12.b.1)

12.b.2)

121.13. Нөөц

Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

121.51. Зорилго

Энэ бүлэгт Агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагааны журмыг тогтооно.

121.53. Онгоцны нислэгт тэнцэх чадвар

Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж байгаа онгоц бүр нислэгт тэнцэх чадвар /цаашид НТЧ гэх/-ын стандарт ангиллын хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

121.55. Багийн гишүүдийн нийтлэг хэл

Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг бататгана:

55.а.1) нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа багийн гишүүн бүр нь нийтлэг нэг хэлээр харилцдаг ба нисэх багийн гишүүд нь англи хэлээр ярих, ойлгох чадвартай байх; болон

55.а.2) нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй бүх этгээд нь гэрчилгээ эзэмшигчийн ҮАЕЗ-ын холбогдох хэсгүүдийг уншиж, ойлгох чадвартай байна.

121.57. Баталгаажуулах нислэг

(57.а) Шинэ маягийн онгоцыг үйл ажиллагаандаа нэвтрүүлхээр төлөвлөж байгаа Гэрчилгээ эзэмшигч бүр нь тухайн онгоцыг агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаас өмнө ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн, гэрчилгээжүүлэгч улсын шаардагдах заалтуудыг хангасан баталгаажуулах нислэг үйлдээгүй бол гэрчилгээжүүлэх шалгалтын нислэгээс гадна, баталгаажуулах нислэгийн хөтөлбөрийг гүйцэтгэх ёстой.

(57.б) Энэ зүйлийн (а)-д заасан хөтөлбөр нь хангалттай тооны маршрутын дагуу /агаарын замын дагуух/ нөөц аэродромуудруу нисэх болон 10-аас доошгүй цагийн шөнийн нислэгийг багтаасан 100-аас доошгүй цагийн нислэгээс бүрдэнэ.

(57.с) Сүүлчийн баталгаажуулах нислэгээс хойш загварын хувьд ямар нэг өөрчлөлт хийгдсэн онгоц ашиглахаар төлөвлөж байгаа гэрчилгээ эзэмшигч бүр нь тухайн онгоцоор агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээс өмнө хөтөлбөрийн дагуу 50 – с доошгүй цагийн баталгаажуулах нислэг үйлдсэн байх ёстой.

(57.д) Энэ зүйлийн (с)-д хамааралтайгаар, дараах өөрчлөлт хийгдсэн онгоцыг загварын хувьд өөрчлөлт хийгдсэн онгоц гэж үзнэ:

57.д.1) анхны маягийн гэрчилгээжүүлэлтэд ашигласнаас өөр хөдөлгүүр суурилуулсан; эсвэл

57.д.2) онгоц, түүний эд ангид хийгдсэн, нислэгийн шинж чанарт нөлөөлөхүйц өөрчлөлтүүд.

(57.е) Онгоцны баталгаажуулах нислэг үйлдэх Гэрчилгээ эзэмшигч бүр нь тухайн нислэгт шаардагдах нисэх багаас гадна дор дурьдсан ажилтнуудаас бусад хүнийг баталгаажуулах нислэгт тээвэрлэж болохгүй:

57.е.1) дадлага болон танилцах сургалтад хамрагдаж байгаа; эсвэл

57.е.2) шугамын нислэгийн цаг хуримтлуулж байгаа; эсвэл

57.е.3) ИНЕГ-ын даргаас зөвшөөрөл олгогдсон.

121.59. Нислэгийн бэлтгэл

(59.a) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд үйлдэгдэх агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцох агаарын хөлгийн даргыг тухайн нислэгийг гүйцэтгэхэд шаардагдах бүх мэдээллээр хангана.

(59.b) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээгээр олгосон эрхийн хүрээнд үйлдэх нислэг бүрт зохих нислэгийн төлөвлөгөөг ИНД-91.307 (с), эсвэл 91.407-д заасны дагуу бэлтгэсэн байх ба нислэгийн төлөвлөгөөг агаарын хөлгийн дарга биечлэн бэлтгээгүй тохиолдолд тухайн нислэгийн төлөвлөгөөг төлөвлөсөн нислэгийн өмнө агаарын хөлгийн даргад танилцуулна.

(59.c) Энэ зүйлийн (b)-д заасны дагуу ИНД-91.307-гийн (с)-д нийцүүлэн, бэлтгэгдсэн ил харааны нислэгийн төлөвлөгөө нь хэд хэдэн нислэгийн route segment –с (SARTIME?) бүрдэж болохоос гадна, нисгэгч нь нислэгийн явцад нисэн очих аэродромоо өөрчлөх боломжтой.

(59.d) Нислэгийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэх этгээд дараах шаардлагыг хангасан гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана:

59.d.1) зохих сургалтад хамрагдсан, тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай; ба

59.d.2) үйл ажиллагааны журам, тоног төхөөрөмжид хийгдсэн аливаа өөрчлөлтийн талаарх шуурхай мэдээллээр хангагдсан.

(59.e) Энэ зүйлийн (d)-ийн 2/-г заасан шуурхай мэдээлэлд навигацийн төхөөрөмж, аэродромын мэдээллүүд, Нислэгийн хөдөлгөөний удирдлага /цаашид НХУ гэх/-ын дүрэм, журам болон тухайн орон нутгийн НХУ-ын онцлог журам, мөн нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц газрын ба навигацийн тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаа, цаг агаарын өөрчлөлтийн тухай мэдээллүүд багтана.

(59.f) ИНД-91.307(a)-г үл харгалзан, Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-д заасан нислэгийн төлөвлөгөөг агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх нислэг бүрийн өмнө зохих Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага (цаашид НХУ-ний байгууллага гэх)-д илгээнэ.

(59.g) ИНД-91.307(a) болон ИНД-91.407(a)-гийн 1/-ийг үл харгалзан, Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (f)-д заасан нислэгийн төлөвлөгөөг гэрчилгээ эзэмшигч НХУ-ний байгууллагад илгээж болох бөгөөд нислэгийн төлөвлөгөөний мэдээллийг агаарын хөлгийн даргад танилцуулсан байна.

121.61. Нислэгийн дэлгэрэнгүй төлөвлөгөө

(61.a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийг баталгаажуулсан байна:

61.a.1) тухайн онгоцны ашиглалтын цаг, циклийг үйлдвэрлэгчийн заавар болон маягийн гэрчилгээнд агуулагдсан параметруудийг ашиглан тооцоолсон; болон

61.a.2) чиг шулуун нислэг дэх салхийг тооцсон; болон

61.a.3) завсрын буудалд буух онгоц бүрийн газрын үйлчилгээнд шаардагдах хугацааг хангалттай тооцсон.

(61.b) Гэрчилгээ эзэмшигч нь дараалсан 365 хоногийн турш үйлдэх нислэгийнхээ 80-аас доошгүй хувийг нислэгийн хуваарьт урьдчилан тусгагдсан нислэгийн дэлгэрэнгүй төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн байна.

121.63. Эрэн хайх, авран туслах тухай мэдээлэл

Гэрчилгээ эзэмшигч нь, ашиглаж буй онгоц бүрийн бүхээгт нислэг үйлдэх бүсүүдийн эрэн хайх, авран туслах ажиллагаанд хамааралтай мэдээллийг байрлуулсан байна.

121.65. Онцгой тохиолдлын болон аврах тоног төхөөрөмжийн тухай мэдээлэл

(65.a) Гэрчилгээ эзэмшигч бүр онцгой тохиолдлын үед авран туслах албатай шуурхай холбоо барих зорилгоор онгоц бүрийн онцгой тохиолдлын болон аврах тоног төхөөрөмжийн тухай мэдээлэлтэй байна.

(65.b) Усан дээгүүрх үргэлжилсэн нислэгийн үед энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байна:

65.b.1) аврах завины төрөл, тоо ширхэг, өнгө; болон

65.b.2) дохионы пуужин байгаа эсэх; болон

65.b.3) эмнэлгийн яаралтай тусламжийн зүйлс болон цэвэр усны хангамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; болон

65.b.4) онцгой тохиолдлын үед ашиглах зөөврийн радио төхөөрөмжийн төрөл ба ажиллах давтамж.

121.67. Усан дээр ослын буулт үйлдэх гэрчилгээ

Гэрчилгээ эзэмшигчийн усан дээгүүр удааг хугацааны үргэлжилсэн нислэг үйлдэх онгоц нь усан дээр ослын буулт хийхээр гэрчилгээжсэн байна.

121.69. Ил харааны нислэгийн хамгийн бага харьцангуй/үнэмлэхүй өндөр

Энэ дүрмийн дагуу агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн даргад ИНД-91.311(c) хэсгийн заалт хамаарахгүй.

121.71. Аэродромын ашиглалт

(71.a) Гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөг нь дараах шаардлагыг хангаагүй ХБЗ – т буулт, хөөрөлт үйлдэхгүй:

71.а.1) тухайн аэродромын ерөнхий шинж чанар, саадын хязгаарлалт болон ил харааны хэрэглэлүүд (visual aid) дараах шаардлагыг хангасан байх:

- 1.1. ашиглагдаж буй онгоцны шинж чанарт тохирсон; болон
- 1.2. нислэг үйлдэж болох хамгийн бага цаг агаарын хязгаарлалтад нийцсэн; болон

71.а.2) Хэрэвоны....-р сарын-ээс хойш агаарын тээврийн үйл ажиллагаа тогтмол явуулах бол:

- 2.1. Монгол Улсад ашиглагдах аэродромын ХБЗ бүр нь ИНД-139 Хавсралт А.1- ийн дагуу зурвасны төгсгөл бүрт RESA-тай; эсвэл
- 2.2. Хэрэв ХБЗ нь RESA-гүй болоны....-р сарын-ээс хойш үйлдэгдэх нислэг бүрт хөөрөлт, буултын үзүүлэлтийн тооцоололтод тухайн зурвасны зарлагдсан уртаас 90 метрийн RESA зайг зурвасны төгсгөлөөс хасаж тооцох; болон
- 2.3. гадаад улсад ашиглагдах? аэродромын зурвас бүр нь 150 метрээс доошгүй RESA-тай байх, эсвэл үүнтэй тэнцэхүйц, ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх инженерийн бүтэцтэй/зохион байгуулалттай/ зохион бүтээгдсэн байх; эсвэл
- 2.4.

(71.а.2.4.а) 2.3 – д шаардсан RESA-гүй, эсвэл үүнтэй тэнцэхүйц бүтэц, зохион байгуулалтгүй бол Гэрчилгээ эзэмшигч тухайнХБЗ-д хөөрөлт, буулт үйлдэх агаарын хөлгийн үзүүлэлтийн тооцоог хийхдээ энэ дэд зүйлийн 2.3-т заасантай тэнцэхүйц хэмжээний зайг хасаж тооцно.

(71.а.2.4.б) Гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх аэродром нь дараах зүйлсээр хангагдаагүй бол хөөрөлт буулт үйлдэж болохгүй :

71.а.2.4.б.1. ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх, тухайн онгоцны маягийн хувьд тохирох гал унтраах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж; болон

71.а.2.4.б.2. тийрэлтэт /turbojet/ болон сэнст тийрэлтэт /turboprop/ хөдөлгүүрт онгоцны хувьд глиссаттай нарийвчлалтай ойртолт үйлдээгүй тохиолдолд, ойртолтын налууг илтгэх\заах ил харааны систем/ төхөөрөмж.

(71.а.2.4.с) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний YAT-д тусгагдаагүй аэродромд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

(71.а.2.4.д) Энэ зүйлийн (с) хэсэгт заасан, гэрчилгээ эзэмшигчийн YAT-д тусгагдсан аэродром бүрийн хувьд дараах хүчин зүйлсийг тодорхойлсон байна:

71.а.2.4.д.1. нислэгийн чиглэл, эсвэл нислэгийн чиглэлийн үе шат;

71.а.2.4.д.2. нисэх багийн сургалтад тавигдах шаардлага;

- 71.a.2.4.d.3. нисэх багийн дадлага туршлагад тавигдах шаардлага;
- 71.a.2.4.d.4. нисэх багийн бүрдүүлэлт (flight crew pairing)-д тавигдах хязгаарлалтууд;
- 71.a.2.4.d.5. нислэгийн үйл ажиллагааны зөвшөөрөгдсөн төрөл.
- (71.a.2.4.e) Энэ зүйлийн (f) 1/-ийг үл харгалзан, энэ зүйлийн (c) – д заагдсан аэродромууд нь 30-аас дээш зорчигчийн суудалтай онгоцоор орон нутгийн нислэгт нөөц аэродромоор ашиглагдах бол гэрчилгээжээгүй байж болно.
- (71.a.2.4.f) Энэ зүйлийн (c) – ийн дагуу гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д тусгагдсан, зорчигч тээврийн хуваарьт нислэг үйлдэх, 30-аас дээш зорчигчийн суудалтай онгоцонд ашиглагдах аэродром нь:
- 71.a.2.4.f.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа бол ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн; эсвэл
- 71.a.2.4.f.2. гадаад улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа бол ИНД-139-ийн стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан ба Чикагогийн конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас гэрчилгээжсэн байна.
- (71.a.2.4.g) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e), (f)-д заагдсан аэродромд холбогдох, дараах мэдээллийн бүртгэлтэй байхаас гадна тэдгээрийг тогтмол шинэчилж байна:
- 71.a.2.4.g.1. аэродромын өгөгдөхүүн;
- 71.a.2.4.g.2. аэродромын нөхцөл байдал нь нислэгийн аюулгүй ажиллагаанд нийцэж байгааг тодорхойлох журам/процедур;
- 71.a.2.4.g.3. аврах тоног төхөөрөмж болон бусад шаардагдах аэродромын тоног төхөөрөмжүүд нь нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж байгааг бататгах журам/процедур;
- 71.a.2.4.g.4. аэродромын ашиглалтын хязгаарлалтын талаарх нарийвчилсан мэдээлэл.
- (71.a.2.4.h) Энэ зүйлийн (i) – д зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд аливаа ХБЗ - д хөөрөлт болон буулт үйлдэхгүй:
- 71.a.2.4.h.1. ХБЗ-ны өргөн нь энэ дүрмийн Хавсралт В – ийн дагуу тодорхойлсон өргөнөөс багагүй ;болон
- 71.a.2.4.h.2. нислэгийн талбайн /runway strip/ өргөн нь ИНД139 - ийн Хавсралт В-гийн хүснэгт В-1-т дагуу тухайн агаарын хөлөг болон ХБЗ –ны хувьд тодорхойлсон өргөнөөс багагүй .
- (71.a.2.4.i) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (h)-д шаардсан өргөнөөс бага өргөнтэй ХБЗ – г дараах тохиолдлуудад гэрчилгээгээр олгогдох эрхийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглаж болно.

71.а.2.4.i.1. Гэрчилгээжсэн шалгах нислэгээр илүү бага хамгийн бага зурвасны өргөнийг Агаарын хөлгийн нислэгийн зааварт заасны дагуу тодорхойлсон, эсвэл

71.а.2.4.i.2. Гэрчилгээ эзэмшигчийн ИНД-136 дагуу олгогдсон агаарын үйлчилгээний гэрчилгээнд /Air Service Certificate/ илүү бага ХБЗ – ны өргөний хязгаарлалт тусгагдсан бол.

121.73. Шөнийн нислэгийн үйл ажиллагаа

Аливаа этгээд нь шөнийн цагт ил харааны нислэг үйлдэхгүй.

121.75. Түлш

(75.а) Гэрчилгээ эзэмшигч бүр нь нислэгийн төлөвлөгөө, нислэгийн явц дахь дахин төлөвлөлтөд нийцсэн, мөн төлөвлөсөн нислэг өөрчлөгдсөн тохиолдолд хүрэлцэхүйц түлшний нөөцтэй байх түлшний бодлоготой байна.

(75.б) Түлшний бодлого нь түлшний тооцоог дараах зүйлүүдэд үндэслэж тооцоолж байгааг бататгана:

75.б.1) хүснэгт, график, журмууд нь тухайн онгоцны үйлдвэрлэгчийн заавраас авсан бөгөөд маягийн гэрчилгээнд тусгагдсан параметруудэд нийцсэн;

75.б.2) Доорхи нөхцөлүүд болон нислэгийг үйлдэх үеийн бусад нөхцөл байдал:

- 2.1. онгоцны түлшний хэвийн зарцуулалтын өгөгдөл;
- 2.2. урьдчилан тооцоолсон жин;
- 2.3. цаг агаарын урьдчилсан тооцоо;
- 2.4. НХҮ-ний шаардлага ба хязгаарлалт;
- 2.5. нисэн очих аэродромын газар зүйн байрлал; болон
- 2.6. түлшний зарцуулалтад нөлөөлөх гадны аливаа нөлөө.

(75.с) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгт шаардагдах /USABLE FUEL/ түлшийг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг багтаасан байна:

75.с.1) онгоцны явгалалтын үед /газарт/ зарцуулах түлш; болон

75.с.2) нислэгийн үед /агаарт/ зарцуулах түлш; болон

75.с.3) дараах зүйлүүдийг багтаасан нөөц түлш;

- 3.1. Урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлын түлш; болон
- 3.2. нөөц аэродром шаардлагатай бол, нөөц аэродром руу нисэхэд шаардагдах түлш; болон
- 3.3. сүүлчийн нөөц түлш;
- 3.4. нислэгийн төрлөөс шалтгаалан шаардагдах нэмэлт түлш.

(75.d) Гэрчилгээ эзэмшигч нь түлшийг нислэгийн явц дахь дахин төлөвлөлтөд нийцүүлэн, энэ зүйлийн (с)-д зааснаас өөр хэлбэрээр тооцож болох ба энэ тохиолдолд УАТ-доо энэ талаар тусгасан байна.

121.77. Нислэгийн ажиллагааг хянах систем

(77.a) Нисэх багийн гишүүд нь дараах зүйлсийг багтаасан нислэгийн ажиллагааг хянах системийг ашиглах боломжтой гэдгийг Гэрчилгээ эзэмшигч бататгах ёстой:

77.a.1) нисэх багийн бүхээгт аюулгүй бөгөөд бүтээмжтэй ажиллах зааварчилга ба удирдамж; болон

77.a.2) нислэгийг аюулгүй гүйцэтгэх аргачлалууд.

(77.b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зарчмуудыг мөрдсөнөөр онгоцыг удирдах болон зөв шийдвэр гаргах системийг бүрдүүлнэ:

77.b.1) онгоцны нислэгийн ашиглалтын зааварт бичигдсэн зарчим; болон

77.b.2) үйлдвэрлэгчийн техникийн болон аюулгүй ажиллагааны зааварт бичигдсэн зарчим; болон

77.b.3) багийн гишүүдийн нөөцийн менежмент (CRM)-ийн зарчим; болон

77.b.4) хүний хүчин зүйл ба сэтгэл зүйн зарчим; болон

77.b.5) ажиллах орчны нөхцөл байдлын судалгаа /эргономик/-ны зарчим.

(77.c) Тухайн систем нь дараах зүйлийг багтаасан байхыг гэрчилгээ эзэмшигч бататгана:

77.c.1) үйл ажиллагааны заавар дахь дэлгэрэнгүй шалгах хуудас; болон

77.c.2) тогтсон дэс дарааллаар шалгах; болон

77.c.3) шуурхай гарын авлага (QRH); болон

77.c.4) онцгой нөхцөл байдлын үеийн журам ба бусад журмуудын шалгах хуудас.

(77.d) Тухайн систем нь нисэх багийн гишүүдийн ажлын байр бүрт зориулсан, дараах үе шатуудад мөрдөх журамтай байхыг гэрчилгээ эзэмшигч баталгаажуулна:

77.d.1) хөөрөлтийн өмнөх болон хөөрөлтийн үед;

77.d.2) нислэгийн үед; болон

77.d.3) буулт үйлдэж байх үед; болон

77.d.4) хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үед.

121.79. Онцгой тохиолдлын гэрлэн дохиолол (emergency light)-ын ажиллагаа

Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь ИНД-26-ийн Хавсралт Г-д шаардсан онцгой тохиолдлын гэрлэн дохиоллын системийг явгалалт, хөөрөлт ба буултын үед асаасан, эсвэл ажиллуулахад/цэнэгэлсэн, идвэхижүүлсэн/ бэлэн байлгана.

121.81. Зорчигчид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага ???

Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй аливаа этгээд нь дараах зүйлсийг багатгана:

- 81.а.1) зорчигчдыг онцгой тохиолдлын үед тэдгээрийг агаарын хөлгөөс нүүлгэн шилжүүлэх ажиллагаа /evacuation/-д саад учруулхааргүй байрлуулж суулгадаг байх; болон
- 81.а.2) согтууруулах ундаа нөлөөлөлд байгаа эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн эсвэл хэвийн бус зан, харилцааны дутагдалтай, онгоцны аюулгүй ажиллагаанд болон зорчигчдод аюул учруулж болзошгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах, хэрэв онгоцонд суусан бол онгоцноос буулгадаг байх; болон
- 81.а.3) хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийг хэвийн болон онцгой тохиолдлын үед тусламж үзүүлэхэд тохиромжтой суудал эзлүүлэх; болон
- 81.а.4) 15 нас хүрээгүй хүүхэд болон нярай хүүхэдтэй насанд хүрсэн зорчигчийг аврах гарцын харалдаа эгнээнд суудал эзлүүлэхийг хориглох; болон
- 81.а.5) харгалзагчтай явж байгаа этгээд онгоц болон зорчигчдод аюул учруулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авсан байх ба Гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д тусгагдсаны дагуу тухайн этгээдийг тээвэрлэхэд зориулан урьдчилан зохицуулалт хийх; болон
- 81.а.6) харгалзагчтай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй зорчигч явах бол онгоцны ахлах үйлчлэгч, эсвэл агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байна.

121.83. Зорчигчдод зориулсан мэдээлэл

(83.а) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй этгээд нь дараах нислэгийн үе шатуудад “Хамгаалах бүсээ бүслэ” гэрлэн дохиог асаасан байна:

- 83.а.1) онгоц газарт хөдөлгөөн үйлдэж байх үед;
- 83.а.2) хөөрөлтийн үед;
- 83.а.3) буултын үед; болон
- 83.а.4) агаарын хөлгийн дарга шаардлагатай гэж үзсэн бусад үед.

(83.б) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй этгээд нь агаарын хөлөгт тамхи татахыг хориглосон үед “Тамхи татахыг хориглоно” гэрлийг асааж эсвэл “Тамхи татахыг хориглоно” зурган мэдээллийг зорчигчдод өгнө.

(83.с) Хэрэв “Тамхи татахыг хориглоно” гэсэн гэрэл асдаг бол агаарын хөлөгт тамхи татахыг хориглосон үед дээрх гэрлийг асаана.

121.85. Нисэх багийн бүхээгт орох зөвшөөрөл

(85.а) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа онгоцны нисэх багийн бүхээгт, чиглэлийн нислэгийн үзлэг хийхэд тохиромжтой, урагшаа харсан 1-ээс доошгүй ажиглагчийн суудалтай байна.

(85.b) Нислэгт томилогдсон нисэх багаас бусад аливаа этгээдийг нисэх багийн бүхээгт орох, тээвэрлэх, эсвэл нисгэгчийн суудалд суухыг хориглох ба агаарын хөлгийн дарга зөвшөөрөл олгосон тохиолдолд дараах хүмүүс нисэх багийн бүхээгт орж болно:

85.b.1) багийн бусад гишүүн; эсвэл

85.b.2) ИНЕГ-ын эрх бүхий этгээд; эсвэл

85.b.3) гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д тусгагдсан журмын дагуу зөвшөөрөл олгогдсон этгээд.

(85.c) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй этгээд нь, нисэх багийн бүхээгт орхоор зөвшөөрөгдсөн эсвэл нисгэгчийн суудалд суусан аливаа этгээдэд гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д тусгагдсан аюулгүй ажиллагааны журмыг танилцуулсан байна.

121.87. Онгоцны удирдлагад оролцох эрх

(87.a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй онгоцны удирдлага, жолоодлогод дор дурьдсанаас бусад этгээд оролцохгүй гэдгийг бататгана:

87.a.1) энэ дүрмийн 121.505-ын дагуу мэргэшиж, гэрчилгээ эзэмшигч томилсон нисэх багийн гишүүн; эсвэл

87.a.2) энэ дүрмийн 121.505-ын дагуу мэргэшсэн, ИНЕГ-ын эрх бүхий этгээд нь:

2.1. гэрчилгээ эзэмшигч болон агаарын хөлгийн даргын зөвшөөрөлтэй;

2.2. албан үүргээ гүйцэтгэж байгаа

(87.b) Энэ зүйлийн (a)-ийн 1/, 2/-т зааснаас бусад аливаа этгээд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн удирдлагад оролцохгүй.

121.89. Бодит хяналтын төхөөрөмж (flight recorder)-д тавигдах шаардлагууд

(89.a) Нисэх багийн гишүүн бүр дараах зүйлийг бататгана:

89.a.1) энэ дүрмийн 121.371-д шаардсан, нисэх багийн бүхээг дэх дуу чимээ бичигч төхөөрөмж нь хөдөлгүүр асаах шалгах хуудсыг уншиж эхлэхээс нислэг гүйцэтгэж дуусах эцсийн шалгах хуудсыг уншиж дуустал тасралтгүй ажиллаж байгааг; болон

89.a.2) хэрэв онгоц нь чихэвчний болон амьсгалын маскны микрофоноос дамжуулсан дууг бичигч төхөөрөмжөөр тоноглогдсон бол 3000 метр (10000 ft)-ээс доош өндөрт чихэвчний микрофон ашиглаж байгааг; болон

89.a.3) хэрэв нисэх багийн бүхээг дэх дуу чимээ бичигч төхөөрөмж нь бичлэг арилгагчтай бол нислэгийн сүүлчийн 30 минутын бичлэг устаагүй байгааг.

(89.b) Нисэх багийн гишүүн бүр дараах зүйлсийг бататгана:

- 89.b.1) энэ дүрмийн 121.373-т шаардсан нислэгийн өгөгдөхүүн бичигч нь онгоц хөөрөлт үйлдэхээс эхлэн буулт үйлдэх хүртэл тасралтгүй ажиллаж байгааг; болон
- 89.b.2) цикл бүрийн дараа тухайн онгоцны 25 хүртэлх цагийн нислэгийн бүх мэдээлэл хадгалагдаж байгааг; болон
- 89.b.3) нислэгийн өгөгдөхүүн бичигч болон түүний системийг шалгах зорилгоор 1-ээс дээш цагийн бичлэгийг арилгахгүй байгааг; болон
- 89.b.4) энэ хэсгийн (b) 3)-ын дагуу бичлэгийг арилгахдаа:
- 4.1. хамгийн хуучин бичлэгийг сонгох; ба
 - 4.2. техник үйлчилгээний зохих баримтад тэмдэглэнэ.

121.91. Түлшээр цэнэглэх ба түлш юүлэх ажиллагаа

- (91.a) ИНД-91.15-ын 2)-ыг үл харгалзан, ИНД-119-ийн дагуу олгогдсон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд агаарын хөлөг ашиглаж байгаа этгээд нь онгоцонд зорчигчид байх үед болон сууж, буух үед гэрчилгээ эзэмшигчийн YAT-д заасан журмын дагуу аюулгүй ажиллагааны болон нүүлгэн шилжүүлэх урьдчилсан шаардлагыг хангасан нөхцөлд 3.1C, эсвэл 3.1D ангилалын шатамхай шингэнээр онгоцыг цэнэглэх, эсвэл юүлэх ажиллагааг гүйцэтгэж болно.
- (91.b) ИНД-119-ийн дагуу олгогдсон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд агаарын хөлөг ашиглаж байгаа этгээд нь дараах нөхцлүүдийг хангаж байгаа тохиолдолд нэг болон түүнээс дээш үндсэн хөдөлгүүр ажиллаж байх үед 3.1C, эсвэл 3.1D ангиллын шатамхай шингэнээр онгоцыг сумлах, эсвэл юүлэх ажиллагааг гүйцэтгэж болно:
- 91.b.1) нисэх багийн гишүүдийн хяналтан дор бүх зорчигч онгоцноос буусан, онгоцны ойр орчим аливаа саадгүй, цэвэр байх тохиолдолд; болон
- 91.b.2) сумлах, юүлэх ажиллагаанд агаарын хөлгийн дарга бүх хариуцлагыг хүлээж байх үед.

121.93. Нөөц

121.95. Онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө

- (95.a) Гэрчилгээ эзэмшигч нь, нислэгт болон газар дахь онцгой тохиолдлын үед аливаа этгээд гэмтэж осолдох эрсдлийг бууруулахад чиглэсэн, онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.
- (95.b) Гэрчилгээ эзэмшигчийн онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байх боловч эдгээрээр хязгаарлагдахгүй:
- 95.b.1) нислэгийг гүйцэтгэх агаарын зам/маршрутын төрөл, урт;
- 95.b.2) аэродромын газрын тоног төхөөрөмж;
- 95.b.3) орон нутгийн авран хамгаалах байгууллагууд;

95.b.4) НХУ-ын хангалт, тоноглолууд; болон

95.b.5) тухайн нислэгт ашиглагдах онгоцны маяг, суудлын тоо, байршил, төлбөрт ачаалал.

(95.c) Нислэгийн үе дэх онцгой тохиолдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө нь дараах зүйлсийг багтаасан байна:

95.c.1) хэрэв удирдах ажилтан нислэгт үүссэн нэн даруй арга хэмжээ авах, эсвэл шийдвэр гаргах шаардлага тулгарсан онцгой тохиолдлын талаар мэдээлэл авсан тохиолдолд тухайн ажилтны мөрдөх журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

1.1. тухайн онцгой нөхцөл байдлын талаар агаарын хөлгийн даргад мэдээлэл, зөвлөмж өгөгдсөн эсэх; болон

1.2. агаарын хөлгийн даргын шийдвэр оновчтой гэдгийг бататгах; болон

1.3. шийдвэрийн талаар тэмдэглэл хийгдэж байгааг;

95.c.2) удирдах ажилтан энэ хэсгийн 1)-д заасны дагуу агаарын хөлгийн даргатай харилцаа, холбоо тогтоох боломжгүй тохиолдолд тухайн ажилтны мөрдөж ажиллах журам нь дараах зүйлсийг бататгасан байна:

2.1. онцгой нөхцөл байдал зарлагдаж байгааг; болон

2.2. тухайн нөхцөл байдалд шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авагдаж байгааг.

(95.d) Онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу холбогдох хүмүүс шаардлагатай сургалтад хамрагдсан бөгөөд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чадвартай гэдгийг Гэрчилгээ эзэмшигч бататгана.

121.97. Үйл ажиллагааг хязгаарлах эсвэл түр зогсоох

Гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдсэн дариудаа энэхүү сөрөг нөлөөг арилгах хүртэл үйл ажиллагаагаа хязгаарлах эсвэл түр зогсооно.

121.99. Нисгэгчийн бүхээгийн хаалганы аюулгүй байдал

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй агаарын хөлгийн дарга нь зорчигчдыг суулган гадна хаалгуудыг хаасан үеэс, зорчигчдыг буулгахаар гадна хаалгуудыг нээх хүртэл нисгэгчийн бүхээгийн хаалга нь агаарын хөлгийн даргын зөвшөөрлөөр орж, гарахаас бусад тохиолдолд хаалттай, цоожтой байлгахыг бататгана.

121.101. Нисгэгчийн бүхээгийн хаалганы ойр орчмыг хянах

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй агаарын хөлгийн дарга нь ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн, харах төхөөрөмж болон аман /аудио/ журмаар дараах зүйлүүдийг бататгаагүй тохиолдолд хаалгыг нээхгүй:

101.a.1) нисгэгчийн бүхээгийн хаалганы орчимд аюулгүй гэдгийг баталгаажуулсны дараа; болон

101.а.2) нисгэгчийн бүхээгийн хаалгыг онгойлгож буй этгээд хүчээр /албадлагаар/ онгойлгоогүйг баталгаажуулсны дараа.

121.103. Нисэх багийн гишүүд хооронд нууц/сэм холбоо барих

Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй гэрчилгээ эзэмшигч нь, агаарын хөлгийн бүхээгт нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөлж болох сэжигтэй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд агаарын хөлгийн үйлчлэгч нисэх багийн гишүүнтэй бусдад мэдэгдэхгүйгээр холбоо тогтоох ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн журамтай байна.

В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ БА ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ

121.151. Зорилго

Энэ бүлэгт ИХНД, ХНД үйл ажиллагааг зохицуулах дүрмүүд болон цаг агаарын шаардлагуудыг тогтооно.

121.153. Цаг агаарын мэдээ

(153.а) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй этгээд нь дараах шаардлагыг хангасан этгээдээс нислэгт ашиглах цаг агаарын мэдээг авсны үндсэн дээр нислэгийг төлөвлөж, гүйцэтгэж, хянаж удирдана:

153.а.1) энэ зүйлийн (b)-с хамаарч, Монгол улсаас эхлэлтэй нислэгийн хэсэгт ИНД-174-ийн дагуу нисэхийн цаг уурын байгууллагын гэрчилгээ эзэмшигч байгууллагаас; эсвэл

153.а.2) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна явагдаж буй нислэгийн хувьд, дараах шаардлагуудыг хангасан нисэхийн цаг уурын байгууллагаас:

2.1. ИНД-174-тэй дүйцэхүйц стандарт шаардлагыг хангасан; болон

2.2. Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсаас цаг уурын үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон байгууллагаас.

(153.б) Монгол Улсын нутаг дэвсгэрээс эхлэлтэй бөгөөд дуусгавар болох нислэгийн хувьд, хэрэв ИНД-174.6 – ийн шаардлагын дагуу хангагдсан цаг агаарын үндсэн/ерөнхий мэдээ нь гэрчилгээ эзэмшигчийн үйлдэж байгаа нислэгт нийцэж байгаа бол агаарын хөлгийн дарга нь хэрэглэлээр үйлдэх ойртолтын журамд зориулсан цаг агаарын үндсэн мэдээллийг ашиглаж болно.

121.155. Цаг агаарын нөхцөл- ИХНД

(155.а) ИХНД-ээр үйлдэх нислэгийн замын дагуух, эсвэл тухайн нислэгийн замын тодорхой хэсэг дэх цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээнд ИНД-91-т заасан ИХНД-ийн хязгаарлалт болон энэ зүйлийн (г)-ийн шаардлагыг хангасан бол агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй этгээд нислэгийг ил хараагаар үйлдэж болно .

(155.б) Аливаа этгээд усан дээгүүр, ИХНД-ээр үргэлжилсэн нислэг үйлдэхийг хориглоно.

(155.c) Агаарын хөлгийн дарга нь дараах нөхцөлд хяналттай агаарын зайн гадна талд ИХНД-ээр нислэг үйлдэнэ:

155.c.1) үүлний өндөр 300 метр (1000 ft)-ээс доошгүй, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх; болон

155.c.2) үүлний сууринаас доош үүлгүй, газар, ус үргэлжлэн харагдаж байгаа үед; болон

155.c.3) солигдмол үүл /SCT/-нээс ихгүй үүлний дээгүүр нисэх үед.

(155.d) Агаарын хөлгийн дарга нь дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд, олон хөдөлгүүрт онгоцоор солигдмол үүл /SCT/-нээс илүү өтгөн үүлний дээгүүр ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

155.d.1) тухайн онгоц нь ХНД-ээр нислэг үйлдэх шаардлагыг хангасан ба удирдлаган дээр сууж буй нисэх баг нь ХНД-ээр нислэг үйлдэх хэрэглэлийн нислэгийн хүчин төгөлдөр зэрэглэлтэй;

155.d.2) ХНД-ээр үйлдэх нислэгт шаардлагатай радио навигацийн тоног төхөөрөмжүүд, бусад хэрэглэл, төхөөрөмжүүд нь ажиллагаатай;

155.d.3) нэг хөдөлгүүр нь татгалзсан үед онгоц үүлнээс дээш 300 метр (1000 ft)-ийн зайтай, эерэг налуу бүхий нислэгийн замыг хадгалах чадвартай;

155.d.4) тухайн онгоц болон аэродром нь ХНД-ээр ойртолтүйлдэн буух боломжтой тоног төхөөрөмжөөр тоноглогдсон; болон

155.d.5) ХНД-ээр нислэг үйлдэх онгоц нь хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт, буулт үйлдэх аэродром хүртэл нисэх хангалттай нөөц түлш авсан байх.

121.157. Цаг агаарын нөхцөл - ХНД

(157.a) Аливаа цаг агаарын бодит мэдээ, эсвэл бодит болон урьдчилсан мэдээ нь дараах нөхцөлд тохирохгүй бол агаарын хөлгийн дарга ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

157.a.1) төлөвлөсөн аэродромд нисэн очих үед тухайн аэродромын цаг агаарын нөхцөл нь холбогдох НМЭ-д заасан хязгаарлалтаас дээш байвал; эсвэл

157.a.2) нисэн очих төлөвлөсөн хугацаанд:

2.1. нэг нөөц аэродром нь ИНД-91.405 (a)-гийн 2)-т заасан үүлний суурийн өндөр болон алсын барааны харагдацын хувьд тавигдах шаардлагад тохирч байвал; эсвэл

2.2. хоёр нөөц аэродром нь ИНД-91.405 (b)-д заасан үүлний суурийн өндөр болон алсын барааны харагдацын хувьд тавигдах шаардлагад тохирч байвал.

(157.b) Агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд ИНД-91.405 (b)-д заасан үүлний суурийн өндөр болон алсын барааны харагдацад тавигдах шаардлагыг хангасан, нэгээс доошгүй аэродромыг нөөцөөр сонгож авна:

157.b.1) хөөрөлт, эсвэл буулт үйлдэх аэродром нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна байрласан; болон

- 157.b.2) буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродром нь тухайн ашиглаж буй онгоц бууж болохуйц хоёр болон түүнээс дээш тусдаа ХБЗ-гүй бол.

121.159. Аэродромын цаг агаарын хязгаарлалт- ХНД

(159.a) Ойртолтын төгсгөлийн үе шатны хяналтын цэг /цаашид FAF гэх/-ээс хойш, эсвэл FAF ашиглагддаггүй бол, хэрэглэлийн ойртолтын төгсгөлийн үе шатны хэсгийг эхлүүлэхээс өмнө FAF болон ойртолтын төгсгөлийн үе шатны хэсгийг тухайн үеийн цаг агаарын бодит мэдээгээр тухайн аэродромын алсын барааны харагдац нь НМЭ-д заасан алсын барааны харагдцын хязгаарлалтаас доогуур өгөгдсөн бол онгоцны дарга хэрэглэлийн нислэгээр буултын ойртолтыг үргэлжлүүлэхгүй.

(159.b) Энэ зүйлийн (a)-д заасан ойртолтын төгсгөлийн үе шатны хэсгийн эхлэл нь дараах цэгүүдээс эхэлнэ:

159.b.1) FAF, эсвэл хэрэглэлийн ойртолтын журамд заасан цэгээс; эсвэл

159.b.2) FAF байхгүй бөгөөд стандарт эргэлт (procedure turn)-тэй бол стандарт эргэлтийг гүйцэтгээд ойртолтын төгсгөлийн курст гарах тухайн хэрэглэлийн ойртолтын журамд заасан зайнаас.

121.161. ХНД-ээр хөөрөлт үйлдэх хязгаарлалтууд

Цаг агаарын нөхцөл нь ИНД-91.413-т заасан хөөрөлтийн хязгаарлалтаас дээгүүр болон ИНД-91.413-т заасан ХНД-ээр буулт үйлдэх зөвшөөрөгдсөн хязгаарлалтаас доогуур бол, дараах хөөрөлтийн нөөц аэродромыг сонгоогүй тохиолдолд тухайн аэродромоос ХНД-ээр хөөрөлт үйлдэхгүй:

13.a.1) хоёр хөдөлгүүртэй онгоцны хувьд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтай 1 цагийн зайд байрлах аэродром; эсвэл

13.a.2) гурав буюу түүнээс олон хөдөлгүүртэй онгоцны хувьд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтай 2 цагийн зайд байрлах аэродром.

121.163. Хөөрөлтийн багасгасан хязгаарлалт

(163.a) Хэрэв гэрчилгээ эзэмшигчийн YAT-д хөөрөлтийн багасгасан хязгаарлалтын журам тусгагдсан бол гэрчилгээ эзэмшигч нь ИНД-91.413-ын (e)-д заасан хөөрөлтийн хязгаарлалтаас багасгаж хөөрөлт үйлдэж болно.

(163.b) Хөөрөлтийн багасгасан хязгаарлалтын журам нь дараах шаардлагуудыг хангана:

163.b.1) багасгасан хязгаарлалтаар хөөрөлт үйлдэх агаарын хөлгийн дарга болон хамтран нисгэгч нь энэ дүрмийн 121.537-гийн дагуу бэлтгэгдсэн;

163.b.2) тухайн ХБЗ нь гол шугамны тэмдэглэгээ, эсвэл гэрэлтүүлэгтэй;

163.b.3) НМЭ-д тухайн ХБЗ дээр хөөрөлтийн багасгасан хязгаарлалт оруулсан;

- 163.b.4) тухайн онгоц нь сэнст хоёр хөдөлгүүртэй тохиолдолд уг онгоц нь автомат флюгерийн (auto-feather) буюу сэнсний өнцгийг автоматаар өөрчлөх (auto-coarse) хэвийн ажиллагаат системээр тоноглогдсон;
- 163.b.5) зурвасан дээрх алсын барааны харагдац нь ХБЗ-ны алсын барааны харагдац (RVR)-аар тогтоогдсон; болон
- 163.b.6) тухайн хөөрөлтийг үйлдэхэд шаардлагатай алсын барааны харагдацыг тодорхойлох, хянах аргачлал нь ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн.

121.165. Чиглэлийн нислэг үйлдэх зайн хязгаарлалтууд

- (165.a) Гэрчилгээ эзэмшигч нь поршинт-хөдөлгүүрт онгоцоор стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар 1 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх аэродромуу нислэг үйлдэхгүй.
- (165.b) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр турбинт-хөдөлгүүртэй онгоцоор, стандарт цаг агаарын нөхцөлд, тогтуун агаарт, нэг хөдөлгүүр татгалзсан үеийн чиг шулуун нислэгийн хурдтайгаар 1 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх аэродромуу дор дурьдсанаас бусад тохиолдолд нислэг үйлдэхгүй:
 - 165.b.1) ИНД-121.955-ийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн онгоц зохистой (adequate) аэродромоос 60 минутаас илүү нисэх (стандарт атмосферийн нөхцөлд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр нь татгалзсанаар тооцсон) үйлдвэрлэгчээс гаргасан маягийн загварын тодорхойлолтоор (type design specifications) гэрчилгээжсэн;
 - 165.b.2) гэрчилгээ эзэмшигч энэ дүрмийн О бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх эрхтэй; болон
 - 165.b.3) тухайн онгоц энэ дүрмийн EDTO-гийнзохих шаардлагуудыг хангасан.
- (165.c) Энэ зүйлийн (d)-д хамааралтайгаар, гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн О бүлгийн дагуу EDTO нислэгийн зохих шаардлагыг хангаагүй зохистой (adequate) аэродромоос 180 минутаас илүү нисэх (стандарт атмосферийн нөхцөлд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр нь татгалзсанаар тооцсон), хоёроос дээш турбинт-хөдөлгүүртэй онгоцыг агаарын тээврийн үйл ажиллагаандаа ашиглахгүй.
- (165.d) Энэ зүйлийн (c)-д заасан шаардлага нь гэрчилгээ эзэмшигчид 20...оны...-р сарын...-ний өдөр хүртэл хамаарахгүй.

121.167. Нөөц

121.169. ХНД-ийн журмууд

- (169.a) Агаарын хөлгийн дарга нь дор дурьдсанаас бусад тохиолдолд, холбогдох НМЭ-д заасан маршрутын дагуу ХНД-ээр агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэнэ:
 - 169.a.1) аюултай нөхцөл байдлаас зайлсхийх шаардлага тулгарсан үед; эсвэл
 - 169.a.2) НХҮ-ний радиолокаторын хяналтан дор нислэг үйлдэж байгаа үед; эсвэл

169.а.3) холбогдох НХУ-аас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр маршрутын бус нислэг үйлдэж буй үед; эсвэл

169.а.4) гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д өөрөөр заагдсан бол, тухайн зөвшөөрсөн үйл ажиллагааг гүйцэтгэхэд.

(169.б) Хяналттай агаарын зайд холбогдох НХУ-аас өөр хэлбэрээр зөвшөөрөл олгоогүй бол агаарын хөлгийн дарга нь холбогдох НМЭ-д заасан тухайн аэродромын ХНД-ээр гаралт, ойртолт үйлдэх журмыг дагаж мөрдөнө.

(169.с) Хяналтгүй агаарын зайд агаарын хөлгийн дарга нь зөвхөн холбогдох НМЭ-д заасан, тухайн аэродромын ХНД-ээр гаралт, ойртолт үйлдэх журмыг дагаж мөрдөнө.

121.171. Туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд тавигдах шаардлага

(171.а) Энэ зүйлийн (б)-д хамааралтайгаар, ИНЕГ-ын дарга зөвшөөрөөгүй бол гэрчилгээ эзэмшигч туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

(171.б) Энэ зүйлийн (а) хэсэг нь 20...оны ...-р сарын ...-ийг хүртэл хүчинтэй агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчид хамаарахгүй.

121.173. Туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх хүсэлт гаргах

Гэрчилгээ эзэмшигч нь туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх авахын тулд дараах мэдээллийг үйл ажиллагаа эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

13.а.1) EDTO нөөц аэродромд тавигдах шаардлагыг хангасан туйлын бүсийн аэродромын дэлгэрэнгүй мэдээлэл болон чиглэлээ өөрчлөх (divert) үед шаардагдах аливаа үйл ажиллагааны шаардлага;

13.а.2) энэ зүйлийн 1)-д заасан нөөц аэродромын аврах төлөвлөгөө (recovery plan);

13.а.3) түлш хөлдөлтөөс сэргийлэх стратеги болон түлш хөлдөлтийг хянах журам;

13.а.4) туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ энэ дүрмийн 121.957(б) 2)-ын 2.2-т заасан холбооны тоног төхөөрөмжийг бататгасан төлөвлөгөө;

13.а.5) туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх сургалтын төлөвлөгөө;

13.а.6) нарны туяарлаас шалтгаалсан нисэх багийн гишүүдийн радиацийн хордлогыг багасгах журам; болон

13.а.7) ИНЕГ-ын дарга тухайн улирлын цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж шаардлагатай гэж үзээгүй тохиолдолд, туйлын бүсэд аэродромын орчим гадна орчинд ямар нэг үйл ажиллагаа явуулах нисэх багийг хүйтнээс хамгаалах хоёроос доошгүй хос дулаан хувцас онгоцонд авч явж буйг баталгаажуулсан журам.

121.175. Туйлын бүсэд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгох

Хэрэв ИНЕГ-ын дарга энэ дүрмийн 121.173-т заасан аэродром, дэлгэрэнгүй мэдээлэл болон журмууд нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан гэж үзвэл ИНД-119.15-д заасан гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулж болно.

Г БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

121.201. Ерөнхий зүйл

(201.a) Энэ Бүлэгт, дараах зорилгоор ашиглаж буй онгоцны ашиглалтын хязгаарлалтад тавигдах нислэгийн үзүүлэлтийн шаардлагыг тогтооно:

201.a.1) агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй онгоц; болон

201.a.2) FAR-25-ын НТЧ-ын стандартын дагуу, эсвэл түүнтэй ижил төстэй стандартын дагуу гэрчилгээжсэн, ИНД-135-ын дагуу үйл ажиллагаанд ашиглагдаж буй онгоцнууд нь:

2.1. 20 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай, сэнст хөдөлгүүртэй; эсвэл

2.2. тийрэлтэт олон-хөдөлгүүртэй (turbojet, turbofan).

(201.b) Энэ бүлгийн шаардлагыг бүрэн хангаагүй онгоцыг алтернатив нислэгийн үзүүлэлтийн хязгаарлалтын хүрээнд ашиглахаар зөвшөөрч болно.

121.203. Нөөц

121.205. Нислэгийн ерөнхий үзүүлэлт

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоц бүр нь дараах шаардлагуудыг хангасан байна:

13.a.1) дараах зүйлийг тооцсоноор, хөөрөлт эхлэхийн өмнөх хөөрөлтийн жин нь энэ Бүлэгт зөвшөөрөгдсөн жингээс илүүгүй байна:

1.1. тухайн нислэгийн явц дахь жингийн хорогдлыг; болон

1.2. энэ Бүлгийн дагуу шаардлагатай үед агаарт түлш цацалтыг (fuel jettison).

13.a.2) энэ Бүлэгт заасан нислэгийн үзүүлэлтэд тавигдах шаардлагуудыг хангаж буйг тодорхойлоход ашиглагдах өгөгдөхүүнүүд нь:

2.1. тухайн онгоцны Нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан; эсвэл

2.2. бохирдсон ХБЗ-ын буултын зайн өгөгдөхүүнүүдийн хувьд тухайн онгоцны үйлдвэрлэгчээс тогтоогдсон болон ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн.

121.207. Хөөрөлтийн зай

(207.a) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоцны хөөрөлтийн жинг тухайн онгоцны Нислэгийн ашиглалтын зааварт заасан хөөрөлтийн хамгийн их жингээс хэтрүүлж болохгүй.

(207.b) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (a)-д заасан хөөрөлтийн хамгийн их жинг, эрсдэлтэй хөдөлгүүр (critical engine) VEF хурдан дээр татгалзсан гэж үзэн, V1 хурдыг ашиглан тооцоолохдоо дараах нөхцөл байдлыг авч үзнэ:

207.b.1) хөөрөлтийг зогсооход шаардагдах зай /ASDR/ нь хөөрөлтийг зогсоох боломжит зай /ASDA/-наас ихгүй байх;

207.b.2) хөөрөлт үйлдэхэд шаардагдах зай /TODR/ нь хөөрөлтийн боломжит зай /TODA/-наас ихгүй байх;

207.b.3) хөөрөлт үйлдэх боломжит зайн саадгүй байх аливаа хэсэг нь хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зайн /TORA/ хагасаас ихгүй байх; болон

207.b.4) нойтон болон бохирдсон ХБЗ-аас хөөрөхдөө, багасгасан V1 хурдыг ашиглан онгоц зурвасны гадаргуугаас дээш 4,5 метр (15 ft)-ийн өндөр авах цэг хүртэлх хөөрөлтийн зайг тооцоолно;

207.b.5) хөөрөлт үйлдэх гүйлтийн шаардлагатай зай /TORR/ нь хөөрөлтийг зогсоох ба үргэлжлүүлэх шийдвэр гаргах V1 хурдыг ашиглан тооцсон хөөрөлт үйлдэх гүйлтийн боломжит зай /TORA/-наас ихгүй; болон

207.b.6) нойтон ба бохирдсон ХБЗ-наас нислэг үйлдэх үеийн хөөрөлтийн жин нь тухайн ХБЗ хуурай үед, ижил нөхцөлд нислэг үйлдэх хөөрөлтийн зөвшөөрөгдсөн жингээс илүүгүй байх.

(207.c) Хөөрөлтийн жинг энэ зүйлийн (b)-д заасны дагуу тооцоолохдоо Гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг харгалзана:

207.c.1) аэродромын батлагдсан өндөр;

207.c.2) стандарт агаарын даралт /ISA/-аас 1 хувиас дээш өөрчлөлттэй тохиолдолд тухайн аэродромын даралтын өндөр;

207.c.3) тухайн аэродром орчмын гаднах агаарын хэм;

207.c.4) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл ба гадаргуугийн нөхцөл байдал;

207.c.5) хөөрөлтийн чиглэл дэх ХБЗ-ны налуу; болон

207.c.6) цаг агаарын мэдээнд өгөгдсөн, урдаас чиглэсэн бүрдүүлэгч салхины 50%-иас ихгүй, эсвэл араас чиглэсэн бүрдүүлэгч салхины 150%-иас багагүй байх.

121.209. ХБЗ-ны гадаргууг засварлах хүчин зүйлс

Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үзүүлэлтийн өгөгдөхүүнгүй тохиолдолд

ХБЗ-ны гадаргуугийн төрлийг засварлахдаа, энэ дүрмийн 121.207 (c)-гийн 4/-т заасан ХБЗ-ны гадаргуугийн төрөлд зориулан тооцоолсон хөөрөлтийн зай болон 121.221(c)-гийн 3/-т

заасан буултын зайг ХБЗ-ны өөр төрлийн гадаргуугийн хувьд хэрэглэхээр бол Хүснэгт 1-д заасан үзүүлэлтийг ашиглана.

Хүснэгт 1.

<i>Гадаргуугийн төрөл</i>	<i>Хөөрөлтийн зайд нөлөөлөх хүчин зүйлс</i>	<i>Хөөрөлтийг зогсоох зайд нөлөөлөх хүчин зүйлс</i>	<i>Буултын зайд нөлөөлөх хүчин зүйлс</i>
Засмал (Асфальт)	x 1.00	x 1.00	x 1.00
Корал	x 1.00	x 1.03	x 1.05
Металл	x 1.05	x 1.06	x 1.08
Сайжруулсан хөрс	x 1.08	x 1.14	x 1.16
Сайжруулаагүй хөрс	x 1.14	x 1.20	x 1.18

121.211. Хөөрөлтийн цэвэр нислэгийн зам

(211.a) Гэрчилгээ эзэмшигчийн нислэг үйлдэж буй онгоц бүр нь эрсдэлтэй хөдөлгүүр татгалзсан гэж үзэн, хөөрөлтийн цэвэр нислэгийн зам нь дор дурдсан өндрүүдэд, босоо чиглэлд саадгүй өнгөрч байгааг баталгаажуулна:

211.a.1) тухайн онгоц 150-аас ихгүй кренээр эргэлт үйлдэхээр бол 10.5 метр (35 ft) хүртэл; болон

211.a.2) дараах нөхцөлд хөөрөлт үйлдэх үед 4.5 метр (15 ft) хүртэл:

2.1. тухайн онгоц 150-аас ихгүй кренээр эргэлт үйлдэх; болон

2.2. энэ дүрмийн 121.207 (b)-гийн 4/-ийн шаардлагыг хангасан; болон

211.a.3) тухайн онгоц 150-аас их кренээр эргэлт үйлдэхээр бол 15 метр (50 ft) хүртэл; болон

211.a.4) дараах нөхцөлд хөөрөлт үйлдэх үед 9 метр (30 ft) хүртэл:

4.1. тухайн онгоц 150-аас их кренээр эргэлт үйлдэх; болон

4.2. энэ дүрмийн 121.207-гийн (b)-гийн 4/-ийн шаардлагыг хангасан бол.

(211.b) Энэ зүйлийн (a)-д хамааралтайгаар, нислэгийн замын хажуугаас ямар нэг саад хүртэлх зай нь дараах хэмжээнээс бага тохиолдолд саадыг хөөрөлтийн цэвэр нислэгийн замд байна гэж тооцно:

211.b.1) хөөрсний дараах нислэгийн чиглэл нь 150-аас илүү өөрчлөлт шаардахгүй үед:

1.1. 75м+0.125D-аас 600 метр хүртэл, эсвэл Гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил хараагаар харж болохуйц, эсвэл радио навигацын тусламжтайгаар замаа хадгалах журамтай бол 300 метр хүртэл; эсвэл

- 1.2. хөөрөлтийн гэрчилгээжсэн хамгийн их жин /MCTOW/ нь 22700 кг-аас ихгүй онгоцоор, ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөл (VMC)-д, өдрийн цагаар үйлдэх нислэгийн хувьд 45м+0.125D-аас 600 метр хүртэл, эсвэл Гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил хараагаар харж болохуйц, эсвэл радио навигацын тусламжтайгаар замаа хадгалах журамтай бол 300 метр хүртэл; эсвэл
- 211.b.2) хөөрсний дараах нислэгийн чиглэл нь 150-аас илүү өөрчлөлт шаардах үед:
- 2.1. 75м+0.125D-аас 900 метр хүртэл, эсвэл Гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил хараагаар харж болохуйц, эсвэл радио навигацын тусламжтайгаар замаа хадгалах журамтай бол 600 метр хүртэл; эсвэл
- 2.2. хөөрөлтийн гэрчилгээжсэн хамгийн их жин /MCTOW/ нь 22700 кг-аас ихгүй онгоцоор, ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөл (VMC)-д өдрийн цагаар үйлдэх нислэгийн хувьд 45м+0.125D-аас 900 метр хүртэл, эсвэл Гэрчилгээ эзэмшигч нь нисгэгчид зориулсан ил хараагаар харж болохуйц, эсвэл радио навигацын тусламжтайгаар замаа хадгалах журамтай бол 600 метр хүртэл.
- (211.c) Энэ зүйлийн (b)-д хамааралтайгаар, “D”- гэдэг нь хөөрөлтийн боломжит зайн төгсгөл /онгоц хөөрч өндөр аван 15м-г хүрэх цэг/-өөс саад хүртэлх хэвтээ зайн хэмжээ.
- (211.d) Энэ зүйлийн (a)-д заасан хөөрөлтийн цэвэр нислэгийн замыг тооцоолохдоо гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг баталгаажуулна:
- 211.d.1) дараах хүчин зүйлсийг тооцно:
- 1.1. хөөрөх гүйлт эхлэхээс өмнөх хөөрөлтийн хүнд;
- 1.2. аэродромын батлагдсан өндөр;
- 1.3. стандарт агаарын даралт /ISA/-аас 1 хувиас дээш өөрчлөлттэй тохиолдолд тухайн аэродромын даралтын өндөр;
- 1.4. аэродром орчмын гадна агаарын хэм; болон
- 1.5. цаг агаарын мэдээнд өгөгдсөн, урдаас чиглэсэн бүрдүүлэгч салхины 50%-иас ихгүй, эсвэл араас чиглэсэн бүрдүүлэгч салхины 150%-иас багагүй байх.
- 211.d.2) хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 метр (50 ft)-ийн өндөрт хүрэхээс өмнө нислэгийн чиглэлийг 150-аас илүү өөрчлөхгүй; болон
- 211.d.3) ИНЕГ-ын дарга өөрөөр зөвшөөрөөгүй бол:
- 3.1. хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 метр (50 ft)-ийн өндөрт хүрэхээс өмнө эргэлтийг 150-аас илүү үйлдэхгүй;
- 3.2. хөөрөлтийн гадаргуугаас дээш 120 метр (400 ft)-ийн өндрийг хүртэл эргэлтийг 200-аас илүү үйлдэхгүй;
- 3.3. хөөрөлтийн гадаргуугаас дээш 120 метр (400 ft)-ээс дээш өндрийн үед эргэлтийг 250-аас илүү үйлдэхгүй,

- 211.d.4) дараах нөхцөлүүдийг зөвшөөрснийг:
- 4.1. нислэгийн зам болон нислэгийн хурдад нөлөөлөх эргэх кренийг;
 - 4.2. нислэгийн хурдыг ихэсгэснээс зай нэмэгдэхийг; болон
 - 4.3. энэ дүрмийн 121.213-т тусгагдсан өндөр авалтын градиентын алдагдал болон хурдны уналтын хязгаарыг хадгалахыг.

(211.e) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлийг тусгасан журмыг боловсруулсан байна:

- 211.e.1) энэ дүрмийн шаардлагуудыг хангасан;
- 211.e.2) саадаас чөлөөтэй нислэгийн аюулгүй замыг сонгох; болон
- 211.e.3) энэ дүрмийн 121.161-д заагдсан нөөц аэродромд, эсвэл хөөрөлт үйлдсэн аэродромд аюулгүй буулт үйлдэх боломжийг хангасан.

121.213. Хөдөлгүүрийн татгалзал - градиент болон хурдны уналтад хийгдэх өөрчлөлт

Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үзүүлэлтийн өгөгдөхүүнгүй тохиолдолд энэ дүрмийн 121.213 (c)-гийн 4/-ийн 4.3-ыг дагаж мөрдөх үүднээс, Хүснэгт 2-т заасан хүчин зүйлсийг ашиглан өндөр авалтын градиентын алдагдлыг тооцоолох болон хурдны уналтын хязгаарыг хадгалах үүрэгтэй.

Хүснэгт 2.

Эргэлтийн өнцөг	Хурданд хийгдэх өөрчлөлт	Градиентад хийгдэх өөрчлөлт
15 ⁰ -аас 19 ⁰	V ₂	1 х Онгоцны нислэгийн ашиглалтын заавар 15 ⁰ градиент алдагдал
20 ⁰ -аас 24 ⁰	V ₂ + 5 кнот (V ₂ +10 км/цаг)	2 х Онгоцны Нислэгийн ашиглалтын заавар 15 ⁰ градиент алдагдал
25 ⁰	V ₂ +19кнот (V ₂ +35 км/цаг)	3 х Онгоцны Нислэгийн ашиглалтын заавар 15 ⁰ градиент алдагдал

121.215. Нислэгт эрсдэлтэй хөдөлгүүр татгалзах

(215.a) Гэрчилгээ эзэмшигч нь ашиглаж байгаа онгоц бүрийн хувьд, нислэгт нэг хөдөлгүүр татгалзсан үеийн нислэгийн замын өгөгдөхүүнийг ашиглан дараах зүйлсийг баталгаажуулна:

- 215.a.1) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, нислэг үйлдэхээр төлөвлөсөн замын дагуу хааш хаашаа 18.5 км (10 nm) дотор орших газар нутаг, саадаас дээш 300 метр (1000 ft)-ээс доошгүй өндөрт нислэгийн замаа эерэг налууутай хадгалж чадах болон хөдөлгүүр татгалзсаны дараа буулт үйлдэх аэродромоос дээш 450 метр (1500 ft)-ийн өндөрт нисэх чадвартайг; болон

- 215.a.2) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд нислэг үйлдэхээр төлөвлөсөн замын дагуу хааш хаашаа 18.5 км (10 nm) дотор, 600 метр (2000 ft)-ээс дээш өндөрт аливаа саадгүй байхыг;
- 215.a.3) дор дурдсан нөхцөлийг тооцсоноор, онгоцыг чиг шулуун нислэгээс 121.221-ийн, эсвэл 121.223-ын дагуу буулт үйлдэх аэродром хүртэлх нислэгийн зам нь чөлөөтэй үргэлжлэх боломжтойг:
- 3.1. чиглэлийн дагуу хамгийн эрсдэлтэйд тооцогдох цэг дээрх хөдөлгүүрийн татгалзал;
 - 3.2. мөсдөлтөөс хамгаалах системийг ажиллуулах тохиолдолд уг системийн үзүүлэх нөлөө;
 - 3.3. урьдчилан мэдэгдсэн агаарын хэм;
 - 3.4. нислэгийн зам дахь урьдчилан мэдэгдсэн салхины нөлөө; болон
 - 3.5. түлшийг цацахдаа аэродром хүртэл нислэг үйлдэхэд шаардлагатай түлшний нөөцийг авч үлдэх; болон
- 215.a.4) хөдөлгүүртатгалзсаны дараа буулт үйлдэх аэродромд дараах шаардлага хангагдсаныг:
- 4.1. тухайн онгоцны буултын хүндэд шаардагдах нислэгийн үзүүлэлтийг хангасан; болон
 - 4.2. буултын үеийн цаг агаарын урьдчилсан мэдээ болон аэродромын нөхцөл байдал нь буултыг аюулгүй үйлдэх боломжтой.

(215.b) Хэрэв нисгэгч нь радио навигацийн тоноглол ашиглан нислэгийн замын өргөнийг 9.3 км (10nm)-т хадгалж чадах бол энэ зүйлийн (a)-гийн 1/ ба 2/-т заасан нислэгийн төлөвлөсөн замын өргөнийг 18.6 км (10 nm)-ээс 9.3 км (5 nm) хүртэл багасгаж болно.

121.217. Чиг шулуун нислэгийн 90 минутын хязгаарлалт

- (217.a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, гэрчилгээ эзэмшигч гурав ба түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан тооцоот буултын жингийн үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос, нислэгийн 90 минутаас дээш зайд нислэг үйлдэж болохгүй.
- (217.b) Дараах нөхцөл хангагдсан тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гурав ба түүнээс дээш хөдөлгүүртэй онгоцоор, тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан тооцоот буултын жингийн үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос, нислэгийн 90 минутаас дээш зайд нислэг үйлдэж болно:
- 217.b.1) тухайн онгоц чиг шулуун нислэгийн замаас, тухайн цаг агаарын нөхцөлд хоёр хөдөлгүүр зэрэг татгалзсан гэж үзэх цэгээс хоёр хөдөлгүүр татгалзсан үеийн журмаар хэвийн буулт үйлдэх боломжит аэродром руу нислэгээ үргэлжлүүлэх боломжтой;
 - 217.b.2) энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, нислэгийн зам нь мөсдөлт эсэргүүцэх системийн нөлөөллийг тооцсоноор, нислэг үйлдэхээр төлөвлөсөн замын дагуу хааш хаашаа 18.6 км (10 nm) дотор орших тухайн

газар нутаг, саадаас дээш 600 метр (2000 ft)-ээс доошгүй өндөрт эерэг налууутай нислэгээ үргэлжлүүлэх боломжтой;

217.b.3) хоёр хөдөлгүүр татгалзсаны дараа, нислэгийн зам нь буулт үйлдэх аэродромоос дээш 450 метр (1500 ft)-ийн өндөрт эерэг налууутай нислэгээ үргэлжлүүлэх боломжтой; болон

217.b.4) хоёр хөдөлгүүр татгалзах үеийн онгоцны жин нь, буулт үйлдэх аэродромд нисэн очих ба очсоны дараа тухайн аэродром дээр 450 метр (1500 ft)-ээс доошгүй өндөрт 15 минутын турш нислэг үйлдэхэд хүрэлцэхүйц түлшийг багтаасан жингээс багагүй байх.

(217.c) Хэрэв нисгэгч нь радио навигацийн тоноглол ашиглан нислэгийн замын өргөнийг 9.3 км (10nm)-г хадгалж чадах бол энэ зүйлийн (b)-гийн 2/-г заасан нислэгийн төлөвлөсөн замын өргөнийг 18.6 км (10 nm)-ээс 9.3 км (5 nm) хүртэл багасгаж болно.

(217.d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-гийн дагуу тооцоо хийхдээ, тухайн онгоцны тооцоот буултын жингийн үзүүлэлтийн шаардлагад нийцсэн аэродромоос нислэгийн 90 минутын зайнаас илүү алслагдсан, нислэгийн замын хамгийн эрсдэлтэй гэж үзэх цэгт, тогтуун стандарт агаарын хэмд, тухайн онгоцны бүх хөдөлгүүр чиг шулуун нислэгийн хурдны горим дээр ажиллаж байхад хоёр хөдөлгүүр нь татгалзсан гэж үзнэ.

121.219. Нисэн очих болон нөөц аэродромд 2-р тойрогт гарахад тавигдах шаардлага

Гэрчилгээ эзэмшигч нь нислэг үйлдэж байгаа онгоцны хувьд дараах шаардлагыг хангасан байна:

13.a.1) нисэн очих аэродром болон нөөц аэродромд тооцоот цагт буулт үйлдэх үеийн гаднах агаарын хэм, аэродромын өндрийг тооцсон онгоцны буултын жин нь ойртолт үйлдэх болон 2-р тойрогт гарах хамгийн их жингээс илүүгүй байх; болон

13.a.2) 60 метр (200 ft)-ээс доош шийдвэр гаргах өндөртэй хэрэглэлийн тусламжтай ойртолт үйлдэх нислэгт, хөөрөлтийн жин болон нислэгт зарцуулагдах түлшийг тооцоолон, эрсдэлтэй хөдөлгүүр /critical engine/ татгалзсан гэж үзэн 2-р тойрогт гарах үеийн өндөр авах градиент нь:

2.1. 2.5%-иас доошгүй; эсвэл

2.2. энэ дүрмийн 121.211-ийн дагуу нислэгийн замд аливаа саадгүй байх шаардлагыг 2-р тойрогт гарах градиент нь хангасан.

121.221. Хуурай зурвасанд буух зай

(221.a) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй онгоц бүрийн тооцоот цагийн буултын жин нь тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан буултын жингээс хэтрэхгүй байна.

(221.b) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй онгоц бүрийн нисэн очих аэродром болон нөөц аэродромд буулт үйлдэх тооцоот цагийн буултын жин нь хуурай ХБЗ дээр, зурвасны

босгоноос дээш 15 метр /50 ft/-т байрлах цэгээс дараах зайд онгоц бүрэн зогсохоор тооцоологдсон байна:

221.b.1) тийрэлтэт хөдөлгүүрт (turbojet, turbofan) онгоцны хувьд, нисэн очих аэродром болон нөөц аэродромын буулт үйлдэх боломжит зайн /LDA/ 60%-ийн дотор; болон

221.b.2) сэнст хөдөлгүүрт (propeller powered) онгоцны хувьд, нисэн очих аэродром болон нөөц аэродромын буулт үйлдэх боломжит зайн /LDA/ 70%-ийн дотор.

(221.c) Гэрчилгээ эзэмшигч нь буултын жингэнэ зүйлийн (b)-гийн дагуу тооцоолохдоо дараах зүйлийг харгалзан үзнэ:

221.c.1) аэродромын батлагдсан өндөр;

221.c.2) тухайн аэродром дахь гадна агаарын хэм;

221.c.3) ХБЗ-ны гадаргуугийн төрөл, нөхцөл;

221.c.4) тухайн ХБЗ-ны буулт үйлдэх чиглэл дэх налуу; болон

221.c.5) урдаас чиглэсэн бүрдүүлэгч салхины 50%-иас ихгүй, эсвэл араас чиглэсэн бүрдүүлэгч салхины 150%-иас багагүй салхи.

(221.d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b), (c)-д заасны дагуу, буултын тооцоо хийх онгоцыг нислэгт гаргахдаа тухайн онгоц дараах зүйлсийг тооцоолон хамгийн боломжит ХБЗ-д буулт үйлдэнэ гэж үзнэ:

221.d.1) цаг агаарын урьдчилсан нөхцөл, байдал;

221.d.2) хүрээлэн буй газар нутаг;

221.d.3) ойртолт, буултын тоноглолууд; болон

221.d.4) 2-р тойрогт гарах нислэгийн зам дахь саадууд.

(221.e) Гэрчилгээ эзэмшигч нь, нисэн очих аэродромын хувьд энэ зүйлийн (d)-г тооцох боломжгүй ч, нөөц аэродром нь энэ зүйлийн (a), (b) болон (c)-д нийцэж байгаа тохиолдолд тухайн онгоцыг нислэгт гаргаж болно.

121.223. Нойтон ба бохирдсон зурвасын буултын зай

(223.a) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй онгоц бүр нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгана:

223.a.1) цаг агаарын бодит, эсвэл урьдчилсан мэдээнд тулгуурлан онгоц нисэн очих үед ХБЗ нойтон байна гэж үзвэл буултын боломжит зай /LDA/ нь энэ дүрмийн 121.221-д шаардсан буултын зайн 115%-иас багагүй байх;

223.a.2) цаг агаарын бодит, эсвэл урьдчилсан мэдээнд тулгуурлан онгоц нисэн очих үед ХБЗ бохирдсон байна гэж үзвэл буултын боломжит зай /LDA/ нь :

2.1. энэ дүрмийн 121.221-д шаардсан буултын зайн 115%-иас багагүй; эсвэл

- 2.2. буултын зай нь бохирдсон зурвасны өгөгдөхүүнүүдээр тодорхойлогдоно.

(223.b) Нойтон зурвас дээрх буултын зай нь энэ зүйлийн (а)-д зааснаас богино, энэ дүрмийн 121.221-д зааснаас урт, мөн онгоцны өгөгдөхүүнүүд нь нойтон зурвас дээр богино зайд буулт үйлдэх боломжтой байвал тухайн зурвасыг ашиглаж болно.

121.225. Огцом ойртолт ба богино зайд буулт үйлдэх

Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд ойртолтыг 4.50, түүнээс илүү өнцгөөр ХБЗ-ны босго дээр ирэх өндөр нь 10.5-15 метр (35-50 ft)-ийн хооронд байвал огцом ойртолт үйлдэх журмын дагуу үйлдэж болно:

13.а.1) огцом ойртолт үйлдэх хамгийн их налууугийн өнцөг (slope angle), бусад хязгаарлалт, журам (огцом ойртолт үйлдэх онцгой тохиолдлын журмыг оролцуулан) болон тухайн талбайн уртын өгөгдөхүүнүүдэд зориулагдсан нэмэлт заалтууд нь тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан;

13.а.2) ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд, огцом ойртолт үйлдэх аэродромд буух ил харааны ойртолтын налууг заах систем /VASIS/-тэй;

13.а.3) Огцом ойртолт үйлдэх ХБЗ бүрт ХНД-ээр үйлдэх нислэгийн цаг агаарын хязгаарлалт нь тодорхойлогдож, зөвшөөрөгдсөн;

13.а.4) ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд дараах зүйлсийг харгалзана:

- 4.1. саадууд;
- 4.2. ойртолтын налууг тодорхойлох заалт болон зурвасны курсын чиглүүлэгч төхөөрөмж (MLS, GPS, ILS, LOC, VOR, NDB)-ийн төрөл;
- 4.3. шийдвэр гаргах өндрөөс ил харааны баримжаа тогтоох хэрэгсэл;
- 4.4. агаарын хөлгийн тоноглол;
- 4.5. нисгэгчийн бэлтгэл ба аэродромын талаарх тусгай мэдлэг;
- 4.6. онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан хязгаарлалт, журмууд; болон
- 4.7. 2-р тойрогт гарах шалгуурууд.

Д БҮЛЭГ. ЖИН БА ТӨВЛӨРӨЛТ

121.301. Зорилго

Энэ бүлэгт, онгоцны ачаалал болон жин, төвлөрөлтийн хяналтад тавигдах шаардлагыг тогтооно.

121.303. Зорчигч, тээш болон ачааны жин

(303.а) Энэ зүйлийн (b), (c) болон (d)-д хамааралтайгаар, Гэрчилгээ эзэмшигч нь онгоцоор тээвэрлэх дараах зүйлсийн бодит жинд хяналт тавина:

- 303.a.1) нийт ачааны бодит жин /тээшийг оролцуулахгүйгээр/;
- 303.a.2) нийт зорчигчдын жин болон тэдний гар тээш;
- 303.a.3) нийт нисэх багийн жин болон тэдний гар тээш;болон
- 303.a.4) нийт шалгагдсан тээш.
- (303.b)Нийт зорчигч болон тэдний гар тээшийг зөвхөн дараах нөхцөлүүдийн аль нэгээр тодорхойлно:
- 303.b.1) зорчигч болон түүний гар тээш бүрийн бодит жин; эсвэл
- 303.b.2) гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д заасан, зорчигч болон түүний гар тээш бүрийн стандарт жин; эсвэл
- 303.b.3) дараах жинг зорчигч болон түүний гар тээш бүрийн стандарт жинд тооцож болно:
- 3.1. 2-оос доош насны хүүхдийг -15 кг;
- 3.2. 2-13 насны хүүхдийг - 46 кг;
- 3.3. 13-аас дээш насны хүнийг - 86 кг.
- (303.c)Нийт багийн гишүүд болон тэдний гар тээшийг зөвхөн дараах нөхцөлүүдийн аль нэгээр тодорхойлно:
- 303.c.1) багийн гишүүн болон түүний гар тээш бүрийн бодит жин; эсвэл
- 303.c.2) гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д заасан,багийн гишүүн болон түүний гар тээш бүрийн стандарт жин; эсвэл
- 303.c.3) багийн гишүүн болон түүний гар тээш бүрийн стандарт жинг - 86 кг.
- (303.d)Шалгуулж буй тээшний жинг дараах байдлаар тодорхойлно:
- 303.d.1) тээшний бодит жингээр; эсвэл
- 303.d.2) Монгол Улсаас гадна эхлэлтэй олон улсын нислэгт шалгагдсан ачааны бодит жинг тодорхойлох боломжгүй бол гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д заасан стандарт жингээр.
- (303.e)Энэ зүйлийн (b)-гийн 2/, (c)-гийн 2/ болон (d)-гийн 2/-т заасан гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д заасан стандарт жинг ашиглах бол ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн судалгаанд тулгуурласан байна.
- (303.f) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (b)-гийн 2/, эсвэл (c)-гийн 3/-т заасны дагуу зорчигчдын, (c)-гийн 2/, эсвэл 3/-т заасны дагуу багийн гишүүдийн стандарт жинг ашиглах бол, уг стандарт жинг ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн байхаас гадна, зорчигч болон багийн гишүүд стандарт жингээсээ илүү болох нь тодорхой байвал тухайн бодит жинг авна.

121.305. Онгоцны ачааллын хязгаарлалтууд

Гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг баталгаажуулна:

- 13.а.1) онгоцны нислэгийн ашиглалтын зааварт, эсвэл онгоцны жин ба төвлөрөлтийн бусад бичиг баримтад заасан хязгаарлалтуудыг дагаж мөрдөхийг;
- 13.а.2) онгоцны түлшгүй үеийн (zero fuel), хөөрөлт, буултын болон нислэгийн үеийн хүнд нь зөвшөөрөгдсөн хамгийн их хүндээс хэтрэхгүйг; болон
- 13.а.3) энэ зүйлийн 1/-д заасан хөөрөлтийн өмнөх онгоцны хүндийн төв нь нислэгийн турш тэрхүү хязгаарлалтдаа байна гэдгийг.

121.307. Ачааллын хуудас

Гэрчилгээ эзэмшигч дараах шаардлагуудыг хангана:

- 13.а.1) нислэг бүрийн өмнө ачааллын хуудсыг бүрэн гүйцэд бөглөсөн байх;
- 13.а.2) ачааллын хуудас нь агаарын хөлгийн даргаар хянагдсан байх; болон
- 13.а.3) ачааллын хуудас нь дараах мэдээллийг агуулсан байна:
 - 3.1. агаарын хөлгийн даргын нэр;
 - 3.2. нислэг үйлдэж буй огноо;
 - 3.3. онгоцны маяг, бүртгэлийн дугаар;
 - 3.4. нисэн гарах болон нисэн очих аэродромуудын нэр, эсвэл товчилсон үсгийн код;
 - 3.5. нислэгийн дугаар, эсвэл нисэн гарах тооцоот цаг;
 - 3.6. гэрчилгээ эзэмшигчийн өөр бичиг баримтад заагдаагүй бол, багийн гишүүдийн болон зорчигчдын овог нэр;
 - 3.7. онгоцны хоосон үеийн жин, салгаж авч болох тоног төхөөрөмжүүд, хэрэглээний зүйлс, зарцуулагдах тослогоо болон түлшний жин ба багийн гишүүдийн жин;
 - 3.8. зорчигчид, ачаа, тээш, ашиглагдах тосолгоо болон түлшний жин;
 - 3.9. онгоцны хөөрөлтийн жин;
 - 3.10. гэрчилгээ эзэмшигчийн өөр бичиг баримтад тэмдэглээгүй бол, хүндийн төв нь заагдсан хязгаартаа байхыг үзүүлсэн баталгаа;
 - 3.11. түлшгүй үеийн (zero fuel), хөөрөлтийн болон буултын жинг тусгасан зөвшөөрөгдөх хамгийн их жин; болон
 - 3.12. энэ дүрмийн 121.303 (е)-гийн дагуу хийгдэх жингийн аливаа өөрчлөлт.

Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

121.351. Зорилго

Энэ бүлгээр шаардлагатай хэрэглэл ба тоног төхөөрөмжүүдийг тодорхойлно.

121.353. Ерөнхий зүйл

(353.а) Энэ зүйлийн (б)-д өөрөөр заагаагүй бол, гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагууд хангагдаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагааг эхлүүлж болохгүй:

353.а.1) агаарын хөлөг нь:

- 1.1. энэ бүлэг болон ИНД-91-ээр шаардсан төрөл, маягийн хэрэглэл болон тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх; болон
- 1.2. 2008 оны 7-р сарын 1—ний өдрөөс хойш нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгогдсон, олон улсын тогтмол нислэг үйлдэж агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй агаарын хөлгийн хувьд тус бүр нь ИНД-91-ийн Хавсралт А.15 /ELT/ - т тусгагдсан холбогдох стандартыг хангах 3 ELT – ээр тоноглогдсон байх бөгөөд тэдгээрээс нэг нь ELT(AF) шаардлагыг хангаж байх; болон
- 1.3. холбоо, навигацийн тоноглолуудын тоо нь нислэг дэх тэдгээрийн аливаа дутагдлын үед холбоо, навигацийн аюулгүй ажиллагааг хангахад хүрэлцэхүүц байна.

353.а.2) Агаарын хөлөгт суурилагдсан хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь дараах шаардалгуудад нийцсэн байна

2.1. Дараах НТЧ – ын хийцийн стандарт болон тодорхойлолтуудад:

(353.а.2.1.а) энэ дүрмийн Хавсралт Б;

(353.а.2.1.б) ИНД-21 – ийн Хавсралт В;

(353.а.2.1.с) ИНД-26-д; эсвэл

2.2. ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн нэмэлт тодорхойлолт болон стандарт.

353.а.3) Тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу эсвэл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад зааварчилгааны дагуу суурилагдсан хэрэглэл болон тоног төхөөрөмжүүд; болон

353.а.4) тухайн онгоцонд суурилагдсан, ИНД-91.539-р хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн бага тоноглолын жагсаалтад орсноос бусад хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь ажиллагаатай байх.

(353.б) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд ИНД-91.529 (а)-д заасан автомат ELT-г онгоцондоо суурилуулах шаардлагагүй:

353.б.1) Тухайн агаарын хөлгийн НТЧ – ын гэрчилгээ нь анх 2008 оны 7-р сарын 1-нээс өмнө олгогдсон ; болон

353.б.2) Онгоц нь олон улсын болон орон нутгийн тогтмол нислэг үйлдэж байгаа; болон

353.б.3) ИНД-91.529 (а)-д заасан автомат ELT-ийн оронд ИНД-91-ийн Хавсралт А.15-д заасан ELT-д тавигдах шаардлагыг хангасан хоёр ELT-ээр тоноглогдсон.

121.355. Нэмэлт хэрэглэлүүд

Гэрчилгээ эзэмшигчийн онгоц бүр нь дараах хэрэглэлүүдээр тоноглогдсон байна:

- 13.а.1) ИНД-21-ийн Хавсралт В-д заасан НТЧ-ын хийцийн стандартын дагуу шаардагдах, хөдөлгүүрийн үзүүлэлтүүдийг заах хэрэглэлүүд; болон
- 13.а.2) сэнсний алганы өнцгийн өөрчлөлтөөр ухрах хүч өгөх сэнсний хувьд, өнцөг нь зохих хязгаарт, эсвэл эсрэг алхам дээр байгааг заагч, сэнсний алганы өнцгөөр удирдагдах буюу шууд холбоотой хэрэглэл.

121.357. Нэмэлт тоноглолууд

(357.а) Гэрчилгээ эзэмшигчийн онгоц бүр дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- 357.а.1) нисгэгчийн бүхээгийн шил арчигч төхөөрөмж (нисгэгч бүрийн урд);
- 357.а.2) нисгэгчийн бүхээгийг зорчигчийн бүхээгээс тусгаарласан, аливаа этгээд агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр онгойлгохоос сэргийлэх тусгай түгжээ бүхий хаалга; болон
- 357.а.3) зорчигчийн бүхээгийг нисгэгчийн бүхээгээс бусад бүхээгүүдээс тусгаарлагч хаалга бүр нь аврах гарцтай байвал:
 - 3.1. түлхүүр нь нисэх багийн гишүүд шууд хэрэглэхэд бэлэн байх; болон
 - 3.2. хөөрөлт ба буултын үед зайлшгүй онгорхой байлгахыг сануулсан санамж, тэмдэглэгээтэй байна.

(357.б) Зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- 357.б.1) энэ зүйлийн (а)-гийн 2/-т заасан хаалга нь:
 - 1.1. 2009 оны 5-р сарын 15-наас хүчин төгөлдөр болсон АНУ – ын холбооны дүрмийн эмхэтгэл 14 – ийн §25.795(а)-гийн 1/, 2/ болон 3/-т заасан шаардлагыг хангасан;
 - 1.2. нисгэгчийн аль ч суудлаас онгойлгож, түгжиж болохуйц байх; болон
- 357.б.2) нисгэгчийн бүхээгт орох гэж буй этгээдийг таних эсвэл сэжигтэй нөхцөл байдал эсвэл боломжит аюулыг илрүүлэх зорилгоор нисгэгчийн бүхээгийн гадна талыг хянах зориулалтын тоног төхөөрөмж.

(357.с) N/A

(357.д) Гэрчилгээ эзэмшигч нь, агаарын хөлгийн үйлчлэгч болон нисэх багийн гишүүдийн хооронд харилцах аргачлалыг нь тогтоож өгсөн дохио өгөх эсвэл баталгаажуулах тоноглол нь бүрэн ажиллагаатай гэдгийг бататгана.

121.359. Шөнийн нислэг

Гэрчилгээ эзэмшигчийн шөнийн нислэг үйлдэх онгоц бүр нь дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

13.а.1) онгоцны буултын гэрэл; болон

13.а.2) зорчигчдын тасалгаа бүрийн гэрэл.

121.361. Хэрэглэлийн нислэгийн журам

(361.а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, Гэрчилгээ эзэмшигчийн ХНД-ээр нислэг үйлдэх онгоц бүр дараах тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна:

361.а.1) ИНД-91-ийн Е Бүлгээр шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмжөөс үл хамаарах, дараах нэмэлт тоноглолууд:

1.1. чийг болон мөсдөлтөөс болж ажиллагаагүй болохоос хамгаалагдсан, хэрэглэлийн хурдыг км/ц эсвэл knots - аар илэрхийлэх хэрэглэл;

1.2. Даралтын өндөр /pressure altitude/ – ийг метр эсвэл (ft)-ээр илэрхийлэх өндрийн хэрэглэл; болон

361.а.2) нисгэгчийн бүхээг дэх хэрэглэлүүдийн гэрэлтүүлгийн нөөц ламп;

361.а.3) нөөц гал хамгаалагч.

(361.б) Энэ зүйлийн (а)-гийн 1/-ийн 1.1-ээс үл хамаарах тусдаа тэжээл үүсгэгчтэй нэмэлт авиагоризонтыг суурилуулж болно.

121.363. Усан дээгүүрх нислэг

Гэрчилгээ эзэмшигчийн усан дээгүүр үргэлжилсэн нислэг үйлдэх онгоц бүр, хамгийн их багтаамжтай нэг завь нь ажиллагаагүй болсон тохиолдолд онгоцонд байгаа бүх хүмүүс багтах боломжтой, хөвөх чадвар сайтай аврах завиудаар тоноглогдсон байна.

121.365. Ослын үед хэрэглэх тоног төхөөрөмжүүд

(365.а) Гэрчилгээ эзэмшигч нь онгоц бүрийн хувьд дараах зүйлсийг баталгаажуулна:

365.а.1) ИНД-91.523 (а) болон (b)-д заасан суудлын тоог үл харгалзан, ИНД-91.523-т заасан ослын үед хэрэглэх тоног төхөөрөмжүүдтэй ; болон

365.а.2) энэ зүйлийн (а)-гийн 1/-д заасан шаардлагад ИНД-91.523 (d) болон (д) хамаарна гэдгийг.

(365.б) Нислэгийн 120 минутаас дээш хугацаагаар нислэг үйлдэх онгоц бүр мэргэжлийн хүн ашиглахад тохиромжтой, гэмтэл авсан хүнд туслах болон бусад яаралтай тусламжийн үед ашиглах зориулалт бүхий эмнэлгийн хэрэгслээр тоноглогдсон байна.

121.367. Амьсгал хамгаалах тоног төхөөрөмж

Гэрчилгээ эзэмшигчийн онгоц бүр дараах шаардлагыг хангасан, амьсгал хамгаалах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

13.а.1) нисэх баг болон багийн бусад гишүүн бүр авч ашиглахад хялбар байрлалд байршуулсан; болон

13.а.2) дараах газруудад суурилагдсан:

- 2.1. нисэх багийн бүхээгт; болон
- 2.2. зорчигчдын бүхээг бүрт, зөөврийн галын хорноос 1 метрийн дотор, эсвэл галын хорноос ИНЕГ-ын даргад зөвшөөрөдөх зайд; болон
- 2.3. зөөврийн галын хор байралсан гал тогоонд;

13.а.3) А, В болон Е ангиллын ачааны бүхээг бүрийн гадна талд, багийн гишүүд ашиглахад боломжтой газарт.

121.369. Зарлан мэдээллэх болон багийн гишүүдийн дотоод холбооны систем

Гэрчилгээ эзэмшигчийн онгоц бүр дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

13.а.1) Зарлан мэдээллэх систем; болон

13.а.2) багийн гишүүдийн дотоод холбооны систем.

121.371. Бүхээгийн дуу чимээ бичигч

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгт ашиглах онгоц бүр нисэх багийн бүхээгийн дуу чимээ бичигч төхөөрөмж(CVR)-өөр тоноглогдсон байна.

121.373. Нислэгийн өгөгдөхүүн бичигч

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгт ашиглах онгоц бүр нислэгийн өгөгдөхүүн бичигч төхөөрөмж(FDR)-өөр тоноглогдсон байна.

121.375. Нэмэлт авиагоризонт

Гэрчилгээ эзэмшигчийн нислэгт ашиглаж буй тийрэлтэт (turbofan, turbojet) хөдөлгүүр бүхий онгоц бүр нь гуравдагч буюу нэмэлт авиагоризонтоор тоноглогдсон байна.

121.377. Цаг агаарын радиолокатор

Гэрчилгээ эзэмшигчийн ХНД-ээр нислэг үйлдэх турбинт-хөдөлгүүрт онгоц бүр нь цаг агаарын радиолокатораар тоноглогдсон байна.

121.379. Газартай ойртсоныг анхааруулах систем (GPWS)

(379.а)энэ зүйлийн (b) – д зааснаас бусад тохиолдолд, гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй турбинт-хөдөлгүүрт онгоцнууд нь Газар ойртолтыг анхааруулах систем (GPWS)-ээр тоноглогдсон байна.

(379.б)Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй онгоц нь А ангиллын А ангиллын Гадаргуу ойртсоныг анхааруулах систем /TAWS/ - ээр тоноглолоор тоноглогдсон бол энэ зүйлийн (а)-д заасан шаардлага хамаарахгүй.

121.381. Гадаргуу ойртсоныг анхааруулах систем (TAWS)

(381.а)Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй, 2002 оны 4-р сарын 1-ний өдрөөс хойш үйлдвэрлэгдсэн турбинт- хөдөлгүүрт онгоц бүр А ангиллын Гадаргуу ойртсоныг анхааруулах систем /TAWS/ - ээр тоноглогдсон байна.

(381.b) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй, 2007 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойш үйлдвэрлэгдсэн турбинт хөдөлгүүрт онгоц бүр Б ангилалын Гадаргуу ойртсоныг анхааруулах систем/TAWS/ - ээр тоноглогдсон байна.

121.383. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)

Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй онгоц бүр нь Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)-ээр тоноглогдсон байна.

Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ

121.401. Зорилго

Энэ бүлэгт, Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн онгоцны техник үйлчилгээ /цаашид ТҮ гэх/-нд тавигдах шаардлагыг тогтооно.

121.403. Нислэгт тэнцэх чадварт хүлээх үүрэг хариуцлага

(403.a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийн НТЧ-т хариуцлага хүлээнэ:

403.a.1) гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй онгоц бүрийн хувьд; болон

403.a.2) онгоцонд суурилагдсан, эсвэл бэхлэгдсэн бүх тоног төхөөрөмжийн хувьд.

(403.b) Гэрчилгээ эзэмшигч дараах зүйлсийг бататгана:

403.b.1) гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй онгоц бүрт ИНД-119.63-т заасан ТҮ-ний хөтөлбөрийн дагуу үйлчилгээ хийгдэж байгааг; болон

403.b.2) энэхүү ТҮ-г дараах байгууллага гүйцэтгэнэ гэдгийг:

2.1. ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн ТҮ-ний байгууллага; эсвэл

2.2. Өөр улсад гүйцэтгэх ТҮ-ний хувьд, тухайн ТҮ үзүүлэх байгууллага нь тухайн улсаас гэрчилгээжсэн, эсвэл техникийн зохицуулалтад тодорхойлсон нөхцөлийн дагуу тухайн онгоцны маяг дээр холбогдох ТҮ гүйцэтгэх эрх авсан байна.

121.405. Бодит нөхцөлөөр хянагдах техник үйлчилгээ

ТҮ-ний хөтөлбөртөө бодит нөхцөлөөр хянагдах ТҮ-г ашигладаг гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг багтаасан ТҮ-ний найдвартай ажиллагааны мэдээллийг ИНЕГ-ын даргад сар тутам ирүүлнэ:

13.a.1) агаарын хөлгийн ашиглалтын мэдээлэл; болон

13.a.2) онгоцны НТЧ-тай холбоотой нисгэгчийн мэдээллийн хуудас; болон

13.a.3) техникийн шалтгаанаас саатсан болон цуцлагдсан нислэгийн мэдээлэл; болон

- 13.а.4) хэвийн бус ажиллагаанаас шалтгаалж хөдөлгүүр унтарсан мэдээлэл; болон
- 13.а.5) төлөвлөгөөнөөс гадуур буулгасан хөдөлгүүрийн мэдээлэл; болон
- 13.а.6) эд ангийг төлөвлөгөөнөөс гадуур буулгасан мэдээлэл; болон
- 13.а.7) эд ангийн гэмтэл; болон
- 13.а.8) НТЧ-тай холбоотой зөрчлүүд; болон
- 13.а.9) Хамгийн бага тоноглолын жагсаалт /MEL/ - ын ашиглалтын мэдээлэл.

121.407. EDTO нислэгийн техник үйлчилгээний элементүүд

(407.а) энэ зүйлийн (b), (c), (d) болон (e) хамааралтайгаар, EDTO нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэхүү нислэг үйлдэх онгоцны ИНД-119.63-т заасан техник үйлчилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг багтаасан байна:

- 407.а.1) маягийн загварын (type design) бичиг баримтад болон төлөв байдал, техник үйлчилгээ болон журмын стандарт бичиг баримт (СМР) – д заасан онгоцны их бие болон хөдөлгүүрийн техник үйлчилгээ болон үзлэг шалгалтын шаардлага;
- 407.а.2) EDTO онгоцонд нислэгийн өмнө дараах үзлэг үйлчилгээ хийсэн байна:
 - 2.1. EDTO онгоц болон онцгой системүүдийн нислэгт бэлэн байдлыг тогтоосон байх;
 - 2.2. Үндсэн хөдөлгүүрүүдийн болон (EDTO нислэгэнд туслах хөдөлгүүр (APU) шаардлагатай тохиолдолд) туслах хөдөлгүүрийн тосны хэмжээ заасан хязгаарт байгааг шалгах;
- 407.а.3) техник үйлчилгээний хөтөлбөрт заасан EDTO онгоцны онцгой системүүдийн техник үйлчилгээний ажлын хуваарь;
- 407.а.4) EDTO онгоцны онцгой системийн техник үйлчилгээ гүйцэтгэх журам;
- 407.а.5) ижил системүүдэд техник үйлчилгээ гүйцэтгэх журам;
- 407.а.6) хөдөлгүүрийн бодит байдлыг хянах хөтөлбөр (ЕСМР);
- 407.а.7) хөдөлгүүр, АPU бүрийн (EDTO нислэгэнд туслах хөдөлгүүр шаардлагатай тохиолдолд) тосны зарцуулалтын хяналтын хөтөлбөр. Энэхүү хөтөлбөр нь хөдөлгүүр, эсвэл АPU-д нэмж буй тосны хэмжээ, үйлдвэрлэгчийн гаргасан зөвлөмжөөс хэтэрсэн бол сэрэмжлүүлэх журмыг багтаасан байх;
- 407.а.8) EDTO нислэгийн явцад АPU асаах шаардлагатай бол, нислэгийн явцад хүйтэн үеийн (cold soak) асаалт, ажиллах явцын найдвартай ажиллагааг хянах хөтөлбөр;
- 407.а.9) EDTO онгоцны онцгой системийн жагсаалт;
- 407.а.10) эд ангийн хяналтын хөтөлбөр нь дараах зүйлсийг бататгана:
 - 10.1. онгоц маягийн гэрчилгээний стандарт шаардлагын хангалтыг хадгалаж байгаа,

10.2. EDTO зөвшөөрөгдсөн онгоцны их бие, хөдөлгүүрт тавигдсан эд ангиудыг зөв таних.

(407.b) EDTO онгоцны онцгой системийн энэ зүйлийн (a)-ийн 3/-т заасан ижил системд хийх техник үйлчилгээ нь бусад хуваарьт техник үйлчилгээний хуваарьтай дараах тохиолдолд давхцаж болохгүй:

407.b.1) зайлшгүй шаардлагатай тохиолдолд; эсвэл

407.b.2) энэ зүйлийн (a)-ийн 2/-т заасан EDTO нислэгийн өмнөх техник үйлчилгээний үзлэг шалгалт хийх шаардлагатай тохиолдолд.

(407.c) Энэ зүйлийн (a)-ийн 4/-т заасан EDTO нислэгийн онцгой системийн техник үйлчилгээ гүйцэтгэх журмууд нь дараах зүйлсийг багтаана:

407.c.1) EDTO нислэгийн онцгой системийн техник үйлчилгээ хийсний дараа тухайн онгоц EDTO нислэг үйлдэх боломжтойг баталгаажуулсан;

407.c.2) энэ хэсгийн 1/-д заасан шаардлага газарт хийгдэх боломжгүй тохиолдолд EDTO шалгах нислэг үйлдэнэ.

(407.d) EDTO онгоцны ижил системүүдэд хийх техник үйлчилгээг энэ зүйлийн (a)-ийн 5/-д заасан ижил системүүдэд техник үйлчилгээ хийх журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

(407.e) Энэ зүйлийн (a)-ийн 5/-д заасан ижил системийн техник үйлчилгээний журам нь дараах зүйлсийг багтаасан байна:

407.e.1) EDTO онгоцны онцгой системийн техник үйлчилгээ гүйцэтгэх эрх бүхий этгээдтэйг;

407.e.2) энэ зүйлийн (e)-ийн 1/-д заасан этгээдийн гүйцэтгэсэн техник үйлчилгээний ажлыг зохих эрх бүхий өөр этгээд шалгах;

407.e.3) техник үйлчилгээг гүйцэтгэсний дараа:

3.1. системүүдийг техник үйлчилгээний ба техникийн өөрчлөлт, сайжруулалт хийсэн зааврын дагуу шалгах;

3.2. тухайн онгоц EDTO нислэг үйлдэх чадвартайг бататгасан шалгалтыг газарт хийх талаар; болон

3.3. EDTO нислэг гүйцэтгэх чадвартайг энэ хэсгийн 3.2-т заасан газрын шалгалтаар тогтоогогүй тохиолдолд EDTO шалгах нислэг үйлдэх талаар.

121.409. Нөөц

121.411. Нөөц

121.413. Нөөц

121.415. Техник үйлчилгээний шалгалт

(13.a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг бататгана:

13.a.1) Өмнөх 12 сарын хугацаанд ТҮ-ний гүйцэтгэлийг нь шалгаагүй бол тухайн онгоцоор гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулахгүй; болон

13.a.2) ТҮ-ний шалгалт бүрийг энэ зүйлийн (г)-д заасны дагуу гэрчилгээжүүлнэ.

(13.b) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь сүүлд хийгдсэн ТҮ –ний шалгалтаас хойш дараах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд онгоцны ТҮ-ний шалгалтыг гэрчилгээжүүлэхгүй:

13.b.1) тухайн онгоцны холбогдох ТҮ-ний хөтөлбөр заагдсан техникийн үзлэг, үйлчилгээнүүд заагдсан цаг хугацаандаа хийгдсэн; болон

13.b.2) НТЧ-ын бүх удирдамжууд /AD/-ыг ИНД-39-д заасан шаардлагуудын дагуу хангасан; болон

13.b.3) ТҮ-ний бичиг баримтад хөтлөгдсөн бүх дутагдлуудыг гэрчилгээ эзэмшигчийн зааврын дагуу засаж залруулсан, эсвэл хойшлуулсан; болон

13.b.4) ТҮ-нээс гаргах бүх ажиллагаа ИНД-43-ын В бүлгийн дагуу хийгдсэн.

(13.c) Дараах нөхцлүүдэд гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөрийн байнгын мөрдөлтөд үндэслэн ТҮ-ний гүйцэтгэлийн шалгалтыг гэрчилгээжүүлж болно:

13.c.1) шалгалтын явцад энэ зүйлийн (b)-д заагдсан бүх шаардлагуудыг хөтөлбөрт ашигласан байх; болон

13.c.2) ТҮ-ний гүйцэтгэлийн шалгалт нь онгоц бүрийн хувьд гэрчилгээжүүлсэн байх.

(13.d) Гэрчилгээ эзэмшигчийн ТҮ-ний гүйцэтгэлийн шалгалтыг явуулах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

13.d.1) Гэрчилгээ эзэмшигчээс зөвшөөрөгдсөн, дор хаяж тухайн онгоцны маягийн техник үйлчилгээний инженерийн гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг хангахуйц дадлага туршалагтай; болон

13.d.2) энэ зүйлийн (b), эсвэл (с)-гийн аль зохих шаардлагын дагуу шалгалтыг зохион байгуулах; болон

13.d.3) техник үйлчилгээний бүртгэлийн дэвтэрт дараах тайлбарыг гарын үсэг, зөвшөөрлийн дугаар болон бүртгэлийн огнооны хамт оруулснаар тухайн ТҮ-ний шалгалт баталгаажих болно:

НТЧ-ыг хадгалах зайлшгүй шаардлагын үүднээс, энэхүү онгоцонд болон түүний тоног төхөөрөмжид хийгдсэн ТҮ-ний гүйцэтгэлийн шалгалт нь, ИНД-121.415-ын шаардлагын дагуу гүйцэтгэгдсэн болно.

121.417. EDTO нислэгийн улирал тутмын тайлан

EDTO нислэг үйлдэх эрхтэй гэрчилгээ эзэмшигч нь дараа улирлын 21 дэх өдрөөс өмнө ИНЕГ-ын даргад дараах зүйлсийг багтаасан өмнөх 3 сарын тайланг ирүүлнэ:

- 417.a.1) EDTO нислэгт ашиглахаар зөвшөөрөгдсөн онгоцны ашиглалт болон үйл ажиллагаа бүрийн талаар;
- 417.a.2) EDTO нислэгэнд ашиглаж буй онгоцны хөдөлгүүр бүрийн ашиглалт болон үйл ажиллагааны талаар;
- 417.a.3) техникийн шалтгааны улмаас цуцлагдсан, хойшилсон эсвэл саатсан EDTO нислэг бүрийн талаар;
- 417.a.4) бодит эсвэл сэжиглэгдсэн техникийн доголдлоос шалтгаалсан EDTO маршрутаас хазайсан, эсвэл цуцалсан тохиолдол бүрийн талаар;
- 417.a.5) нислэгт хөдөлгүүр татгалзсан /IFSD/ тохиолдлууд болон тохиолдлуудын өсөлт, бууралтын талаар;
- 417.a.6) хөдөлгүүр удирдах боломжгүй эсвэл хүссэн чадал гаргахгүй байсан тохиолдол бүрийн талаар;
- 417.a.7) урьдчилан сэргийлэх үүднээс хөдөлгүүрийн зүтгэх хүч(thrust)-ыг багасгасан тохиолдол бүрийн талаар (онгоцны ашиглалтын зааварт зөвшөөрөгдсөн алдааг тодорхойлох үйл ажиллагаанаас бусад тохиолдолд);
- 417.a.8) хөдөлгүүрийг нислэгийн үед асаах боломж буурсан тохиолдол бүрийн талаар;
- 417.a.9) ИНД-12-т заасны дагуу 72 цагийн дотор эрх бүхий байгууллагад мэдээлэх шаардлагатай, EDTO нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн онгоцтой холбоотой зөрчил бүрийн талаар;
- 417.a.10) EDTO онгоцны системийн ноцтой дутагдлуудын тоо гэрчилгээ эзэмшигчээс тогтоосон анхааруулах түвшинээс хэтэрсэн тохиолдолд, системийн дутагдлын нэгдсэн тайлан;
- 417.a.11) EDTO онцгой систем дээр MEL нээсэн тухай мэдээлэл;
- 417.a.12) EDTO онцгой системийн эд ангийг буулгасан хуваарьт бус техник үйлчилгээний талаар;

3 БҮЛЭГ. БАГИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

121.501. Зорилго

Энэ бүлэгт, Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцогч багийн гишүүдийг томилох шаардлагыг тогтооно.

121.503. Багийн гишүүдийг томилох

(503.a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй багийн гишүүн бүрийн аюулгүй ажиллагааны болон үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг онгоцны маяг тус бүрийн хувьд бичгээр тодорхойлсон байна.

(503.b) Гэрчилгээ эзэмшигч нь, дараах шаардлагыг хангаагүй этгээдийг гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах онгоцны багийн гишүүнээр томилж болохгүй:

- 503.b.1) энэ дүрмийн И бүлэгт заасан холбогдох сургалтын хөтөлбөрийг гүйцэтгэж, К бүлэгт заасны дагуу багийн гишүүний байрлалдаа ур чадвараа дүгнүүлсэн байх; эсвэл
- 503.b.2) Энэ дүрмийн 121.567-ын дагуу шугамын дадлага, эсвэл 121.569-ын дагуу нисгэгчийн зөөлтийн дараах сургалт хийж, нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа нисгэгчийн хувьд:
- 2.1. энэ дүрмийн И бүлэгт заасан сургалтын хөтөлбөрийн зохих үе шатуудыг гүйцэтгэсэн байх; болон
- 2.2. энэ дүрмийн К бүлэгт заасан нисэх багийн байрлалаас ур чадвараа дүгнүүлсэн байх; эсвэл
- 2.3. энэ дүрмийн Н бүлэгт заасан мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдаж ур чадвараа дүгнүүлсэн байх.
- (503.c) Гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн онцгой үе шатанд онгоцны аюулгүй ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад аливаа ажил үүрэг гүйцэтгэхийг багийн гишүүдээс шаардахгүй.
- (503.d) Энэ зүйлийн (c)-д заасан нислэгийн онцгой үе шат гэдэгт:
- 503.d.1) нисэх багийн гишүүдийн хувьд, чиг шулуун нислэгээс бусад, онгоцыг чирэх, явгалах, хөөрөх болон ойртолт буултын үеийн үйл ажиллагаа болон газраас дээш 3000 метр (10000 ft)-ээс доош өндөр дэх нислэгийн үйл ажиллагааг; болон
- 503.d.2) АХУ нарын хувьд, агаарын хөлгийн зогсоолоос үндсэн явгалах замруу орохоос эхлэн хөөрч газраас дээш 300 метр (1000 ft) хүртэл болон газраас дээш 1500 метр (5000 ft)-ээс доош өндөр алдахаас эхлэн ойртолт, буулт үйлдэх үе шатыг хамааруулна.

121.505. Нисэх багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалт

- (505.a) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээгээр олгогдох эрхийн хүрээнд гүйцэтгэх агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй дараах мэргэжлийн хүмүүсийг бичгээр томилно:
- 505.a.1) энэ дүрмийн 121.507-д заасан шаардлагыг хангасан нисгэгчийг агаарын хөлгийн даргаар; болон
- 505.a.2) энэ дүрмийн 121.507, эсвэл 121.509-д заасан шаардлагыг хангасан, тухайн онгоцны ашиглалтын зааварт шаардсан нэмэлт нисгэгчийг; болон
- 505.a.3) агаарын хөлгийн даргаар мэргэшсэн эсвэл (a) 2/ - ийн дагуу шаардагдах нэмэлт нисгэгчээр мэргэшсэн, тухайн үйл ажиллагааны онцлогоос хамаарч агаарын хөлгийн нислэгийн зааварт шаардсанаас нэмэлтээр шаардагдах бусад нисгэгч; болон
- 505.a.4) үйл ажиллагааны төрлөөс хамаарч, шаардлагатай бол дараах мэргэжлийн хүмүүсийг:

- 4.1. энэ дүрмийн 121.513-т заасан шаардлагыг хангасан нисэх инженер; эсвэл
- 4.2. энэ дүрмийн 121.511-ийн шаардлагыг хангасан чиг шулуун нислэгийн орлон нисгэгч (relief pilot); эсвэл
- 4.3. нисэх инженер болон чиг шулуун нислэгийн орлон нисгэгчийн аль алиныг.

(505.b) Хэрэв энэ зүйлийн (а)-гийн 1/, 2/ болон 3/-р шаардсан нисгэгчийн тоо нь 2-оос илүү бол гэрчилгээ эзэмшигч нь, томилогдсон агаарын хөлгийн дарга үүргээ гүйцэтгэх чадваргүй (incapacity) болсон тохиолдолд энэ зүйлийн (а)-гийн 2/, эсвэл 3/-т заасан нисгэгчийн аль нь агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг бичгээр тодорхойлно.

121.507. Агаарын хөлгийн даргын дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилохгүй:

- 13.a.1) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчин төгөлдөр агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй (онгоц) байх; болон
- 13.a.2) хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байх; болон
- 13.a.3) энэ дүрмийн “И” болон “К” бүлэгт заасан сургалт, шалгалтыг амжилттай давсан, эсвэл “Н” бүлэгт заасан мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдаж дүгнүүлсэн байх; болон
- 13.a.4) доорх шаардлагуудыг багтаасан 1500-аас доошгүй нислэгийн цагтай байх:
 - 4.1. энэ дүрэмд хамаарах үйл ажиллагааны, эсвэл үүнтэй дүйцэхүйц ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагааны төрлөөр 500 цаг ниссэн; болон
 - 4.2. 100 цагийн хэрэглэлийн нислэг үйлдсэн ба үүнээс 50-иас доошгүй цагийг нь бодит нислэгт үйлдсэн; болон
- 13.a.5) 100 цагаас доошгүй шөнийн нислэг үйлдсэн дадлага туршлагатай байх.

121.509. Хамтран нисгэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг хамтран нисгэгчээр томилохгүй:

- 13.a.1) Дор хаяж тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчин төгөлдөр коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (онгоц) байх;
- 13.a.2) хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байх;
- 13.a.3) дараах шаардлагуудыг хангасан байна:

- 3.1. энэ дүрмийн “И” болон “К” бүлэгт заасан сургалт, ур чадварыг амжилттай дүгнүүлж, хамрагдсан, эсвэл “Н” бүлэгт заасан мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдаж дүгнүүлсэн байх; эсвэл
- 3.2. энэ дүрмийн “И” бүлэгт шаардсан сургалтын хөтөлбөрийн холбогдох зэрэг ахиулах (upgrade), шилжин сургалт (transition), танилцуулах (introduction) сургалтуудыг амжилттай дүүргэж, “К” бүлэгт заасны дагуу нисэх багийн суудлаасаа ур чадвараа амжилттай дүгнүүлж, энэ дүрмийн 121.567, эсвэл 121.569-д заасан шугамын нислэгийн дадлага авсан, эсвэл нисгэгчийн зөөлтийн нислэгт хамрагдсан байх.

13.а.4) агаарын хөлгийн дарга үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд дараах чадвартай байна:

- 4.1. урьдчилан авсан болон бодит цаг агаарын нөхцөлд нислэгээ аюулгүй гүйцэтгэх; болон
- 4.2. агаарын хөлгийн даргын үүргийг гүйцэтгэх; болон
- 4.3. нисэн очих болон боломжит нөөц аэродромд онгоцыг буулгах ур чадвартай.

121.511. Чиг шулуун нислэгийн орлон нисгэгч (Cruise relief pilot)-ийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг чиг шулуун нислэгийн орлон нисгэгчээр томилохгүй:

- 13.а.1) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчин төгөлдөр коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (онгоц) байх;
- 13.а.2) хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байх;
- 13.а.3) энэ дүрмийн “И” болон “К” бүлэгт заасан сургалт, ур чадварыг амжилттай дүгнүүлж, хамрагдсан байх; болон
- 13.а.4) энэ дүрмийн 121.533 (b)-д заасны дагуу чиг шулуун нислэгийн үед дор дурдсаннөхцлүүдэд онгоцыг аюулгүй нисгэх чадвартай байх:
 - 4.1. агаарын хөлгийн дарга үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд хамтран нисгэгчийг нисгэгчийн бүхээгт орж ирэх хүртэл; эсвэл
 - 4.2. хамтран нисгэгч үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд агаарын хөлгийн даргыг нисгэгчийн бүхээгт орж ирэх хүртэл.

121.513. Нисэх инженерийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараах шаардлагыг хангаагүй этгээдийг нисэх инженерээр томилохгүй:

- 13.а.1) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчин төгөлдөр нисэх инженерийн үнэмлэхтэй бөгөөд энэ дүрмийн “И”, “К” бүлэгт заасан сургалт болон ур чадварыг амжилттай дүгнүүлж, хамрагдсан байх; эсвэл

- 13.а.2) хүчин төгөлдөр сурагч-нисэх инженерийн үнэмлэхтэй бөгөөд тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчин төгөлдөр үнэмлэхтэй, энэ дүрмийн “И”, “К” бүлэгт заасан сургалт болон ур чадварыг амжилттай дүгнүүлж, хамрагдсан багш-нисэх инженерийн шууд зааварчилга дор ажиллах бол.

121.515. Агаарын хөлгийн үйлчлэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцох агаарын хөлгийн үйлчлэгч (цаашид АХҮ гэх) нь тухайн маягийн онгоц болон тухайн багийн гишүүний ажлын байрны хувьд энэ дүрмийн 121.553-г шаардсан багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн холбогдох үе шатуудад амжилттай хамрагдсан байна.

121.517. Шугамын хянан нисгэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараах шаардлагыг хангаагүй этгээдийг шугамын нислэгт хяналт тавих нисгэгчээр томилохгүй:

- 517.а.1) тухайн маягийн онгоцны агаарын хөлгийн даргаар нисэх эрхтэй;
- 517.а.2) ИНД-61-ийн дагуу олгогдсон “D” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй, эсвэл агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлтэй;
- 517.а.3) доорх цагийг багтаасан 2000-аас доошгүй нислэгийн цагтай:
- 3.1. тухайн маягийн онгоцонд 200 цагийн шугамын нислэгийн дадлага туршлагатай; эсвэл
- 3.2. энэ дүрмийн “И”, эсвэл “Н” бүлэгт заасны дагуу агаарын тээврийн үйл ажиллагаанд өөр маягийн онгоцонд, зөөлтийн нислэгт хяналт тавьж байсан, ИНД-61-ийн дагуу олгогдсон агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлийн эрхийг эдэлсэн 100 цагтай, болон
- 517.а.4) хүний хүчин зүйл болон нисэх багийн нөөцийн менежмент (CRM)-ийг багтаасан агаарын хөлгийн техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх аргачлалын сургалтад хамрагдсан.

121.519. Багш нисгэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг энэ дүрмээр шаардсан нисэх багийн сургалтын хөтөлбөрт заасан багш нисгэгчийн үүрэгт томилохгүй:

- 13.а.1) тухайн маягийн онгоцны даргаар нисэх эрхтэй байх; болон
- 13.а.2) ИНД-61-ийн дагуу олгогдсон “D” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй, эсвэл агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлтэй байх;
- 13.а.3) доорх цагийг багтаасан 3000-аас доошгүй нисгэгчээр ажилласан нислэгийн цагтай байх:
- 3.1. тухайн маягийн онгоцонд 500 цагийн шугамын нислэгийн дадлага туршлагатай; эсвэл

3.2. ИНД-61-ийн дагуу олгогдсон “D” ангиллын багш нисгэгчийн зэрэглэл эсвэл агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлийн эрхийг эдэлж өөр маягийн онгоцонд 100 цаг энэ дүрмийн “И”, эсвэл “Н” бүлэгт заасны дагуу багшилж байсан; болон

13.а.4) хүний хүчин зүйл болон нисэх багийн нөөцийн менежмент (CRM)-ийг багтаасан агаарын хөлгийн техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх аргачлалын сургалтад хамрагдсан.

121.521. Шалгах нисгэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг энэ дүрмийн 121.567 (е)-ийн 3/, 121.569 (а)-гийн 3/-т заасан нислэгийн шалгалт, эсвэл энэ дүрмийн “К” бүлэгт шаардсан ур чадварыг үнэлэх хөтөлбөрт шалгах нисгэгчийн үүрэгт томилохгүй:

13.а.1) ИНД-61-ийн дагуу олгогдсон агаарын тээвэрлэгчийн шалгах нисгэгчийн зэрэглэлтэй байх; болон

13.а.2) тухайн маягийн онгоцны даргаар нисэх эрхтэй байх; болон

13.а.3) нисгэгч нь:

3.1. ИНД-61-ийн дагуу олгогдсон тухайн маягийн онгоцны агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлтэй, эсвэл “D” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлийн эрхийг эдэлсэн нислэгийн 200 цагтай; эсвэл

3.2. энэ дүрмээр зохицуулагдаж буй онгоцонд, ИНД-61-ийн дагуу олгогдсон агаарын тээвэрлэгчийн шалгах нисгэгчийн зэрэглэлийн эрхийг эдэлсэн нислэгийн 100 цагтай; эсвэл

3.3. ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх, энэ дүрэм эсвэл ИНД-125 - аар зохицуулагдах маягийн онгоцны бусад дадлага туршлагатай; болон

13.а.4) хүний хүчин зүйл болон нисэх багийн нөөцийн менежмент (CRM)-ийг багтаасан нисэх багийн үйл ажиллагааны техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх аргачлалын сургалтад хамрагдсан.

121.523. Дадлагажуурын багш болон шалгагчийн дадлага туршлага

(523.а) Энэ зүйлийн (b), (c)-д зааснаас бусад тохиолдолд, гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн дадлагажуурт нислэгийн зааварчилгаа өгөх, эсвэл нисэх багийн ур чадварыг үнэлэх зорилгоор дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийг багш, эсвэл шалгах нисгэгчээр томилохгүй:

523.а.1) энэ дүрмийн 121.519, эсвэл 121.521-д заасан холбогдох шаардлагыг хангасан; болон

523.а.2) энэ дүрмийн “К” бүлэгт шаардсан стандартын дагуу нислэгийн дадлагажуурт агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх ур чадвараа харуулсан;

523.а.3) нислэгийн дадлагажуурын үйл ажиллагааны сургалтад хамрагдсан; болон

- 523.a.4) хүний хүчин зүйл, нисэх багийн нөөцийн менежмент (CRM)-ийг багтаасан нисэх багийн үйл ажиллагааны техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх аргачлалын сургалтад хамрагдсан.
- (523.b) Энэ зүйлийн (a)-д заасан шаардлагуудыг хангаж байгаа боловч эрүүл мэндийн гэрчилгээ нь хүчингүй болсон этгээд хэрэв дараах ур чадвараа хадгалж байгаа бол нислэгийн дадлагажуурын багш нисгэгч, эсвэл шалгах нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно:
- 523.b.1) энэ дүрмийн 121.553-д заасан сургалтын хөтөлбөрийн дагуу нислэгийн дадлагажуурт нисэх багийн гишүүний хувиар сургалтад хамрагдсан; болон
- 523.b.2) “К” бүлгийн дагуу ур чадвараа үнэлүүлсэн; болон
- 523.b.3) энэ дүрмийн болон ИНД-61-ийн шалгах нисгэгчийн зэрэглэл, эсвэл агаарын тээвэрлэгчийн багш нисгэгчийн зэрэглэлийн ур чадварын хадгалалтад тавигдах шаардлагаас бусад, холбогдох сургалтуудад хамрагдсан бол.
- (523.c) Энэ зүйлийн (a)-д зааснаас гадна, гэрчилгээ эзэмшигч эрүүл мэндийн гэрчилгээ нь хүчингүй, энэ дүрмийн 121.519, эсвэл 121.521-д заасан шаардлагыг хангаагүй боловч дараах шаардлагыг хангасан этгээдийг нислэгийн дадлагажуурын багш, эсвэл шалгах нисгэгчээр ажиллуулах хүсэлтийг ИНЕГ-ын даргад бичгээр гаргасан тохиолдолд ИНЕГ-ын дарга зөвшөөрч болно:
- 523.c.1) агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцсон 5000-аас доошгүй цагийн нислэгийн дадлага туршлагатай; болон
- 523.c.2) тухайн онгоцны маягийн нислэгийн дадлагажуур дээр энэ дүрмийн “И” болон “К” бүлэгт шаардсан сургалтад хамрагдаж, ур чадвараа шалгуулсан; болон
- 523.c.3) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх нислэгийн зааварчилгаа өгөх, эсвэл нислэгийн шалгалт авах сургалтад амжилттай хамрагдсан; болон
- 523.c.4) нислэгийн дадлагажуурын үйл ажиллагааны сургалтад хамрагдсан; болон
- 523.c.5) энэ зүйлийн (b)-д заасан ур чадварыг үргэлжлүүлэн хадгалж байгаа бол.

121.525. Багш үйлчлэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй АХҮ-ийг энэ дүрмээр шаардсан нисэх багийн сургалтын хөтөлбөрт багш үйлчлэгчээр томилохгүй:

- 13.a.1) энэ дүрмийн 121.553-т заасан нисэх багийн сургалтын хөтөлбөрийн холбогдох үе шатуудыг амжилттай дүүргэсэн; болон
- 13.a.2) хүний хүчин зүйл болон нисэх багийн нөөцийн менежмент (CRM)-ийг багтаасан нисэх багийн техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх аргачлалын сургалтад хамрагдсан.

121.527. Шалгах үйлчлэгчийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй АХҮ-ийг энэ дүрмийн 121.611-д заасан шалгах үйлчлэгчээр томилохгүй:

13.а.1) энэ дүрмийн 121.525-д заасан холбогдох сургалт болон сургалтын хэсэгт амжилттай хамрагдсан ; болон

13.а.2) энэ дүрмийн 121.575-д заасны дагуу мэргэшсэн.

121.529. Онолын багшийн дадлага туршлага

Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй этгээдийг энэ дүрмийн 121.553-т шаардсан нисэх багийн сургалтын хөтөлбөрт онолын багшаар томилохгүй:

13.а.1) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх багшлах арга зүйн курс; болон

13.а.2) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх хүний хүчин зүйлийн курс; болон

13.а.3) тухайн зааж буй хичээлийн хувьд гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдсан.

121.531. Нисэх баг бүрдүүлэлтийн хязгаарлалт

(531.а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, гэрчилгээ эзэмшигч нь, дор хаяж нисэх багийн нэг гишүүн нь энэ дүрмийн “И” бүлэгт заасан сургалт болон нисгэгчийн зөөлтийн нислэгийг гүйцэтгэснээс хойш, доорх нислэгийн цагийн туршлагыг хуримтлуулаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагааг эхүүлэхгүй:

531.а.1) тухайн онгоцны маяг дээр 75-аас доошгүй цагийн нислэг үйлдсэн; эсвэл

531.а.2) тухайн онгоцны маяг дээр 75-аас доошгүй нислэг (цикл)- ийг үйлдсэн.

(531.б) Гэрчилгээ эзэмшигч ИНЕГ-ын даргад бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд, ИНЕГ – ын дарга дараах нөхцлүүдэд гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод холбогдох нэмэлтийг оруулснаар энэ зүйлийн (а)-д зааснаас гажиж зөвшөөрөл олгож болно:

531.б.1) шинээр гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (а)-д заасан шаардлагыг хангах боломжгүй бол;

531.б.2) гэрчилгээ эзэмшигч өмнө нь үйл ажиллагаандаа тухайн маягийн онгоцыг ашиглах зөвшөөрөл ИНЕГ – ын даргаас авч байгаагүй бол.

(531.с) Нисэх багийн гишүүн энэ дүрмийн “Н” бүлэгт заасны дагуу мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрт хамрагдаж байвал энэ зүйлийн (а)-д заасан нислэгийн цаг мөн хамаарна.

121.533. Нисгэгчийн үйл ажиллагааны хязгаарлалтууд

(533.а) Хөөрөлт, буулт гүйцэтгэх идэвхтэй нисгэгч нь:

533.а.1) агаарын хөлгийн дарга; эсвэл

- 533.a.2) энэ зүйлийн (с)-г харгалзан, агаарын хөлгийн даргаас бусад нисгэгч гэдгийг Гэрчилгээ эзэмшигч баталгаажуулна.
- (533.b) Гэрчилгээ эзэмшигч, энэ дүрмийн 121.505 (а)-гийн 4/-т заасан чиг шулуун нислэгийн орлон нисгэгчийг томилж байгаа бол, орлон нисгэгч нь дараах тохиолдолд нисгэгчийн суудал дээр суухгүйг баталгаажуулна:
- 533.b.1) тухайн онгоц нислэгийн цуваа FL200-аас доош, эсвэл шилжих цуваачлал (TL)–аас доош нислэг үйлдэх бол, дээрх хоёр өндрийн аль ихийг нь авна; эсвэл
- 533.b.2) дараах нисэх багийн гишүүн нисгэгчийн суудалд байхаас бусад үед:
- 2.1. агаарын хөлгийн дарга; эсвэл
- 2.2. агаарын хөлгийн дарга томилсон, мөн чиг шулуун нислэгийн орлон нисгэгчийг хянах гэрчилгээ эзэмшигчийн тодорхойлсон чиг шулуун нислэгийн агаарын хөлгийн дарга.
- (533.c) Гэрчилгээ эзэмшигч, агаарын хөлгийн даргаас бусад нисгэгч идэвхитэй нисгэгчээр хөөрөлт, буулт үйлдэхэд зориулсан дараах зүйлсийг баталгаажуулсан журамтай байна:
- 533.c.1) хөөрөлт, буултыг бие даан гүйцэтгэх ур чадвартай; болон
- 533.c.2) агаарын хөлгийн даргын хяналтанд байгааг.
- (533.d) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь эрсдлийн менежментийн бодлогод тулгуурлан дараах хүчин зүйлсийг тооцсон байна:
- 533.d.1) онгоцны даргын мэргэшил (qualifications);
- 533.d.2) нисгэгчийн дадлага туршлага болон сургалт;
- 533.d.3) агаарын хөлгийн үзүүлэлт болон төлөв;
- 533.d.4) ХБЗ-ны нөхцөл байдал болон хэмжээс (dimensions);
- 533.d.5) үүлний суурийн өндөр;
- 533.d.6) зонхилох алсын барааны харагдац;
- 533.d.7) хөндлөнгийн салхины бүрэлдэхүүн.

121.535. Нэгээс дээш маяг эсвэл вариант (variant)-ын онгоцоор нисэх баг

- (535.a) Гэрчилгээ эзэмшигч, нэгээс дээш онгоцны маяг, эсвэл вариант дээр нисэх багийн гишүүнийг томилох бол дараах шаардлагыг хангасан байна:
- 535.a.1) Нисэх багийн гишүүн нь тухайн онгоцны маяг болон вариант тус бүр дээр нисэх сургалтад хамрагдаж, мэргэшсэн; болон
- 535.a.2) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх, сургалтын болон ур чадварын үнэлгээний журамтай байна.

- (535.b) Энэ зүйлийн (а)-гийн 2/-т заасан журам нь дараах шаардлагыг хангасан байна:

- 535.b.1) нэгээс дээш онгоцны маяг, эсвэл вариант дээр томилогдох нисэх багийн гишүүн нь сургалт эхлэхээс өмнө тухайн маяг, эсвэл вариантын онгоцууд дээр нисэхэд шаардагдах хангалттай дадлага туршлагатай байх (Үйлдвэрлэгчээс гаргасан дадалага, туршалагын зөвлөмжийг харгалзан үзнэ);
- 535.b.2) нэгээс дээш онгоцны маяг, эсвэл вариант дээр нисэх багийн гишүүн нь аль нэг онгоцны сургалтыг эхлэхээс өмнө нөгөө онгоцон дээр үйлдвэрлэгчийн зөвлөмжийг харгалзан үзсэн хангалттай дадлага туршлагатай байх;
- 535.b.3) нэг онгоцны маяг, эсвэл вариант дээр мэргэшсэн нисэх багийн гишүүн нь өөр онгоцны маяг, эсвэл вариант дээр сургалтад хамрагдаж, мэргэшсэн байх; болон
- 535.b.4) нисэх багийн гишүүн нь:
- 4.1. тухайн онгоцны маяг, эсвэл вариант бүрд холбогдох нислэгийн ур чадвар болон дадлага туршлагын шаардлагыг хангасан; эсвэл
 - 4.2. заагдсан онгоцны маяг, эсвэл вариантын ур чадварын стандартыг хангах өөр онгоцны маяг, эсвэл вариант дээр ур чадвараа амжилттай дүгнүүлсэн байх; болон
 - 4.3. энэ хэсгийн 4.2 -т заагдсан онгоцны маяг эсвэл вариант нь үйлдвэрлэгчийн зөвлөмжид тодорхой заагдсан байх ёстой.
- (535.c) Энэ зүйлийн (b)-гийн 1/-д заасан дадлага туршлага гэдэгт энэ дүрмээр зохицуулагдаж буй агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх хамгийн бага нислэгийн цагийн дадлага туршлага болон циклийг хангасан байхыг ойлгоно.
- (535.d) Энэ зүйлийн (b)-гийн 2/-г заасан дадлага туршлага нь дараах зүйлсийг багтаасан байна:
- 535.d.1) одоо нисэж буй онгоцон дээрээ энэ дүрмээр зохицуулагдаж буй хамгийн бага нислэгийн цагийн дадлага туршлага, эсвэл циклийг хангасан; болон
- 535.d.2) нисэх багийн гишүүн нь шинэ онгоцны маяг, эсвэл вариант дээр сургалт эхэлсний дараа, өмнө нь нисэж байсан онгоцны дадлага туршлагыг үл харгалзан шинэ онгоцон дээр минимум нислэгийн цагийг гүйцэтгэнэ.
- (535.e) Энэ зүйлийн (a)-гийн 2/-г заасан нэгээс дээш онгоцны маяг эсвэл ижил шинж чанар (characteristic)-тай өөр маягийн онгоцоор нисэх багт шаардагдах сургалт болон ур чадварыг дүгнэх журам нь дараах зүйлсийг харгалзан үзсэн байна:
- 535.e.1) тухайн онгоцны үйл ажиллагааны журам; болон
- 535.e.2) тухайн онгоцны системүүд; болон
- 535.e.3) тухайн онгоцны үзүүлэлтийн хязгаарлалтууд; болон
- 535.e.4) тухайн онгоцны удирдлагын шинж чанарууд (handling characteristics).
- (535.f) ИНД-61.37-г үл харгалзан, Гэрчилгээ эзэмшигч нь, нэгээс дээш онгоцны маяг, эсвэл вариант дээр томилогдох чиг шулуун нислэгийн орлон нисгэгчээс бусад нисгэгч нь дараах шаардлагыг хангасныг баталгаажуулна:

535.f.1) тухайн онгоцны маяг, эсвэл вариант бүрт ИНД-61-ийн дагуу шаардсан нислэгийн дадлага туршлагыг хангасан; эсвэл

535.f.2) энэ зүйлийн (а)-гийн 2/-т шаардсан журамд заасан онгоцны маяг, эсвэл вариант бүрт шаардагдах нислэгийн дадлага туршлагыг хангасан.

121.537. САТ II, САТ III-аар нарийвчлалтай ойртолт, багасгасан хязгаарлалтаар хөөрөлт үйлдэх нисэх баг

(537.a) Гэрчилгээ эзэмшигч нь, САТ II буюу САТ III-аар нарийвчлалтай ойртолт үйлдэх, эсвэл багасгасан хязгаарлалтаар хөөрөлт үйлдэх агаарын хөлгийн дарга болон хамтран нисгэгч нь тухайн ойртолт, хөөрөлтийг үйлдэхээр мэргэшсэн гэдгийг баталгаажуулна.

(537.b) Энэ зүйлийн (а)-гийн хувьд:

537.b.1) агаарын хөлгийн дарга нь САТ II буюу САТ III-аар нарийвчлалтай ойртолт үйлдэх, эсвэл багасгасан хязгаарлалтаар хөөрөлт үйлдэхэд зөвхөн идэвхтэй нисгэгч(PF)-ээр мэргэшсэн бол тухайн ойртолт болон багасгасан хязгаарлалтаар хөөрөлтийг идвэхитэй нисгэгчээр гүйцэтгэх; болон

537.b.2) хамтран нисгэгч нь САТ II буюу САТ III-аар нарийвчлалтай ойртолт үйлдэх, эсвэл багасгасан хязгаарлалтаар хөөрөлт үйлдэхэд зөвхөн идэвхгүй нисгэгч /PNF/-ээр мэргэшсэн тохиолдолд агаарын хөлгийн дарга бүх САТ II, САТ III-аар нарийвчлалтай ойртолт болон багасгасан хязгаарлалтаар хөөрөлт гүйцэтгэх.

(537.c) Энэ зүйлийн (с)-г үл харгалзан, дараах шаардлагыг хангасан нисгэгч САТ II, САТ III-аар нарийвчлалтай ойртолт, эсвэл багасгасан хязгаарлалтаар хөөрөлтийг идвэхитэй эсвэл идвэхгүй нисгэгчээр гүйцэтгэж болно:

537.c.1) агаарын хөлгийн дарга болон хамтран нисгэгч нь энэ зүйлийн (а)-д заасан шаардлагыг хангаж байгаа; болон

537.c.2) агаарын хөлгийн дарга нь:

2.1. энэ дүрмийн 121.517-д заасан шугамын хянан нисгэгчээр мэргэшсэн; эсвэл

2.2. энэ дүрмийн 121.519-д заасан багш нисгэгчээр мэргэшсэн; эсвэл

2.3. энэ дүрмийн 121.521-д заасан шалгах нисгэгчээр мэргэшсэн бол.

121.539. Агаарын хөлгийн үйлчлэгчийн үүрэгт томилох

(539.a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагаас бага агаарын хөлгийн үйлчлэгчтэйгээр зорчигч тээвэрлэн агаарын тээврийн үйл ажиллагаа явуулж болохгүй:

539.a.1) тухайн онгоцонд зориулж үйлдвэрлэгчээс гаргасан, онцгой тохиолдлын үед зорчигчдыг яаралтай гаргах журамд заасан үйлчлэгчийн тоо;

539.a.2) тухайн онгоцны загварын онцлогоор тогтоогдсон үйлчлэгчийн тоо;

539.а.3) онгоцны, зорчигчтой тасалгаа тус бүрт 1-ээс доошгүй үйлчлэгч байхаар; болон

539.а.4) хүснэгт 3-т заасан тооноос багагүй.

Хүснэгт 3

Онгоцны зорчигчийн багтаамж	Үйлчлэгчийн тоо
15- 50	1
51- 100	2
101- 150	3
151- 200	4
201- 250	6
251- 300	7
301- 350	9
351- 400	10
401- 450	11
451- 500	12
500-аас дээш	12 +(500– аас дээш 50 зорчигч тутамд нэмэх 1)

(539.б) Гэрчилгээ эзэмшигч нь:

539.б.1) 2 ба түүнээс дээш үйлчлэгч шаардлагатай нислэгт агаарын хөлгийн даргын өмнө бусад үйлчлэгчийн үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааг хариуцан ажиллах ахлах үйлчлэгчийг; болон

539.б.2) 6 болон түүнээс дээш үйлчлэгч шаардлагатай нислэгт ахлах үйлчлэгчийн орлогчийг тус тус томилсон байх ёстой.

(539.с) Энэ зүйлийн (а)-гийн 4/-ийг үл харгалзан, нислэгийн үед үйлчлэгч өвчилсөн, эсвэл бэртэж гэмтсэний улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх үүднээс Хүснэгт 3-т зааснаас 1-ээр цөөн үйлчлэгчтэйгээр нислэг үйлдэж болох бөгөөд энэ тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна:

539.с.1) энэ зүйлийн (а)-гийн 1/, 2/ ба 3/-т заасан шаардлагуудыг хангах боломжтой; болон

539.с.2) үлдсэн үйлчлэгч нар нь нэг үйлчлэгчээр багассан үед үйл ажиллагааг гэрчилгээ эзэмшигчийн ерөнхий зааварт заасан журмын дагуу хэвийн явуулах чадвартай; болон

539.с.3) үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон үйлчлэгчийн оронд томилогдох, энэ дүрмийн 121.515-д заасан шаардлагыг хангасан үйлчлэгч буулт үйлдэх эхний нисэх буудалд бэлэн байх.

121.541. Агаарын хөлгийн диспатчерт багшлах этгээдэд тавигдах шаардлага

(541.a) Агаарын хөлгийн диспатчерт багшлах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- 541.a.1) хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй;
- 541.a.2) агаарын хөлгийн диспатчерээр 5-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай;
- 541.a.3) батлагдсан хөтөлбөрийн дагуу давтан сургалтад амжилттай хамрагдсан.

И БҮЛЭГ. СУРГАЛТ

121.551. Зорилго

Энэ бүлэгт, энэ дүрмийн “Н” бүлэгт заасан мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрт хамрагдаагүй нисэх багийн гишүүд болон АХҮ нарын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг тогтооно.

121.553. Ерөнхий зүйл

(553.a) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн “Н” бүлэгт заасан мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрт хамрагдаагүй нисэх багийн гишүүн болон АХҮ бүр агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад хамрагдсаныг баталгаажуулсан, энэ дүрмийн дагуу боловсруулсан Багийн гишүүдийн сургалтын хөтөлбөртэй байна.

(553.b) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (a)-д заасан хөтөлбөр нь ажилчид, тоног төхөөрөмж болон гуравдагч этгээдэд аливаа эрсдэл учруулахааргүй болон хэрэгжүүлэхэд аюулгүй гэдгийг баталгаажуулна.

(553.c) Энэ зүйлийн (a)-д заасан хөтөлбөр нь сургалтын дараах үе шатуудаас бүрдэнэ:

- 553.c.1) танилцуулах сургалт;
- 553.c.2) шилжин сургалт;
- 553.c.3) шат ахих сургалт;
- 553.c.4) давтан сургалт.

(553.d) Энэ зүйлийн (c)-д заасан сургалтын хэсэг бүрд хүний хүчин зүйлийн сэдвийг заавал оруулсан байна.

(553.e) Танилцах сургалт, шилжин сургалт, эсвэл шат ахих сургалтад хамрагдсан нисгэгч нь энэ дүрмийн 121.567-д заасан нисгэгчийн шугамын сургалт болон энэ дүрмийн 121.569-д заасан нисгэгчийн зөөлтийн сургалтад хамрагдна.

(553.f) Гэрчилгээ эзэмшигч нь, нисэх багийн сургалтын хөтөлбөр хариуцсан этгээд нь шалгах нисгэгчийн зэрэглэлтэй байгааг баталгаажуулна.

(553.g) АХҮ-ийн сургалтын хөтөлбөрийг хариуцсан этгээд нь энэ дүрмийн 121.525, эсвэл 121.527-ийн дагуу мэргэшсэн, эсвэл ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн мэргэшил болон дадлага туршлагатай байна.

(553.h) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)-д заасан сургалтын хөтөлбөрт хяналт тавих үүрэгтэй.

(553.i) Гэрчилгээ эзэмшигч нь:

553.i.1) энэ зүйлийн (а)-д заасан сургалтын хөтөлбөрийн дагуу өөрөө сургалтаа явуулж болно; эсвэл

553.i.2) энэ зүйлийн (а)-д заасан сургалтын хөтөлбөрийг, тухайн төрлийн сургалтыг гүйцэтгэх эрхтэй ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно; эсвэл

553.i.3) Монгол улсаас өөр улсад хийгдэх сургалтын хувьд, энэ зүйлийн (а)-д заасан сургалтын хөтөлбөрийг ИНД-141-д заасантай адил шаардлагыг хангасан гадаадын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно.

(553.j) Гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүд сургалтын хөтөлбөрийн үе шатуудыг гүйцэтгэж дууссаны дараа, доорх зүйлсийг баталгаажуулна:

553.j.1) багийн гишүүний сургалтын бүртгэлийг тухайн сургалтаар олж авсан мэргэшлийн дэлгэрэнгүйг оруулж шинэчлэх; болон

553.j.2) энэ хэсгийн 1/-д заасан сургалтын дэлгэрэнгүй бүртгэл нь ИНД-119.67-д заасан журмын дагуу хадгалагдаж байгааг; болон

553.j.3) багийн гишүүн бүр мэргэшлийнхээ талаар мэдээлэлтэй байгааг.

121.555. Багийн гишүүний сургалтын хөтөлбөрийн хуваарь (syllabus).

(555.a) Гэрчилгээ эзэмшигчийн нисэх багийн болон АХҮ-ийн сургалтын хөтөлбөрийн үе шат бүр нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд нийцсэн бөгөөд ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн төлөвлөгөө/ syllabus/ - тэй байна.

(555.b) Энэ зүйлийн (а)-д заасан төлөвлөгөө бүр нь дараах зүйлүүдэд хамаарах элементүүдийг багтаасан байна:

555.b.1) тухайн үйл ажиллагаанд зориулагдсан тусгай тоног төхөөрөмжийг багтаасан, ашиглах гэж буй онгоцны маяг;

555.b.2) тухайн үйл ажиллагаанд хамааралтай аэродром болон нислэгийн чиглэл, маршрут;

555.b.3) багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, хариуцлага, хэвийн бус, эсвэл онцгой тохиолдлын үед багийн бусад гишүүдтэй хамтран ажиллах үеийн ажил үүргийн хуваарилалт болон хариуцлагын уялдаа холбоо;

555.b.4) хөдөлгүүр, их бие, эсвэл системийн доголдол, гал, эсвэл бусад хэвийн бус үйл ажиллагаанаас шалтгаалсан бүх төрлийн онцгой нөхцөл, тохиолдлын үеийн сургалт;

- 555.b.5) нисэх багийн гишүүд онцгой тохиолдлын үед хэрэглэх тоног төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- 555.b.6) хүчилтөрөгчийн төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- 555.b.7) аврах гулсуур, аврах олс зэрэг бүх ослын болон ердийн үеийн гарах гарцын байрлал болон ашиглалт;
- 555.b.8) багийн гишүүдийн нөөцийн менежмент (CRM) болон хүний хүчин зүйлийн сургалт;
- 555.b.9) аюул, заналаас зайлсхийх менежментийг багтаасан эрсдлийг удирдах стратегийн сургалт;
- 555.b.10) ИНД-92-т заасан аюултай ачааг тээвэрлэхтэй холбогдсон шаардлагууд;
- 555.b.11) ИНД-119.75-д заасан агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөрт заасан аюулгүй байдлын сургалт; болон
- 555.b.12) гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагааны бодлого болон журам.

121.557. Багийн гишүүний танилцах сургалт

- (557.a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, нисгэгч болон АХҮ нь мэргэшээгүй боловч гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа бол энэ дүрмийн 121.553-т заасан танилцах сургалт болон энэ дүрмийн 121.555-д заасан төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдсан байна.
- (557.b) Гэрчилгээ эзэмшигч нь, ИНЕГ-ын даргын зөвшөөрөлтэйгээр, танилцах сургалтын төлөвлөгөөг гэрчилгээ эзэмшигчийн ҮАТ-д тэмдэглэл хийн, өөрчилж болно. Энэхүү өөрчлөгдсөн төлөвлөгөөний дагуу танилцах сургалтад хамрагдсан багийн гишүүний сургалтын бүртгэлд өөрчлөлт болон тухайн өөрчлөлтийг хийх болсон шалтгааны талаар дэлгэрэнгүй тэмдэглэнэ.
- (557.c) Гэрчилгээ эзэмшигч нь, танилцах сургалтад хүний хүчин зүйл болон багийн гишүүдийн нөөцийн менежмент (CRM)-ийн сэдвийг багтаасан байна.
- (557.d) Дараах шаардлагыг хангаагүй нисгэгч нь, энэ зүйлийн (a)-д заасан танилцах сургалтыг эхлүүлж болохгүй:
 - 557.d.1) Дор хаяж нислэгийн 500 цагийн туршлага хуримтлуулсан байх; эсвэл
 - 557.d.2) ИНЕГ – ын даргын хүлээн зөвшөөрсөн Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан байх; болон
 - 557.d.3) Хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байх; болон
 - 557.d.4) Нисгэгчээр шөнийн нислэгийн 25 цагийн туршлагатай байх.

121.559. Багийн гишүүний шилжин сургалт

- (559.a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, мэргэшсэн бөгөөд гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд багийн гишүүний үүрэг гүйцэтгэн оролцож байгаа

нисгэгч болон АХҮ нь дараах тохиолдолдлуудад энэ дүрмийн 121.553-т заасан шилжин сургалтад хамрагдана:

559.a.1) нэг маяг, эсвэл вариантын онгоцноос өөр маяг, эсвэл вариантын онгоц руу шилжих бол; эсвэл

559.a.2) үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт орсон, эсвэл шинэ тоног төхөөрөмж нэвтрүүлснээр онгоцны маяг, эсвэл вариантын үйл ажиллагаанд нөлөөлөлсөн.

(559.b) Энэ зүйлийн (a)-д заасан шилжин сургалтад хамгийн багадаа дараах зүйлсийг тусгасан байна:

559.b.1) тухайн онгоцны маяг, эсвэл вариантанд нийцсэн аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журам болон тоноглолуудын ашиглалт;

559.b.2) одоо ашиглагдаж буй онгоцны маяг, эсвэл вариантанд нэвтрүүлсэн шинэ тоног төхөөрөмж эсвэл шинэ журмууд; болон

559.b.3) өөр онгоц, тоног төхөөрөмж, эсвэл журмаар шаардсан хүний хүчин зүйл болон багийн гишүүдийн нөөцийн удирдлагын сургалт (CRM)-д орсон аливаа өөрчлөлт.

121.561. Багийн гишүүний дэвшүүлэх сургалт

(561.a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд багийн гишүүний үүрэг гүйцэтгэн оролцож байгаа мэргэшсэн нисгэгч эсвэл АХҮ нь дараах тохиолдолуудад энэ дүрмийн 121.553-т заасан ижил маягийн онгоц дээр дэвшүүлэх сургалтад хамрагдана:

561.a.1) нисгэгчийн хувьд, нисэх багийн нэг суудлаас илүү хариуцлагатай суудалд шилжиж байгаа; болон

561.a.2) АХҮ-ийн хувьд, илүү хариуцлагатай ажил үүрэг гүйцэтгэхээр дэвших тохиолдолд.

(561.b) Дэвшүүлэх сургалтад, нисгэгчийн шилжсэн шинэ байрлал болон АХҮ-ийн дэвшсэн илүү хариуцлагатай үүрэгт хамаарах аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журам болон тоног төхөөрөмжийн ашиглалт болон дараах зүйлсийн тусгасан байна:

561.b.1) багийн гишүүдийн шинэ, дэвшсэн ажлын байрны өвөрмөц, ялгаатай талыг онцлон тусгасан хүний хүчин зүйл болон багийн гишүүдийн нөөцийн менежмент (CRM)-ийн сургалт; болон

561.b.2) удирдах, хянах арга барилын сургалт.

121.563. Багийн гишүүний давтан сургалт

(563.a) Гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж байгаа онгоцны Нисгэгч болон АХҮ нь тухайн онгоцны маяг, ажлын байр болон үйл ажиллагааны төрлийн хувьд ажлын байрны ур чадвараа хадгалж байхын тулд энэ дүрмийн 121.553-т заасан давтан сургалтад хамрагдсан байна.

(563.b) Гэрчилгээ эзэмшигчийн давтан сургалтын хөтөлбөрт нисэх багийн гишүүдийн нислэгийн давтан сургалтыг багтаасан байх ба дараах хугацаанд хийгдэнэ гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана:

563.b.1) ХНД-ээр үйлдэгдэх агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд 6 сар тутамд; болон

563.b.2) ИХНД-ээр үйлдэгдэх агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд 12 сар тутамд.

(563.c) Гэрчилгээ эзэмшигч нь сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын хэсгийг энэ дүрмийн 121.565-д заасан сургалтын тоног төхөөрөмжийг ашиглаж хийдэг байна.

(563.d) Гэрчилгээ эзэмшигч нь давтан сургалтын хөтөлбөртөө хүний хүчин зүйлс болон багийн гишүүдийн нөөцийн менежмент (CRM)-ийн сэдвийг тусгасан байна.

121.565. Нисэх багийн сургалтын тоног төхөөрөмж

(565.a) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ дүрмийн 121.553-р шаардсан нисэх багийн сургалтын хөтөлбөр нь дараах зүйлсийг ашигласан онолын болон нислэгийн зааварчилгаатай байна гэдгийг бататгана:

565.a.1) сургалтын тоног төхөөрөмжүүд; болон

565.a.2) тухайн ашиглаж буй маягийн онгоцны нислэгийн дадлагажуур.

(565.b) Гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хөтөлбөртөө ашиглах нислэгийн дадлагажуур болон сургалтын тоног төхөөрөмж бүрийг:

565.b.1) гэрчилгээ эзэмшигч ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан; болон

565.b.2) тухайн сургалт, эсвэл шалгалт хийгдэх онгоцны маягийн хувьд, шаардлагатай бол тухайн маягийн вариантын хувьд баталгаажуулсан; болон

565.b.3) гүйцэтгэх маневр, журам, эсвэл багийн гишүүдийн гүйцэтгэх үүргийн хувьд баталгаажуулсан; болон

565.b.4) ИНД-119.81-ийн дагуу YAT-д тодорхойлсон байна.

(565.c) Гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хөтөлбөрт ашиглагдаж буй аливаа нислэгийн дадлагажуур, эсвэл сургалтын тоног төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

565.c.1) баталгаажуулахад шаардагдах үзүүлэлт, функц болон бусад шинж чанараа хадгалж байгааг; болон

565.c.2) дуурайлгаж байгаа онгоцонд орсон өөрчлөлт нь баталгаажуулахад шаардагдах үзүүлэлт, үйл ажиллагаа болон бусад шинж чанарт нөлөөлхүйц байх тохиолдолд тухайн өөрчлөлтөд нийцүүлэн өөрчилсөн байх; болон

565.c.3) Ашиглахын өмнө нислэгийн өмнөх үзлэгийг тогтмол хийдэг байх ба нислэгийн шалгалт эсвэл сургалт бүрийн дараа нислэгт гарсан аливаа дутагдлыг зохих багш нисгэгч, эсвэл шалгах нисгэгч нь бүртгэлд оруулдаг байх.

(565.d) Нисэх багийн сургалтад ашиглаж байгаа төхөөрөмж, эсвэл хэрэгсэл нь зөвхөн сургалтаас бусад зүйлд ашиглагддаг бол, гэрчилгээ эзэмшигч нь, дараах шаардлагуудыг хангах нөхцөл, бололцоог бүрдүүлсэн байна:

565.d.1) сургалтыг төлөвлөгөөт бус тасалдал гаргахгүйгээр дуусгах; болон

565.d.2) тухайн сургалтыг аюулгүй, таатай орчинд бүрэн гүйцэтгэх.

(565.e) Гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд ашиглаж буй онгоцны маяг тус бүрт тухайн маягийн онгоцны нислэгийн дадлагжуурыг нисэх багийн сургалтад ашиглана.

(565.f) Энэ зүйлийг (e)-г үл харгалзан, хэрэв тухайн маягийн онгоцны нислэгийн дадлагажуурыг ашиглах боломжгүй бол, гэрчилгээ эзэмшигч тухайн сургалтыг онгоцонд хийхээр сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт оруулан ИНЕГ-ын даргад өргөдөл гаргаж болно.

(565.g) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (f)-д зааснаар сургалтыг онгоцонд хийх тохиолдолд ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх аюулгүй ажиллагааны зөвлөмжийн дагуу гүйцэтгэнэ.

121.567. Нисгэгчийн шугамын нислэгийн сургалт

(567.a) Гэрчилгээ эзэмшигчийн, энэ дүрмийн 121.553-т заасан сургалтын хөтөлбөрийн дагуу 121.557-д заасан танилцах сургалт, эсвэл 121.559-д заасан шилжин сургалт, эсвэл 121.561-д заасан дэвшүүлэх сургалтад хамрагдсан чиг шулуун нислэгийн орлон нисгэгчээс бусад нисгэгч дараах шаардлагыг хангасан байна:

567.a.1) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтыг эхлүүлэхээс өмнө энэ дүрмийн К бүлэгт заасны дагуу ур чадвараа амжилттай дүгнүүлсэн байх; болон

567.a.2) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтад амжилттай хамрагдсан байна.

(567.b) Энэ зүйлийн (a)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт нь дараах зүйлээс бүрдэнэ:

567.b.1) Танилцах сургалтын дараа:

1.1. сэнст турбинт олон-хөдөлгүүрт онгоц – 10 хөөрөлт, буултыг багтаасан нислэгийн 20-иос доошгүй цаг, үүнээс дор хаяж 6 хөөрөлт, буулт нь идэвхтэй нисгэгчээр;

1.2. тийрэлтэт хөдөлгүүрт онгоц - 10 хөөрөлт, буултыг багтаасан нислэгийн 25-аас доошгүй цаг, үүнээс 6 хөөрөлт, буулт нь идэвхтэй нисгэгчээр;

1.3. энэ дэд заалтын 1.1 болон 1.2 – ыг оролцуулан бүх онгоцны хувьд – 4-өөс доошгүй цикл, үүнээс дор хаяж 2 нь идэвхтэй нисгэгчээр ниссэн байна.

567.b.2) шилжин, эсвэл дэвшүүлэх сургалтын дараа:

- 2.1. сэнст турбинт, олон-хөдөлгүүрт онгоц – 10 хөөрөлт, буултыг багтаасан нислэгийн 12-оос доошгүй цаг, үүнээс 6 хөөрөлт, буулт нь идэвхтэй нисгэгчээр;
- 2.2. тийрэлтэт хөдөлгүүрт онгоц - агаарын хөлгийн даргын хувьд 10 хөөрөлт, буултыг багтаасан нислэгийн 20-иос доошгүй цаг, үүнээс 6 хөөрөлт, буулт нь идэвхтэй нисгэгчээр, хамтран нисгэгчийн хувьд 10 хөөрөлт, буултыг багтаасан нислэгийн 10-аас доошгүй цаг, үүнээс 6 хөөрөлт, буулт нь идэвхтэй нисгэгчээр; болон
- 2.3. энэ заалтын 2.1 болон 2.2-ыг оролцуулан бүх онгоц – 4-өөс доошгүй цикл, үүнээс дор хаяж 2 нь идэвхтэй нисгэгчээр ниссэн байна.

(567.с) Энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын сургалт нь дараах шаардлагыг хангасан байна:

567.с.1) агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй онгоцон дээр гүйцэтгэсэн; болон

567.с.2) дараах шаардлагыг хангасан багш нисгэгчийн хяналтын дор гүйцэтгэсэн байна:

- 2.1. энэ дүрмийн 121.519-д заасан шаардлагыг хангасан; эсвэл
- 2.2. шинэ онгоцны маягийн танилцуулах сургалтыг явуулахаар ИНЕГ-ын дарга зөвшөөрөл олгосон.

(567.d) Энэ зүйлийн (с)-гийн 1/-ийн шаардлагыг хангахын тулд (с)-гийн 2/-т заасан багш нисгэгч нь:

567.d.1) нислэгийн бүх хугацааны турш агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;

567.d.2) хамтран нисгэгчээр бэлтгэгдэж буй нисгэгчид шугамын нислэгийн зааварчилгаа/дадлага өгч байгаа тохиолдолд нисгэгчийн суудал эзэлсэн байх;

567.d.3) агаарын хөлгийн даргаар бэлтгэгдэж байгаа нисгэгчид шугамын нислэгийн зааварчилгаа/дадлага өгч байгаа тохиолдолд тухайн нисгэгч дараах туршлагыг хуримтлуулах хүртэл нисгэгчийн суудлаас зааварчилгаа өгнө:

- 3.1. агаарын хөлгийн даргаар бэлтгэгдэж байгаа тухайн маягийн онгоцоор 2-оос доошгүй удаа хөөрөлт, буулт үйлдсэн; болон
- 3.2. тухайн маягийн онгоцны хувьд агаарын хөлгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэх чадвараа багш нисгэгчид амжилттай харуулсан;

567.d.4) энэ хэсгийн 3/-т заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд ажиглагчийн суудлаас зааварчилгаа өгч болно.

(567.e) Чиг шулуун нислэгийн орлон нисгэгч нь энэ дүрмийн 121.557-д заасан танилцах сургалт, эсвэл 121.559-д заасан шилжих сургалтад хамрагдсаны дараа дараах шаардлагуудыг хангасан байна:

567.e.1) энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтыг эхлүүлэхээс өмнө энэ дүрмийн К бүлэгт заасан ур чадвараа амжилттай дүгнүүлсэн байх; болон

- 567.e.2) 6-аас доошгүй нислэгт нисгэгчийн аль нэг суудлаас чиг шулуун нислэгийн орлон нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх; болон
- 567.e.3) энэ хэсгийн 2/-т заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалтын дараа К бүлэгт заасан чиглэлийн шалгалт (route check)-д амжилттай шалгуулсан байна.
- (567.f) Энэ зүйлийн (e) 2/-т заасан чиг шулуун нислэгийн орлон нисгэгчийн шугамын сургалт нь дараах шаардлагыг хангасан байна:
- 567.f.1) энэ дүрмийн 121.519-д заасан шаардлагыг хангасан багш нисгэгчийн хяналтанд; болон
- 567.f.2) агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй тухайн сургалтад хамаарах маягийн онгоцонд.

121.569. Нисгэгчийн зөөлтийн нислэг

- (569.a) Энэ дүрмийн 121.553-т заасан сургалтын хөтөлбөрийн дагуу 121.557-д заасан анхан шатны сургалт, 121.559-д заасан шилжин сургалт, эсвэл 121.561-д заасан дэвшүүлэх сургалтад амжилттай хамрагдсан чиг шулуун нислэгийн орлон нисгэгчээс бусад нисгэгч нь дараах шаардлагыг хангана:
- 569.a.1) энэ зүйлийн (b)-д заасан зөөлтийн нислэгийг эхлэхийн өмнө, энэ дүрмийн 121.567-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт, шилжин болон дэвшүүлэх сургалтын хувьд К бүлэгт заасан нислэгийн шалгалт (route check)-ыг амжилттай гүйцэтгэх; болон
- 569.a.2) энэ зүйлийн (b), (c)-д заасан нисгэгчийн мэдлэг болон ур чадварыг бэхжүүлэх зөөлтийн нислэгт 100-гаас доошгүй нислэгийн цаг, эсвэл 75-аас доошгүй нислэгийн циклийг гүйцэтгэх; болон
- 569.a.3) танилцах сургалтын хувьд, зөөлтийн нислэгийн дараа К бүлэгт заасан нислэгийн шалгалт (route check)-ыг амжилттай гүйцэтгэсэн байна.
- (569.b) Энэ зүйлийн (a)-д заасан нисгэгчийн мэдлэг болон ур чадварыг бэхжүүлэх зөөлтын нислэгт хамрагдаж буй нисгэгч нь:
- 569.b.1) танилцах, эсвэл шилжин сургалтад хамрагдсанаас хойш 120 хоногт багтаан нислэгийн 100 цаг, эсвэл 75 хөөрөлт, буулт (цикл) гүйцэтгэх; болон
- 569.b.2) зөвхөн тухайн сургалтад хамаарах нэг маягийн онгоцонд зөөгдөх; болон
- 569.b.3) энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг биелүүлэхэд энэ дүрмийн 121.567-д заасан нисгэгчийн шугамын нислэгийн сургалт хийхдээ гүйцэтгэсэн нислэгийн цаг, эсвэл хөөрөлт, буултыг (цикл) тооцож болно; болон
- 569.b.4) Хэрэв танилцах сургалтын дараа зөөлтийн нислэгт хамрагдаж байгаа бол энэ зүйлийн (a)-д шаардсан нислэгийн дадлага туршлагыг хуримтлуулахдаа дараах шаардлагыг хангасан нисгэгчийн хяналтанд гүйцэтгэнэ:

- 4.1. энэ дүрмийн 121.517-д заасан шаардлагыг хангасан шугамын хянан нисгэгч; эсвэл
 - 4.2. энэ дүрмийн 121.519-д заасан шаардлагыг хангасан багш нисгэгч; эсвэл
 - 569.b.5) Хэрэв шилжих, эсвэл дэвшүүлэх сургалтын дараа зөөлтийн нислэгт хамрагдаж байгаа бол энэ зүйлийн (а)-д шаардсан нислэгийн дадлага туршлагыг хуримтлуулахдаа дараах шаардлагыг хангасан нисгэгчийн хяналтанд гүйцэтгэнэ:
 - 5.1. энэ дүрмийн 121.531 (а)-д заасан шаардлагыг хангасан нисэх багийн гишүүн; эсвэл
 - 5.2. энэ дүрмийн 121.517 (а)-д заасан шаардлагыг хангасан шугамын хянан нисгэгч; эсвэл
 - 5.3. энэ дүрмийн 121.519-д заасан шаардлагыг хангасан багш нисгэгч.
- (569.c) Хэрэв энэ зүйлийн (b)-гийн 1/-д заасны дагуу нисгэгчийн мэдлэг болон ур чадварыг бэхжүүлэх зөөлтийн нислэгийг 120 хоногийн дотор гүйцэтгэх боломжгүй боловч у тухайн нисгэгч нь дараах шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд 30 хоног хүртэл сунгаж болно:
- 569.c.1) сургалтын хөтөлбөрт тусгагдсан бусад бүх шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа; болон
 - 569.c.2) ИНЕГ-ын дарга зөвшөөрсөн сэргээх сургалтыг амжилттай дүүргэсэн, эсвэл дараах нисгэгчийн хяналтанд шугамын нислэг гүйцэтгэсэн бол:
 - 2.1. энэ дүрмийн 121.517 (а)-д заасан шаардлагыг хангасан шугамын хянан нисгэгч; эсвэл
 - 2.2. энэ дүрмийн 121.519-д заасан шаардлагыг хангасан багш нисгэгч; эсвэл
 - 2.3. энэ дүрмийн 121.521-д заасан шаардлагыг хангасан шалгах нисгэгч.

121.571. Нисэх инженерийн зөөлтийн нислэг

(571.a) Энэ дүрмийн 121.553-т заасан сургалтын хөтөлбөрийн дагуу 121.557-д заасан танилцах сургалт, эсвэл 121.559-д заасан шилжин сургалтад амжилттай хамрагдсан нисэх инженер нь гэрчилгээ эзэмшигчээс гаргасан зөөлтийн хөтөлбөрийн дагуу зөөлтийн нислэгийг гүйцэтгэнэ.

(571.b) Энэ зүйлийн (а)-д заасан зөөлтийн хөтөлбөр нь:

- 571.b.1) зөвхөн тухайн маягийн онгоцонд гүйцэтгэх хамгийн бага нислэгийн цаг, эсвэл хөөрөлт, буултыг (цикл) тоог тодохойлсон; болон
- 571.b.2) зөөлтийн нислэг үргэлжлэх хамгийн их хугацааг тодорхойлсон; болон
- 571.b.3) зөөлтийн нислэг гүйцэтгэх хяналтад тавигдах шаардлагыг тодорхойлсон; болон

571.b.4) зөөлтийн нислэг дуусхад ур чадвар шалгах шаардлагуудыг тодорхойлсон байна.

(571.c) Энэ зүйлийн (a)-д заасан зөөлтийн хөтөлбөр нь ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байхаас гадна гэрчилгээ эзэмшигчийн YAT-т тусгагдсан байна.

121.573. Агаарын хөлгийн үйлчлэгчийн сургалтын хөтөлбөр

Энэ дүрмийн 121.533-г заасан гэрчилгээ эзэмшигчийн АХУ-ийн сургалтын хөтөлбөрт хамгийн багадаа дараах зүйлсийг тусгасан байна:

- 13.a.1) багийн гишүүдийн эрх үүргийн дараалал, зохион байгуулалт;
- 13.a.2) АХУ-ийн ажил үүрэгт хамаарах хүний хүчин зүйл болон CRM-ийн сургалт;
- 13.a.3) онцгой тохиолдлын үеийн багийн гишүүдийн үүрэг, хариуцлага болон ажил үүргийн хуваарь;
- 13.a.4) гэрчилгээ эзэмшигчийн YAT-д тусгагдсан онцгой халамж шаардсан зорчигчтой ажиллах журам болон онцгой тохиолдлын үеийн журмыг багтаасан зорчигчтой харьцах журам;
- 13.a.5) зорчигчид өгөх мэдээлэл;
- 13.a.6) АХУ, эсвэл багийн бусад гишүүд ашиглах аврах тоног төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- 13.a.7) бүхээгийн тоног төхөөрөмж болон тохируулгын зохистой ашиглалт;
- 13.a.8) хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- 13.a.9) аврах гулсуур болон олс зэрэг бүх хэвийн болон хэвийн бус үеийн гарах гарцын байрлал болон ашиглалт;
- 13.a.10) ICAO, Doc7192-AN/857 Part E-1 “АХУ – ын аюулгүй ажиллагааны сургалт, бүлэг 8-д заасан анхны тусламжийн сургалт;
- 13.a.11) гэрчилгээ эзэмшигчийн бичиг баримт болон заавар журмууд; болон
- 13.a.12) холбогдох ИНБД болон хамааралтай бусад бичиг баримтууд.

121.575. Агаарын хөлгийн үйлчлэгчийн ажлын дадлага туршлага

(575.a) Гэрчилгээ эзэмшигч нь, дараах шаардлагуудыг хангаагүй этгээдыг гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах онгоцны АХУ – ийн үүрэгт томилож болохгүй:

- 575.a.1) энэ дүрмийн 121.553-д шаардсан сургалтын хөтөлбөрийн, багийн гишүүдэд холбогдох хэсэгт амжилттай хамрагдсан; болон
- 575.a.2) энэ дүрмийн 121.553 –т заасан сургалтын хөтөлбөрийн 121.557-д заасан анхан шатны сургалт, эсвэл 121.559-д заасан шилжин сургалтад амжилттай хамрагдсаны дараа:

- 2.1. тухайн маягийн онгоцонд 5 цагийн шугамын нислэгт 2-оос доошгүй удаад тухайн ажлын байрандаа нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэсэн; эсвэл
- 2.2. энэ дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж буй өөр маягийн онгоцонд, тухайн ажиллах байрлалдаа АХҮ-ийн үүрэг гүйцэтгэж байсан, ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх дадлага туршлагатай.

(575.b) Энэ зүйлийн (а)-гийн 2.1-д шаардсан шугамын нислэгийн дадлага нь:

- 575.b.1) энэ дүрмийн 121.525-д заасан шаардлагыг хангасан этгээдийн хяналтан дор гүйцэтгэгдсэн; болон
- 575.b.2) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх, бүрэн хэмжээний, тухайн маягийн онгоцны, бүхээгийн бодит сургалтын төхөөрөмж дээр гүйцэтгэсэн 2.5-аас илүүгүй нислэгийн цагийг тооцож болно.

121.577. Багийн гишүүдийн сургалтын тайлан, тэмдэглэл

Гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүдийн бүх дадлага, сургалтын үнэн зөв тайлан, бүртгэлийг ИНД-119.67-д заасны дагуу хадгална.

121.579. Шилжилтийн үеийн зохицуулалт

N/A

К БҮЛЭГ. БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

121.601. Зорилго

Энэ бүлэгт, энэ дүрмийн И бүлгийн дагуу сургалтад хамрагдсан нисэх багийн гишүүд, агаарын хөлгийн үйлчлэгч болон багийн бусад гишүүдийн ур чадварт үнэлгээ өгөх журмыг тогтооно.

121.603. Ерөнхий зүйл

(603.a) Гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүд үүрэгт ажлаа гүйцэтгэж чадахыг бататгасан, багийн гишүүдийн нислэгийн үйл ажиллагааны ур чадварт үнэлгээ өгөх хөтөлбөртэй байна.

(603.b) Багийн гишүүдийн үйл ажиллагааны ур чадварын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

- 603.b.1) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх; болон
- 603.b.2) гэрчилгээ эзэмшигчийн хяналтад байхг; болон
- 603.b.3) тухайн онгоцны маяг, эсвэл вариант бүрд тодорхой; болон
- 603.b.4) энэ дүрмийн 121.607-гийн 2/, 3/, 5/-д заасан нисэх багийн ур чадварын үнэлгээг нислэгийн дадлагажуурт хийсэн байх.

(603.c) Гэрчилгээ эзэмшигч нь,:

- 603.с.1) энэ зүйлийн (а)-д заасан багийн гишүүдийн үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг өөрөө гүйцэтгэх; эсвэл
- 603.с.2) ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, багийн гишүүдийн ур чадварт үнэлгээ өгөх эрх бүхий нисэхийн сургалтын байгууллагатай гэрээгээр энэ зүйлийн (а)-д заасан багийн гишүүдийн үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг гүйцэтгэх; эсвэл
- 603.с.3) Монгол улсаас өөр улсад багийн гишүүдийн үйл ажиллагааны ур чадварын үнэлгээг хийх тохиолдолд ИНД-141-тэй ижил түвшний стандартыг хангасан, багийн гишүүдийн ур чадварт үнэлгээ өгөх хөтөлбөртэй гадаадын байгууллагаар гэрээгээр гүйцэтгэж болно.
- (603.d) Гэрчилгээ эзэмшигчийн багийн гишүүдийн үйл ажиллагааны ур чадварын үнэлгээний хөтөлбөрийг хариуцах этгээд нь шалгах нисгэгчийн зэрэглэлтэй байна.
- (603.e) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (b)-гийн 4/-ийг үл харгалзан, ур чадварын үнэлгээ өгөх хөтөлбөрийг тухайн маягийн онгоцны нислэгийн дадлагажуурт гүйцэтгэх боломжгүй бол нислэгийн дадлагажуур ашиглахгүйгээр ур чадварт үнэлгээ өгөхөөр хөтөлбөртөө өөрчлөлт оруулах хүсэлтийг ИНЕГ-ын даргад гаргаж болно.
- (603.f) Гэрчилгээ эзэмшигчийн, энэ зүйлийн (e)-д заасны дагуу өөрчлөлт орсон хөтөлбөр нь ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн нислэгийн аюулгүй ажиллагааны зөвлөмжийн дагуу байна.
- (603.g) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-ийн 4-т шаардсан ур чадварын үнэлгээг хийхэд ашиглах нислэгийн дадлагажуур эсвэл сургалтын төхөөрөмжүүд нь дараах шаардлагуудыг хангаж байгааг бататгана:
- 603.g.1) зөвшөөрөл авахад шаардагдсан үзүүлэлт, ажиллагаа болон бусад шинч чанараа хадгалж байх; болон
- 603.g.2) онгоцонд хийгдсэн өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан хийгдсэн аливаа өөрчлөлтөөс шалтгаалан үзүүлэлт, ажиллагаа болон бусад үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт гарсан тохиолдолд ИНЕГ – с зөвшөөрөл авсан байх; болон
- 603.g.3) ашиглахаас өмнө хэвийн ажиллагааг шалгах нислэгийн өмнөх үзлэг хийдэг ба ашиглалтын явцад илэрсэн аливаа дутагдлыг зохих багш эсвэл шалгагч нисгэгч нь сургалт эсвэл шалгалт бүрийн дараа бүртгэл хөтөлдөг байх.

121.605. Үйл ажиллагааны ур чадварт үнэлгээ өгөх хөтөлбөрийн талаарх үүрэг хариуцлага

- (605.a) Гэрчилгээ эзэмшигч нь, энэ дүрмийн 121.603-т шаардсан багийн гишүүдийн ур чадварт үнэлгээ өгөх хөтөлбөрийн үйл ажиллагааны зохицол болон хэрэгжилтэд бүрэн хариуцлага хүлээнэ.
- (605.b) Гэрчилгээ эзэмшигч нь, багийн гишүүн бүр хөтөлбөрийн дагуу ур чадвараа үнэлүүлж байгааг баталгаажуулна.

121.607. Нисэх багийн гишүүдийн ур чадварийн үнэлгээ

Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг баталгаажуулна:

13.а.1) Гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй онгоцны дарга бүр өмнөх 12 сарын хугацаанд шалгах нисгэгчийн хяналтан дор аэродромын шалгалтыг багтаасан нислэгийг чиглэлийн шалгалтыг амжилттай өгсөн байх бөгөөд тухайн шалгалт нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- 1.1. хамгийн багадаа нислэгийн нэг чиглэлд нэг нислэг үйлдэх бөгөөд үйл ажиллагаа явуулах аэродромуудыг төлөөлөх аэродромд нэг буюу түүнээс дээш буултаас бүрдсэн байх; болон
- 1.2. гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод нийцсэн нислэгийн үйл ажиллагаанд оролцох онгоцны, даргын үүргийг гүйцэтгэх чадвараа харуулах бололцоог олгох; болон

13.а.2) Гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд ИХНД-ээр нислэг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа онгоцны нисгэгч бүр нь, өмнөх 12 сарын хугацаанд шалгах нисгэгчийн хяналтан дор дараах сэдвүүдийг хамарсан ур чадварын үнэлгээнд хамрагдсан байна:

- 2.1. онцгой тохиолдлын үед мөрдөх журам болон бусад журмууд; болон
- 2.2. агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглах онгоцны маягийн хувьд нисгэгчийн нислэгийн ур чадвар; болон
- 2.3. хүний хүчин зүйл, багийн харилцан ажиллагааны удирдлага /CRM/; болон

13.а.3) Гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд ХНД-ээр нислэг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа онгоцны нисгэгч бүр нь, өмнөх 6 сарын хугацаанд шалгах нисгэгчийн хяналтан дор дараах сэдвүүдийг хамарсан ур чадварын үнэлгээнд хамрагдсан байна:

- 3.1. гэрчилгээ эзэмшигчээс тухайн нисгэгчийг томилсон үйл ажиллагааны төрөл болон онгоцны тоноглолд нийцсэн онцгой тохиолдлын үед ажиллах журам болон бусад журмуудыг батгаасан байх; болон
- 3.2. хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлага /CRM/-ыг багтаасан байх;

13.а.4) Нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй нисгэгч бүр нь өмнөх 12 сарын дотор дараах сэдвүүдээр нисгэгчийн мэдлэгээ амаар, эсвэл бичгээр шалгуулсан байна:

- 4.1. холбогдох иргэний нисэхийн дүрмүүд;
- 4.2. гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолт болон үйл ажиллагааны заавруудын талаарх мэдлэг;
- 4.3. тухайн нисгэгчийн нислэг үйлдэх онгоцны систем, үзүүлэлт, нислэгийн журмууд болон нислэгийн ашиглалтын зааврын талаарх мэдлэг;

- 4.4. навигаци, НХУ, цаг уурын мэдлэг;
 - 4.5. тухайн нисгэгчийн гүйцэтгэх нислэгийн төрөлд хамааралтай тусгай нислэгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг;
 - 4.6. шинэ тоног төхөөрөмж, журам болон аргачлал;
 - 4.7. тухайн нисгэгчийн нислэг үйлдэх онгоцны онцгой тохиолдлын тоног төхөөрөмжүүдийн байрлал болон ашиглалт;
- 13.а.5) Нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа онгоцны нисэх инженер бүр нь, өмнөх 12 сарын дотор шалгах зэрэглэлтэй нисэх инженерийн хяналтан дор тухайн онгоцны тоноглол болон тухайн төрлийн нислэгийн үйл ажиллагаанд нийцсэн онцгой тохиолдлын үед ажиллах журам болон бусад журмууд, хүний хүчин зүйл, багийн нөөцийн улирдлага /CRM/-ыг багтаасан ур чадварын үнэлгээг амжилттай өгсөн байх; болон
- 13.а.6) Нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоцны нисэх инженер бүр нь өмнөх 12 сарын дотор инженерийн мэдлэгээ дараах онолын шалгалтуудыг амаар, эсвэл бичгээр амжилттай өгч шалгуулсан байх:
- 6.1. холбогдох иргэний нисэхийн дүрмүүд;
 - 6.2. гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолт, үйл ажиллагааны заавруудын талаарх мэдлэг;
 - 6.3. тухайн нислэг үйлдэх онгоцны систем, үзүүлэлт, үйл ажиллагааны журам болон нислэгийн ашиглалтын зааврын талаарх мэдлэг;
 - 6.4. тухайн нислэгийн төрөлд хамааралтай тусгай нислэгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг;
 - 6.5. шинэ тоног төхөөрөмж, журам болон аргачлал.

121.609. Багш нисгэгч, шугамын хянан нисгэгч, дадлагажуурын багш болон шалгах нисгэгчийн ур чадварын үнэлгээ

Гэрчилгээ эзэмшигч нь багш нисгэгч, шугамын хянан нисгэгч, дадлагажуурын багш болон шалгах нисгэгчид нь дараах зүйлд нийцсэн зааварчилга авсан байх ба ур чадвараа хадгалж байгааг баталжуулна:

- 13.а.1) тухайн маягийн онгоцонд хэрхэн үйл ажиллагаа явуулах болон хэрхэн аюулгүй ажиллагааг хангах талаарх зааварчлагаа өгөх аргачлал;
- 13.а.2) хүний хүчин зүйлс, CRM-ийг багтаасан нисэх багийн гишүүдийн онгоцны техникийн болон техникийн бус ур чадварт үнэлгээ өгөх болон дүгнэх аргачлал;
- 13.а.3) онгоцыг буруу удирдсан, хэвийн бус болон онцгой тохиолдлын үеэс хэвийн үйл ажиллагааг сэргээх аргачлал; болон
- 13.а.4) үйл ажиллагаандаа ашиглаж буй ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн нислэгийн дадлагажуур эсвэл онгоц, тэдгээрийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн, хэвийн бус болон онцгой тохиолдлын үеийн ажиллагаа, журам, маневрууд.

121.611. Агаарын хөлгийн үйлчлэгчийн ур чадварт үнэлгээ

Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцох онгоцны АХҮ бүр нь өмнөх 12 сарын хугацаанд энэ дүрмийн 121.527-ын шаардлагыг хангасан шалгах үйлчлэгчтэй гүйцэтгэх нислэгийн шалгалтыг багтаасан ур чадварын үнэлгээг дараах сэдвүүдээр амжилттай гүйцэтгэсэн байх ёстой:

- 13.а.1) агаарын хөлгийн даргын эрх;
- 13.а.2) аюулгүй ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй зорчигчтой харьцах журмыг багтаасан зорчигч үйлчилгээний журмууд;
- 13.а.3) бусдын туслалцаа шаардлагатай зорчигчийг онцгой тохиолдлын үед нүүлгэн шүлжүүлэх зэргийг багтаасан онцгой тохиолдлын үеийн нисэх багийн томилгоо, үүрэг хариуцлага болон үйл ажиллагаа;
- 13.а.4) хүний хүчин зүйл болон багийн нөөцийн удирдлага /CRM/;
- 13.а.5) зорчигчдод зааварчилгаа, мэдээлэл өгөх;
- 13.а.6) бүхээгийн тоноглол, удирдлагын ашиглалт;
- 13.а.7) аврах тоног төхөөрөмжийн байрлал болон ашиглалт;
- 13.а.8) хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн байрлал, ашиглалт;
- 13.а.9) гулсах шат,олс зэрэг бүх ердийн болон аврах гарцнуудын байрлал болон ашиглалт;
- 13.а.10) туслалцаа шаардлагатай байж болзошгүй зорчигчдыг суудалд хуваарилах;
- 13.а.11) ICAO Doc 7192-AN/857-ийн дагуу анхан шатны тусламжийн сургалт; болон
- 13.а.12) агаарын хөлгийн ахлах үйлчлэгч болон түүний орлогчийн хувьд, бусад үйлчлэгчид хяналт тавих чадвар.

121.613. Ур чадварын болон шалгалтын бүртгэл

Гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүдийн бүх ур чадварын үнэлгээ, чиглэлийн шалгалт болон онолын мэдлэгийг шалгасан үнэн зөв бүртгэлийг ИНД-119.67-д заасны дагуу хадгална.

121.615. Шилжилтийн үеийн зохицуулалт

N/A

Л БҮЛЭГ. НИСЭХ БАГИЙН ГИШҮҮДИЙН НИСЛЭГИЙН БОЛОН АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**121.801. Зорилго**

Энэ бүлэгт, гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа онгоцны нисэх багийн гишүүдийн алжаал ядаргааг багасгахад чиглэсэн нислэгийн цагийн хязгаарлалт болон бусад холбогдох журмыг тогтооно.

121.803. Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага

(803.а) Тээвэрлэгч нь дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй:

803.а.1) Онгоцны нисэх багийн гишүүнээр нислэг үйлдэх нисгэгч бүрт зориулсан нислэгийн болон нислэгийн үүрэгт цагийн зохицуулалтыг тусгасан хуваарьтай байх;

803.а.2) Хуваарь нь, тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаанд нийцсэн, дараах хүчин зүйлсийг тусгасан байна:

- 2.1. нислэгийн өмнөх амралтын хугацаа;
- 2.2. цагийн зөрүүд дасан зохицох;
- 2.3. цагийн бүсүүд;
- 2.4. шөнийн нислэг;
- 2.5. хамгийн их нислэгийн тоо;
- 2.6. нэг нисгэгчтэй нислэг;
- 2.7. хоёр нисгэгчтэй нислэг;
- 2.8. хоёр нисгэгч дээрх нэмэлт нисэх багийн гишүүд;
- 2.9. нисэх багийн гишүүдийн мэргэшил;
- 2.10. хамтатгасан ажил үүрэг;
- 2.11. нислэгийн үүрэг гүйцэтгэхийн өмнө буюу дараа зорчигчоор аялах (deadhead transportaion);
- 2.12. нөөц болон бэлэн үе;
- 2.13. нислэгийн үүргийн үе (flight duty period);
- 2.14. нислэгийн үед амрах (in-flight relief);
- 2.15. нислэгийн төрөл;
- 2.16. нислэгийн үүргэг хүлээсэн нийт цаг;
- 2.17. нислэгийн нийт цаг;
- 2.18. нислэгийн үүрэгт цаг эсвэл нислэгийн цаг, эсвэл аль алинийг нь онгоцны даргын шийдвэрээр нэмэгдүүлэх;

2.19. биоритм /Circadian Rhythm/;

2.20. амралтын өдрүүд;

2.21. бүртгэл хөтлөлт; болон

803.а.3) Хуваарь нь ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

(803.б) Гэрчилгээ эзэмшигч, агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоцны нисэх багийн гишүүн ядарч, алжаасан эсвэл нислэгийн явцад ядрах бодит шалтгаан байгаа бөгөөд энэ нь нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж үзвэл тухайн нисэх багийн гишүүнийг нислэгийн үйл ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах эсвэл оролцох зөвшөөрөл олгох ёсгүй.

(803.с) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх тээвэрлэгч нь дараах шаардлагуудыг хангасан байна:

803.с.1) нислэгт оролцож байгаа нисэх багийн гишүүн бүрийн нислэгийн болон нислэгийн үүрэгт цагийн үнэн зөв бүртгэлийг хадгалах; болон

803.с.2) энэ зүйлийн (с) /1 – т шаардсан нислэгийн болон нислэгийн үүрэгт цагийн бүртгэлийг тухайн бүртгэл хийгдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

121.805. Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага

(805.а) Нисэх багийн гишүүн нь ядарсан байгаагаа мэдэж байгаа эсвэл ядарсан байж болзошгүй гэж үзэж байгаа эсвэл нислэгийн явцад ядрах бодит шалтгаан байгаа бөгөөд энэ нь нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байгаа тохиолдолд нисэх багийн гишүүний үүрэг хүлээх ёсгүй.

(805.б) Нисэх багийн гишүүн нь агаарын тээвэрлэгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байх үедээ өөр тээвэрлэгчтэй урамшууллаар буюу хөлсөөр нислэгийн үүрэг гүйцэтгэх тохиолдолд нийт нислэгийн болон нислэгийн үүрэгт цаг нь 121.803-ын (а) 1/-д заасан нислэгийн цагийн хязгаарлалтаас хэтрэхээр бол тухайн нислэгийн үйл ажиллагаанд оролцохгүй.

(805.с) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоцны нисэх багийн гишүүн, 121.803-ын (а) 1/-д шаардсан хуваарийн өөрт хамаарах хязгаалалтаас хэтрээгүй гэдгийг бататгаагүй тохиолдолд нислэгийн үйл ажиллагаанд оролцохгүй.

(805.д) Агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх онгоцны нисэх багийн гишүүн нислэг эхлэхээс өмнө, гүйцэтгэсэн болон гүйцэтгэхээр төлөвлөсөн нислэгийн нийт цаг нь дор зааснаас хэтэрсэн тохиолдолд нислэгийн үйл ажиллагаанд оролцохгүй:

805.д.1) тухайн нислэгийг үйлдэх өдрийг оролцуулан өмнөх дараалсан 28 өдрийн нислэгийн нийт цаг нь 100-гаас хэтэрсэн; эсвэл

805.д.2) тухайн нислэгийг үйлдэх өдрийг оролцуулаад өмнөх дараалсан 365 өдрийн нислэгийн нийт цаг нь 1000-аас хэтэрсэн.

М БҮЛЭГ. ЗААВАР БОЛОН НИСЛЭГИЙН ДЭВТЭР, БҮРТГЭЛ

121.851. Зорилго

Энэ бүлэгт, агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай заавар болон нислэгийн дэвтэр, бүртгэлийн ашиглалт, хадгалалтад хамааралтай журмыг тогтооно.

121.853. Үйл ажиллагааны мэдээлэл

(853.a) Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааврын, багийн гишүүдийн ажил үүрэгт хамааралтай хэсэг нь хүчин төгөлдөр бөгөөд нислэгийн өмнөх төлөвлөлтийн үед болон нислэгийн үед нисэх багийн гишүүд ашиглах боломжтой байна.

(853.b) Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцогчдын дагаж мөрдөх шаардлагатай мэдээлэл нь АIP-д тусгагдсан бөгөөд хүчин төгөлдөр байна.

(853.c) гэрчилгээ эзэмшигч ИНЕГ – с гаргаагүй нислэгийн хүснэгт (chart), нислэгийн бичиг баримтыг ашиглахаар сонгосон тохиолдолд тухайн бичиг баримтууд нь агуулгын хувьд ИНЕГ-аас гаргасан бичиг баримтуудтай ижил байна.

(853.d) Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд нь тэдгээрт зориулагдсан бичиг баримтад хийгдэж буй аливаа нэмэлт, өөрчлөлтүүд зохих журмын дагуу хийгдсэн, хүчин төгөлдөр гэдгийг бататгана.

121.855. Агаарын хөлгийн бүхээгт авч явах бичиг баримтууд

(855.a) Гэрчилгээ эзэмшигч нислэг бүрт дараах бичиг баримтуудыг агаарын хөлгийн бүхээгт авч явна гэдгийг бататгана:

855.a.1) нислэгийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй мэдээлэл;

855.a.2) нислэгт шаардлагатай NOTAM мэдээ болон аэронавигацийн бусад бичиг баримтууд;

855.a.3) тухайн нислэгтэй холбогдолтой цаг агаарын мэдээ;

855.a.4) ачаалалтын дэлгэрэнгүй мэдээлэл /load manifest/;

855.a.5) аюултай ачааны талаарх мэдээ;

855.a.6) нислэгийн зураг, схемийн хуулбар; болон

855.a.7) тогтмол нислэгт, нислэгийн чиглэл болон ашиглаж болох нөөц аэродромуудыг хамарсан маршрутын лавлах.

(855.b) Энэ зүйлийн (a)-гийн 6/-д заасан бичиг баримтын хуулбар нислэг үйлдэж буй нисгэгч тус бүрт байна.

121.857. Нислэгийн бүртгэл

(857.a) Гэрчилгээ эзэмшигч нь гүйцэтгэсэн нислэг бүрийнхээ хувьд дараах бүртгэлийг тогтмол хөтөлнө:

857.a.1) нислэгийн төлөвлөлтийн; болон

857.а.2) нислэгийн гүйцэтгэлийн.

(857.б) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)-д заасан бүртгэлийг хугацаагүй хадгална.

121.859. Бүртгэлийг хадгалах хугацаа

(859.а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах бүртгэлийг, тэдгээрийг үйлдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална:

859.а.1) нислэгийн бүртгэл (operational records);

859.а.2) ачаалалтын дэлгэрэнгүй мэдээлэл;

859.а.3) аюултай ачааны талаарх мэдээлэл.

(859.б) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх багийн гишүүдийн нислэгийн болон нислэгийн үүрэгт цагийн бүртгэлийг бүртгэл хийгдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

(859.с) Гэрчилгээ эзэмшигч нь багийн гишүүн бүрийн сургалт, дадлага, шалгалтын бүртгэлүүдийг тухайн этгээд гэрчилгээ эзэмшигчтэй хөдөлмөрийн гэрээ цуцалснаас хойш 12 сар хүртэл хугацаагаар хадгална.

Н БҮЛЭГ. МЭРГЭШҮҮЛЭХ ДЭВШИЛТЭТ ХӨТӨЛБӨР

121.901. Зорилго

Энэ бүлэгт, багийн гишүүд болон бусад ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, гэрчилгээжүүлэх болон ур чадварыг нь өөр бусад хэлбэрээр хадгалахад чиглэгдсэн мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх шаардлагыг тогтооно.

121.903. Ерөнхий зүйл

(903.а) Гэрчилгээ эзэмшигч бүр энэ бүлгийн дагуу мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөр эсвэл энэ дүрмийн И бүлгийн дагуу боловсруулсан сургалтын хөтөлбөртэй байна.

(903.б) Энэ бүлгийн дагуу мэргэшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа гэрчилгээ эзэмшигч нь одоо ашиглаж буй сургалтын хөтөлбөрөөс мэргэшүүлэх хөтөлбөр рүү шилжих төлөвлөгөөг боловсруулсан байна.

(903.с) Гэрчилгээ эзэмшигч нь хөтөлбөрийг ажилтан, тоног төхөөрөмж болон гуравдагч этгээдэд аливаа эрсдэлгүй бөгөөд аюулгүй ажиллагааг хангаж хэрэгжүүлнэ.

(903.д) Хөтөлбөрийг хариуцах этгээд нь шалгах нисгэгчийн зэрэглэлтэй байна.

(903.е) Гэрчилгээ эзэмшигч энэхүү хөтөлбөрт тавигдах хяналтыг өөрөө хариуцна.

(903.ф) Энэ бүлэгт хамаарах аливаа этгээдийн хувьд хөтөлбөрийн бүх шаардлагуудыг дагаж мөрдөнө гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана.

(903.г) Мэргэшүүлэх хөтөлбөр нь дараах бүх ажлын байруудыг хамарсан байна:

903.г.1) нисэх багийн гишүүд; болон

- | | |
|----------|---------------------------|
| 903.g.2) | багш нисгэгч нар; болон |
| 903.g.3) | шалгах нисгэгч нар; болон |
| 903.g.4) | үнэлгээ өгөгчид. |

(903.h) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (g)-д тусгагдаагүй, агаарын хөлгийн үйлчлэгч, нислэгийн зохицуулалтын мэргэжилтэн зэрэг бусад ажлын байруудыг мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулах бол тухайн ажлын байрт хамаарах бүх ажилтнууд тус хөтөлбөрт хамрагдаж байгааг баталгаажуулна.

121.905. Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлтүүд

(905.a) Мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөр шинээр боловсруулж, эсвэл өөрчилж буй гэрчилгээ эзэмшигч нь тухайн төлөвлөгөөг ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөх хүртэл энэ дүрмийн З, И, К бүлгийн шаардлагыг хангана.

(905.b) ИНЕГ – ын дарга гэрчилгээ эзэмшигчийг хөтөлбөрийн шаардлагыг хангахгүй байна гэж үзвэл дараах зүйлсийг гэрчилгээ эзэмшигчээс шаардаж болно:

905.b.1) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөх байдлаар хөтөлбөртөө өөрчлөлт хийх; эсвэл

905.b.2) мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрийг энэ дүрмийн И, К бүлгийн шаардлагыг хангасан сургалтын хөтөлбөрөөр солих.

(905.c) хэрэв энэ зүйлийн (b)-гийн заалтыг хэрэгжүүлж байгаа бол ИНЕГ гэрчилгээ эзэмшигчээс одоо мөрдөж буй мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрөөс өөр хөтөлбөрт шилжих ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөхүйц төлөвлөгөөг шаардаж болно.

121.907. Хөтөлбөрийн агуулга

(907.a) Гэрчилгээ эзэмшигчийн мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрийн агуулга нь:

907.a.1) энэ бүлгийн шаардлагыг хангасан; болон

907.a.2) ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдхүйц байна.

(907.b) Хөтөлбөрийн сэдэв бүр нь дараах шаардлагыг хангасан байна:

907.b.1) ИНД-61, эсвэл энэ дүрмийн И, К бүлгийн шаардлагыг тусгасан;

907.b.2) аюулгүй ажиллагааны түвшин нь ИНД-61, эсвэл энэ дүрмийн И, К бүлгийн шаардлага бүрийн хувьд адил түвшинд тавигдсан;

907.b.3) ИНД-61, эсвэл энэ дүрмийн И, К бүлгийн холбогдох шаардлагыг хангасан;

907.b.4) дараах зүйлийг тусгасан:

4.1. онгоцны маяг, загвар, үйлдвэрлэл, төрөл; болон

4.2. нисэх багийн гишүүд болон бусад этгээдүүдийн ажлын байр.

121.909. Сургалтын чиглэл

- (909.a) Мэргэшүүлэх дэвшилтэт сургалтын хөтөлбөр нь анхан шатны буюу танилцуулах, мэргэшүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалтын тус тусдаа хэсгүүдээс бүрдэнэ.
- (909.b) Анхан шатны танилцуулах сургалтаар гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд оролцож буй мэргэшээгүй ажилтан бүрт дараах зүйлсийг танилцуулдаг байна:
- 909.b.1) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон бодлого;
 - 909.b.2) үйл ажиллагааны ерөнхий мэдлэг; болон
 - 909.b.3) тухайн этгээдийн ажлын байранд зайлшгүй шаардлагатай аэронавигацийн ерөнхий мэдлэг, тусгай мэдээлэл.
- (909.c) Мэргэшүүлэх сургалтын агуулга нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд оролцож байгаа мэргэшээгүй ажилтан бүрийг өөрийн ажил үүргийг стандарт шаардлагын хүрээнд гүйцэтгэхэд шаардлагатай техникийн сургалт, дадлагад хамруулж, үнэлгээ хийж, гэрчилгээжүүлдэг байна.
- (909.d) Мэргэшил хадгалуулах давтан сургалтын агуулга нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд оролцож байгаа бэлтгэгдэж мэргэшсэн ажилтан бүрийг өөрийн ажил үүргээ стандарт шаардлагын хүрээнд гүйцэтгэхэд шаардлагатай давтан сургалтыг гүйцэтгэх үе шатыг тооцож хийгдсэн байна.

121.911. Танилцуулах сургалтын төлөвлөгөө

Танилцуулах сургалтын төлөвлөгөө бүр нь дараах сэдвүүдийг агуулсан байна:

- 13.a.1) Энэ сургалтад хамрагдаж байгаа ажилтан бүрт гэрчилгээ эзэмшигчийн бодлого, үйл ажиллагааны туршлага болон үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдлэг; болон
- 13.a.2) Энэ сургалтад хамрагдах нисэх багийн гишүү болон НХЗ – ын ажилтан бүрт энэ зүйлийн 1/-д зааснаас гадна аэронавигацийн ерөнхий мэдлэг; болон
- 13.a.3) Энэ сургалтад хамрагдаж байгаа багшлах эрх бүхий этгээдүүдэд энэ зүйлийн 1/-д зааснаас гадна:
 - 3.1. заах ба сургах арга барилын суурь зарчим;
 - 3.2. багшлах онол болон арга зүй;
 - 3.3. агаарын хөлөг, нислэгийн сургалтын төхөөрөмж, нислэгийн дадлагажуур, мэргэшүүлэх дэвшилтэт сургалтын бусад тоног төхөөрөмжүүдийг ашиглахад шаардлагатай мэдлэг;
- 13.a.4) Энэ сургалтад хамрагдаж байгаа шалгах нисгэгч болон үнэлгээ өгөгч бүрт энэ зүйлийн 1/-д зааснаас гадна:
 - 4.1. батлагдсан хөтөлбөр бүрт заагдсан дүгнэлт өгөх шаардлагууд;

- 4.2. багийн гишүүд ба нислэгийн үйл ажиллагаанд оролцогчдыг дүгнэх аргачлал; болон
- 4.3. мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрийн сэдвийн дагуу үнэлгээ өгөх бодлого, аргачлал.

121.913. Мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө

Мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө бүр нь дараах сэдвүүдийг агуулсан байна:

13.а.1) энэ сургалтад хамрагдах этгээд нь дараах мэдлэгийг эзэмшсэн байна:

- 1.1. төлөвлөсөн сургалтын хугацаа, дүгнэлт ба хяналтан дор олж авах ажлын туршлага;
- 1.2. холбогдох хүн бүрийн ажлын байрны онцлогт хамаарах мэргэшүүлэх болон үнэмлэхжүүлэх үйл ажиллагаа, сургалт дадлагын жагсаалт;
- 1.3. холбогдох хүн бүрийн ажлын байрны онцлогт хамаарах мэргэшүүлэх болон үнэмлэхжүүлэх үйл ажиллагаа, сургалт дадлагын тодорхой заалтууд.

13.а.2) энэ бүлгийн дагуу сургалтад оролцох нисэх багийн гишүүд болон нислэгийн үйл ажиллагаанд оролцох бусад этгээд нь энэ зүйлийн 1/-д зааснаас гадна дараах зүйлийг нарийвчлан судалсан байна:

- 2.1. аливаа этгээдийг гүйцэтгэх ажил үүрэгтэй нь уялдаатайгаар, онгоцны тодорхой маяг, загвар дээр агаарын хөлөг ба тоног төхөөрөмжийн онцлогт тохируулан бэлтгэх, үнэлэх ба гэрчилгээжүүлэх ажиллагаа;
- 2.2. мэдлэгт тавигдах шаардлагууд, сургалтын материал, ажлын ур чадвар, мөн сургалт хийгдэж, үнэлгээ өгөгдөх журам, маневрууд; болон
- 2.3. хяналтын үед олж авах ажлын туршлагыг тодорхойлсон жагсаалтууд ба ИНД-61-ийн шаардлагад нэмэлт болох, эсвэл түүнийг орлох дадлагын шалгуур шаардлагууд;

13.а.3) энэ сургалтад хамаарах багш нисгэгч нь энэ зүйлийн 1/-д зааснаас гадна, онгоцны тодорхой маягийн хувьд аюулгүй ажиллагааг хангах, үйл ажиллагааг гүйцэтгэх зааварчилгааг хэрхэн өгөх талаар мэргэшүүлэх сургалт ба үнэлгээ; болон

13.а.4) энэ сургалтад хамаарах шалгах нисгэгч ба үнэлгээ өгөгчийн хувьд, энэ зүйлийн 1/-д зааснаас гадна, онгоцны тодорхой маягийн хувьд аюулгүй ажиллагааг хангах, үйл ажиллагааг гүйцэтгэх этгээдийг сургах, үнэлгээ өгөх, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны жагсаалт.

121.915. Мэргэшил хадгалуулах давтан сургалтын төлөвлөгөө

Мэргэшүүлэх давтамж

(13.а) Гэрчилгээ эзэмшигчийн мэргэшүүлэх давтан сургалтын төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан циклд үндэслэнэ:

- 13.a.1) энэ сургалтад хамрагдах этгээд нь мэргэшүүлэх давтан сургалтын үе шат бүрийн явцад сургалт дадлагад оролцож, үнэлэлт дүгнэлт авсан байх;
- 13.a.2) энэ сургалтад хамрагдах этгээд нь ур чадвар, мэдлэгийн түвшин болон зан чанарын хувьд хамгийн доод түвшинг хадгалж байх; болон
- 13.a.3) энэ сургалтад хамаарах нисэх багийн гишүүд нь ИНД-61.37-д заасан дадлага туршлагад тавигдах шаардлагуудыг хангасан байна.
- (13.b) Мэргэшүүлэх давтан сургалт нь хуанлийн 26 сараас дээшгүй хугацаанд давтагдах бөгөөд энэ хугацааг ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, дараах байдлаар сунгаж болно:
- 13.b.1) гэрчилгээ эзэмшигч сунгалт хийх хангалттай үндэслэлтэй;
- 13.b.2) сунгалт нь хуанлийн 3 сараас хэтрэхгүй байх; болон
- 13.b.3) мэргэшүүлэх давтан сургалтын цикл нь хамгийн ихдээ 39 сар байна.
- (13.c) Мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөрт, давтан сургалтад хамрагдаагүй нисэх багийн гишүүд, агаарын хөлгийн диспатчер, нислэгийн ажиллагаанд оролцогч бусад этгээдийг хамруулна гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана.

Мэргэшүүлэх давтан сургалтад үнэлгээ өгөх үе

- (13.d) Мэргэшүүлэх давтан сургалтын цикл нь үнэлгээ өгөх үетэй байх ба мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдах хүн бүр нэгээс доошгүй удаа ур чадварын үнэлгээ авсан байна гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана.
- (13.e) Энэ зүйлийн (d)-д заасан үнэлгээ өгөх үе нь эхний удаа хуанлийн 13 сараас хэтрэхгүй байх бөгөөд хэрэв ИНЕГ-ын дарга зөвшөөрвөл, дараах байдлаар сунгаж болно:
- 13.e.1) гэрчилгээ эзэмшигч сунгалт хийх хангалттай үндэслэлтэй;
- 13.e.2) сунгалт нь хуанлийн 3 сараас хэтрэхгүй; болон
- 13.e.3) мэргэшүүлэх давтан сургалтын цикл нь хамгийн ихдээ 26 сар байна.

Үнэлгээ өгөх үеийн дадлага

- (13.f) Энэ зүйлийн (d)-д заасан үнэлгээ өгөх үе нь ИНЕГ-ын Даргаас хүлээн зөвшөөрсөн үечлэл бүхий дадлагыг агуулсан байна.
- (13.g) Энэхүү дадлагыг өгөх хугацаанаасаа 2 сарын өмнө өгсөн тохиолдолд, гэрчилгээ эзэмшигч тухайн дадлагыг сүүлийн сардаа өгснөөр тооцож болно.
- (13.h) Энэхүү хөтөлбөрт хамрагдаж буй этгээд дадлагын турш дараах мэдлэгийг олж авсан байна:
- 13.h.1) агаарын хөлгийн дарга, хамтран нисгэгч, нисэх инженер, багшлах ба үнэлгээ өгөгч этгээдийн хувьд дараах зүйлийг оролцуулсан үндсэн сэдвүүд болон бүх тохиолдолд хийгдэх дадлагууд:
- 1.1. ерөнхий ур чадвар ба мэдлэгийг сэргээхэд чиглэсэн газрын дадлага;
- 1.2. шинээр боловсруулагдсан аюулгүй ажиллагааны мэдээлэл болон журмын талаарх шинэчилсэн мэдээлэл;

13.h.2) нисэх багийн гишүүд, агаарын хөлгийн диспатчер, багшлах болон үнэлгээ өгөгч этгээд, нислэгт оролцох бусад этгээдийн хувьд, үндсэн мэргэшил олгоход шаардлагатай, онгоц ба дадлагажуур дээр хийгдэх, онцгой тохиолдлын үеийн нислэгийн үйл ажиллагаа болон маневр зэргийг багтаасан, ур чадварын дадлагыг оролцуулсан үндсэн сэдвүүд болон бүх тохиолдолд хийгдэх дадлагууд;

13.h.3) нислэгийн дадлагажуур дээр багшлах болон үнэлгээ өгөгч этгээдийн хувьд, дараах зүйлүүдийг оролцуулсан үндсэн сэдвүүд болон бүх тохиолдолд хийгдэх дадлагууд:

3.1. сургалтын тоног төхөөрөмжийг ажиллуулахтай хамааралтай нислэгийн дадлагажуур дээр хийгдэх ур чадварын дадлага;

3.2. хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн үйл ажиллагаа болон маневрууд;

13.h.4) сургалтын тоног төхөөрөмж дээр багшлах болон үнэлгээ өгөгч этгээдийн хувьд, дараах зүйлүүдийг оролцуулсан үндсэн сэдвүүд болон бүх тохиолдолд хийгдэх дадлагууд:

4.1. сургалтын тоног төхөөрөмжийг ажиллуулахтай хамааралтай нислэгийн дадлагажуур дээр хийгдэх ур чадварын дадлага;

4.2. хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн үйл ажиллагаа болон маневрууд.

Үнэлгээний үе шатанд ур чадварыг үнэлэх

(13.i) Гэрчилгээ эзэмшигч, энэхүү үнэлгээний үе шатанд үнэлгээ хийлгэж буй аливаа этгээд ур чадвараа амжилттай үнэлүүлж байгааг баталгаажуулна.

(13.j) Энэ үе шатанд хийгдэх дадлага нь дараах зүйлийг багтаасан байна:

13.j.1) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдах хүн бүрийн хувьд мэргэшил олгоход шаардлагатай үндсэн сэдвүүдээр ур чадварын үнэлэлт өгөх; болон

13.j.2) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдах агаарын хөлгийн дарга болон багийн бусад гишүүдийн хувьд үйлдвэрлэлийн нислэгийн цагийн үнэлгээ өгөх.

(13.k) Ур чадварын үнэлгээг дараах зүйлүүдийг ашиглан өгнө гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана:

13.k.1) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдах агаарын хөлгийн дарга, хамтран нисгэгч, нисэх инженерийн хувьд онгоц, нислэгийн дадлагажуур, эсвэл сургалтын тоног төхөөрөмж гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хуваарийн дагуу байгааг; болон

13.k.2) хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдах бусад этгээдүүдийн хувьд, тэдгээрийн гүйцэтгэх ажил үүрэгт шаардлагатай ур чадварыг үнэлэх хэрэгсэл.

Үнэмлэгээний үед үйлдвэрлэлийн нислэгийн цагийн үнэлгээ өгөх

(13.l) Хөтөлбөрийн энэ хэсэгт хамрагдах агаарын хөлгийн дарга нь үнэлгээ өгөх хугацаа бүрт дараах байдлаар үйлдвэрлэлийн нислэгийн цагийн үнэлгээ авсан байна:

- 13.1.1) агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсвэл хөөх болон баталгаажуулах нислэг үйлдэж байгаа агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах онгоцон дээр;
- 13.1.2) үнэлгээ өгөх хугацааны дунд үед, хуанлийн нэг сарын хугацаанд; болон
- 13.1.3) үнэлгээ хийлгэх хугацаандаа амжилттай үнэлүүлсэн байна.
- (13.m) Үйлдвэрлэлийн нислэгийн цагийн үнэлгээний явцад агаарын хөлгийн дарга, хамтран нисгэгч, тухайн нислэгийн нисэх инженерийн үүргийг гүйцэтгэж байгаа этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:
- 13.m.1) тухайн төрлийн нислэгийн үйл ажиллагаа, гүйцэтгэх ажил үүрэг, онгоцны хувьд хангалттай бэлтгэгдсэн байх; ба
- 13.m.2) нисэх багийн гишүүний хувьд шаардлагатай мэдлэг, ур чадвартай байх.
- (13.n) Энэ зүйлийн (l)-ийн 3/-т заасан шаардлагыг хангах үүднээс, үйлдвэрлэлийн нислэгийн цагийн үнэлгээг шаардлагатай гэж үзсэн өдрөөс хойш нэг сарын дотор авсан бол шаардлага хангасан гэж үзнэ.
- (13.o) Агаарын хөлгийн дарга, хамтран нисгэгч болон нисэх инженер нь ИНД-61.37, эсвэл ИНД-63.157-д заасан дадлага туршлагад тавигдах шаардлагыг хангасан гэдгийг гэрчилгээ эзэмшигч бататгана.

121.917. Багийн нөөцийн удирдлага /CRM/ - ын шаардлага

- (917.a) Гэрчилгээ эзэмшигчийн танилцуулах, мэргэшүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр бүр нь дараах зүйлсийг багтаасан байна:
- 917.a.1) сургалт явуулж буй ажлын байр тус бүрт таарах багийн нөөцийн удирдлага /CRM/-ын сургалт;
- 917.a.2) нисэх багийн гишүүн бүрийн CRM-ийг ур чадвараа хэрэгжүүлэх сургалт, сургалтад оролцсон этгээдийн ур чадварт үнэлэлт дүгнэлт өгөх; болон
- 917.a.3) нислэгийн бодит буюу дууриамал нөхцөлд нисэх багийн гишүүдийн нислэгийн болон техникийн ур чадварын дадлага, тэдэнд өгөх үнэлгээ.
- (917.b) Нисэх багийн гишүүдийн хувьд энэхүү дадлага болон үнэлэлт дүгнэлт өгөх ажиллагаа нь нислэгийн дадлагажуур, эсвэл сургалтын тоног төхөөрөмж дээр хийгдэнэ.

121.919. Өгөгдөл цуглуулхад тавигдах шаардлага

Гэрчилгээ эзэмшигч нь, сургалт болон шалгалтууд нь сургалтын ерөнхий зорилгыг хүрээнд хийгдэж байгааг ИНЕГ тодорхойлоход шаардагдах мэдээллүүдийг нисэх багийн гишүүд, багш болон үнэлгээ өгөх эрх бүхий этгээдүүдээс цуглуулна.

121.921. Гэрчилгээжүүлэлт

Энэхүү хөтөлбөрийн дагуу сургалт болон үнэлгээнд амжилттай хамрагдсан аливаа этгээд дараах тохиолдолд коммерийн эсвэл агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн, нисэх инженерийн эсвэл бусад зохих зэрэглэлийг эзэмших эрхээр хангагдана:

- 921.a.1) энэ хөтөлбөрийн дагуу эзэмшсэн мэдлэг, ур чадварын дадлага, үнэлгээ нь ИНД-61, эсвэл ИНД-63 -д заасан шаардлагыг хангаж байгаа;
- 921.a.2) зохих мэргэшүүлэх сургалтын хуваарийн дагуу амжилттай суралцсан;
- 921.a.3) шаардлагатай техникийн мэдлэг, чадвар болон CRM-ын мэдлэг, чадвараа хэрэгжүүлэх ур чадвартай гэдгээ шалгалтаар харуулсан; болон
- 921.a.4) ИНД-61, эсвэл ИНД-63 -ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа.

121.923. Гэрээгээр сургалт явуулах этгээдэд зөвшөөрөл олгох

(923.a) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн бөгөөд гэрчилгээгээр мэргэшүүлэх дэвшилтэт сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр зөвшөөрөгдсөн нисэхийн сургалтын байгууллагатай энэ бүлгийн шаардлагыг хангасан хөтөлбөрийн дагуу сургалт явуулах гэрээ байгуулж болно.

(923.b) Энэ зүйлийн (a)-д заасны дагуу ИНД-141-ээр гэрчилгээжсэн байгууллагатай гэрээ байгуулж сургалт зохион байгуулах гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг багтагана:

- 923.b.1) ИНД-141-ээр гэрчилгээжсэн байгууллагын багшлах болон үнэлгээ өгөгч этгээд нь сургалт хийгдэх гэрчилгээ эзэмшигчийн мэргэшүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалтад тавигдах бүх шаардлагыг хангасан, мөн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тухай зохих мэдлэгтэй байх; болон
- 923.b.2) ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн гэрээт сургалтын байгууллага нь энэ бүлгийн шаардлагын дагуу мэргэшүүлэх дэвшилтэт хөтөлбөрт хамрагдаж мэргэшсэн этгээдүүдийн сургалтын дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан бүртгэл хөтөлж, хадгалах.

О БҮЛЭГ. EDTO НИСЛЭГИЙН ЭРХ ОЛГОХ БОЛОН ТАВИГДАХ ШААРДЛАГА**121.951. Ерөнхий зүйл**

Энэ дүрмийн 121.165-ийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй гэрчилгээ эзэмшигч, онгоцоор EDTO нислэг үйлдэхгүй:

- 951.a.1) гэрчилгээ эзэмшигч нь энэ бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх эрх авсан байх;
- 951.a.2) ИНД-119.15-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод:
 - 2.1. тухайн EDTO нислэгийг зөвшөөрсөн; болон

2.2. онгоцны их бие болон хөдөлгүүрийн хослолыг EDTO нислэгт ашиглах зөвшөөрөл олгосон байх;

951.a.3) EDTO нислэгтэй холбоотой, энэ бүлэгт тусгагдсан шаардлагуудыг ИНД-119.81-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн ерөнхий зааварт тусгасан байна.

121.953. Нөөц аэродромоос 180 минут хүртэл холдох EDTO нислэгт тавигдах шаардлага – хоёр хөдөлгүүрт онгоц

(953.a) Гэрчилгээ эзэмшигч нь хоёр турбинт-хөдөлгүүрт онгоцоор нөөц аэродромоос 180 минут хүртэл холдох EDTO нислэг үйлдэх тухай хүсэлт ИНЕГ-ын даргад бичгээр гаргаж болно.

(953.b) Гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (a)-д заасан EDTO нислэг үйлдэх эрх авах хүсэлт гаргахдаа, EDTO нислэг үйлдэхээр төлөвлөсөн хугацаанаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсвэл ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн үүнээс бага хугацаанд дараах мэдээллийг агуулсан хүсэлтийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

953.b.1) EDTO нислэг үйлдэх онгоц бүрийн их бие болон хөдөлгүүрийн хослолын дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.2) тохиромжтой аэродромоос 60 минутаас дээш нислэгийн цагтай EDTO нислэг үйлдэх бол үйлдвэрлэгчийн маягийн загварын дэлгэрэнгүй болон зөвшөөрөл (type design approval) болон энэ хэсгийн 1/-д заасан их бие болон хөдөлгүүрийн хослолын үйл ажиллагааны хязгаарлалтуудын дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.3) энэ хэсгийн 1/-д заасан их бие болон хөдөлгүүрийн хослолын төлөв байдал, техник үйлчилгээ болон журмын стандарт бичиг баримт (СМР)-ын дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.4) Хүсэлт гаргаж байгаа EDTO нислэгийн нөөц аэродромоос холдох хамгийн их хугацаа. Энэ нь 180 минутаас ихгүй байна;

953.b.5) Нөөц аэродром явах чиглэлийг оролцуулан EDTO нислэг үйлдэх чиглэл бүрийн хамгийн бага нислэгийн өндөр;

953.b.6) ИНД-121.975-ын шаардлагад нийцсэн түлшний бодлогын дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.7) ИНД-121.407-ын шаардлагад нийцсэн техник үйлчилгээний хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.8) Энэ хэсгийн 4/-т заасан, нөөц аэродромоос холдох хамгийн их хугацааны EDTO нислэг үйлдэхэд шаардагдах, энэ дүрмийн И бүлгээр шаардсан сургалтын хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.9) Энэ хэсгийн 4/-т заасан нөөц аэродромоос холдох хамгийн их хугацаанд тохирсон MEL-ийн дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.10) Тухайн онгоц ИНД-26-ийн Хавсралт Г.5.(a)-ийн 2/-т заасан ачаа, тээшний хэсгийн гал илрүүлэх болон унтраах стандарт шаардлага, эсвэл

ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн үүнтэй тэнцэхүйц стандартыг хангаж байгааг гэрчлэх баримт;

953.b.11) Тухайн онгоцны хугацаанаас хамаарсан хязгаарлагдмал системүүдийн ажиллах боломжит хугацаан дээр хүлээх нислэг, ойртолт, буултыг оролцуулан 15 минут нэмсэн хугацаа нь энэ хэсгийн 4/-т заасан хугацаанаас багагүй байна гэдгийг нотлох баримт;

953.b.12) Энэ хэсгийн 4/-т заасан хугацаанд тохирсон төлөвлөгөөт нислэгийн чиглэлд шаардагдах EDTO нөөц аэродром бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл;

953.b.13) Дараах зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

13.1. энэ хэсгийн 12/-т заасан EDTO нислэгийн нөөц аэродром бүрийн тоног төхөөрөмжүүд нь нисэх бүрэлдэхүүн болон бүх зорчигчдын аюулгүй байдлыг хангаж буйг баталгаажуулсан; эсвэл

13.2. EDTO нислэгийн нөөц аэродром бүрт нисэх бүрэлдэхүүн болон бүх зорчигчдыг аюулгүй газарт тээвэрлэх хүртэл авах арга хэмжээний төлөвлөгөө (recovery plan).

121.955. Нөөц аэродромоос 180 минут хүртэл холдох EDTO нислэгийн эрх олгох – хоёр хөдөлгүүрт онгоц

(955.a) Дараах шаардлагыг хангасан гэрчилгээ эзэмшигчид ИНЕГ-ын дарга хоёр турбинт-хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 180 минут хүртэл холдох EDTO нислэг үйлдэх эрх олгож, ИНД-119.15-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулж болно:

955.a.1) Тухайн онгоцны их бие болон хөдөлгүүрийн хослол нь үйлдвэрлэгч улсаас, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хугацааны EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн (approval from State of Design);

955.a.2) энэ дүрмийн холбогдох бүх шаардлагыг хангасан.

(955.b) Энэ зүйлийн (a)-ийн 1/-ийг үл харгалзан, хэдийгээр үйлдвэрлэгч улсаас эх бие болон хөдөлгүүрийн хослолыг нь нөөц аэродромоос холдох хугацаа нь 60 минутаас их (стандарт атмосферийн нөхцөлд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр нь татгалзсан үед чиг шулуун нислэгийн хурдтайгаар тооцсон) үйл ажиллагаанд ашиглах зөвшөөрөл олгоогүй ч, хэрэв онгоц нь хоёр тийрэлтэт хөдөлгүүртэй бол ИНЕГ-ын дарга гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод нөөц аэродромоос холдох хугацаа нь 75 минут хүртэл EDTO нислэгт ашиглах өөрчлөлт оруулж болно

121.957. Нөөц аэродромоос 240 минут хүртэл холдох EDTO үйл ажиллагаанд тавигдах шаардлага – хоёр хөдөлгүүрт онгоц

(957.a) ИНД-121.955-ийн дагуу хоёр турбинт хөдөлгүүртэй онгоцыг нислэгийн нөөц аэродромоос 180 минут хүртэл хугацаагаар холдох EDTO үйл ажиллагаанд ашиглах эрхтэй гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргад хоёр турбинт-хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 240 минут хүртэл холдох EDTO нислэг үйлдэх хүсэлтийг бичгээр гаргаж болно.

(957.b) Энэ зүйлийн (а)-д заасан EDTO үйл ажиллагаа явуулах эрх авах хүсэлт гаргасан гэрчилгээ эзэмшигч дараах мэдээллийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

957.b.1) ИНД-121.953-ийн (b)-д заасан, 240 минутаас ихгүй, хүсэлт гаргаж буй хугацааны EDTO үйл ажиллагаанд хамааралтай мэдээллүүд; болон

957.b.2) Онгоц нь дараах шаардлагыг хангасан холбооны системээр тоноглогдсоныг нотлох баримт:

2.1. ИНД-91.519 болон ИНД-121.353-т шаардсан нэмэлт холбооны тоног төхөөрөмж; болон

2.2. Нисэх багийг холбогдох НХҮ-ийн нэгж болон агаарын тээвэрлэгчтэй газрын шугамын холбоотой дүйцэхүйц чанартай шууд холбоогоор хангах боломжтой.

121.959. Нөөц аэродромоос 240 минут хүртэл холдох EDTO нислэгийн эрх олгох – хоёр хөдөлгүүрт онгоц

Дараах шаардлагыг хангасан гэрчилгээ эзэмшигчийг ИНЕГ-ын дарга хоёр турбинт-хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 240 минут хүртэл холдох EDTO үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож ИНД-119.15-д шаардсан үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулж болно:

13.a.1) гэрчилгээ эзэмшигч ИНД-121.955-ийн дагуу олгосон зөвшөөрлийн дагуу 180 минутаас бага EDTO үйл ажиллагаа явуулах чадвартай гэдгээ харуулсан; болон

13.a.2) Тухайн онгоцны их бие болон хөдөлгүүрийн хослол нь үйлдвэрлэгч улсаас, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хугацааны EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн; болон

13.a.3) ИНД-121.957-ийн (б)-ын шаардлагыг хангасан бол.

121.961. Нөөц аэродромоос 240 минутаас дээш хугацаагаар холдох EDTO үйл ажиллагаанд тавигдах шаардлага – хоёр хөдөлгүүрт онгоц

(961.a) Хэрэв хүсэлт гаргах үед гэрчилгээ эзэмшигч дараах шаардлагыг хангаж байх тохиолдолд ИНЕГ-ын даргад хоёр турбинт хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 240 минутаас дээш хугацаагаар холдох EDTO үйл ажиллагаа явуулах хүсэлт бичгээр гаргаж болно:

961.a.1) өмнөх 24 сарын хугацаанд ИНД-121.955, эсвэл ИНД-121.959-ийн дагуу ИНЕГ-ын даргын олгосон EDTO үйл ажиллагаа явуулах эрхийн хүрээнд хоёр турбинт хөдөлгүүртэй онгоцоор EDTO үйл ажиллагаа явуулж байсан; болон

961.a.2) өмнөх 12 сарын хугацаанд ИНД-121.959-ийн дагуу ИНЕГ-ын даргын олгосон эрхийн дагуу 180 минутаас дээш хугацааны EDTO үйл ажиллагааг тухайн эх бие болон хөдөлгүүрийн хослолтой онгоцоор явуулсан.

(961.b) Энэ зүйлийн (а)-д заасан EDTO үйл ажиллааны эрх авах хүсэлт гаргасан гэрчилгээ эзэмшигч дараах мэдээллийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- 961.b.1) EDTO үйл ажиллагааны хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хамгийн их хугацаанд тохирох, ИНД-121.953-ийн (b)-д заасан мэдээлэл; болон
- 961.b.2) Онгоц нь ИНД-121.957-ийн (b)-ийн (2)-т шаардсан холбооны системээр тоноглогдсоныг нотлох баримт.

121.963. Нөөц аэродромоос 240 минутаас дээш хугацаагаар холдох EDTO үйл ажиллааны эрх олгох – хоёр хөдөлгүүрт онгоц

(963.a) Дараах шаардлагыг хангасан гэрчилгээ эзэмшигчийг ИНЕГ-ын дарга хоёр турбинт-хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 240 минутаас дээш хугацаагаар холдох EDTO нислэг үйлдэхийг зөвшөөрч, ИНД-119.15-д заасны дагуу үйл ажиллагааны тодорхойлолтод нь өөрчлөлт оруулж болно:

- 963.a.1) гэрчилгээ эзэмшигч ИНД-121.961-ийн (a)-ийн дагуу EDTO нислэг үйлдэх чадвартай гэдгээ харуулсан; болон
- 963.a.2) тухайн онгоцны их бие болон хөдөлгүүрийн хослол нь үйлдвэрлэгч улсаас, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хугацааных EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн; болон
- 963.a.3) ИНД-121.961-ийн (b)-д заасан шаардлагыг хангасан бол.

121.965. EDTO нислэгт тавигдах шаардлага – хоёроос дээш хөдөлгүүртэй онгоц

(965.a) Гэрчилгээ эзэмшигч хоёроос дээш турбинт хөдөлгүүрт онгоцоор, тохиромжтой аэродромоос нислэгийн 180 минутаас дээш хугацаагаар холдох шаардлагатай чиглэлд (стандарт атмосферийн нөхцөлд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр татгалзсан үеийн хурдтайгаар тооцсон) EDTO үйл ажиллагаа явуулах эрх авах хүсэлтээ ИНЕГ-ын даргад бичгээр гаргаж болно.

(965.b) ИНД-121.967-ийн (b)-д хамааралтайгаар, энэ зүйлийн (a)-д заасан EDTO үйл ажиллагаа явуулах эрх авах хүсэлт гаргасан гэрчилгээ эзэмшигч дараах мэдээллийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- 965.b.1) EDTO үйл ажиллагааны хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хамгийн их хугацаанд тохирох, ИНД-121.953-ийн (b)-д заасан мэдээлэл; болон
- 965.b.2) Онгоц нь ИНД-121.957-ийн (b)-ийн 2/-т шаардсан холбооны системээр тоноглогдсоныг нотлох баримт.

121.967. EDTO нислэгийн эрх олгох – хоёроос дээш хөдөлгүүртэй онгоц

(967.a) Энэ зүйлийн (b)-д хамааралтайгаар, дараах шаардлагыг хангасан гэрчилгээ эзэмшигчийг ИНЕГ-ын дарга хоёр дээш турбинт-хөдөлгүүрт онгоцоор, нөөц аэродромоос 180 минутаас дээш хугацаагаар холдох EDTO үйл ажиллагаа явуулхыг зөвшөөрч, ИНД-119.15-д заасны дагуу үйл ажиллагааны тодорхойлолтод нь өөрчлөлт оруулж болно

- 967.a.1) ИНД-121.965-ийн (b)-д заасан шаардлагыг хангасан; болон

967.а.2) тухайн онгоцны их бие болон хөдөлгүүрийн хослол нь үйлдвэрлэгч улсаас, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт гаргасан нөөц аэродромоос холдох хугацааны EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн.

(967.б) Гэрчилгээ эзэмшигч онгоцны их бие, хөдөлгүүрийн хослол нь хүсэлт гаргасан “нөөц аэродромоос холдох хамгийн их хугацаа”- д EDTO үйл ажиллагаа явуулхад тохиромжтой гэдгийг ИНЕГ-ын даргад нотлох баримтаар харуулсан тохиолдолд, ИНД-121.953-ийн (b)-ийн 3/-ын их бие болон хөдөлгүүрийн хослолын төлөв байдал, техник үйлчилгээ болон журмын стандарт бичиг баримт (СМР) –тай хамааралтай шаардлагууд болон энэ зүйлийн (a)-ийн 2/-т заасан их бие, хөдөлгүүрийн хослолын үйлдвэрлэгч улсаас олгосон EDTO зөвшөөрөл нь 2018 оны 11-р сарын 01-ний өдрөөс өмнө үйлдвэрлэгдсэн хоёроос дээш хөдөлгүүртэй нөөц аэродромоос 180 минутаас дээш хугацаагаар холдох EDTO үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа онгоцонд хамаарахгүй.

121.969. EDTO нислэг гаргахад (dispatch) тавигдах шаардлага – ерөнхий зүйл

(969.а) Энэ бүлгийн дагуу EDTO үйл ажиллагаа явуулах эрхтэй гэрчилгээ эзэмшигч дараах шаардлагыг хангаагүй онгоцыг EDTO нислэгт гаргахгүй (dispatch):

969.а.1) ИНД-91.519 болон ИНД-121.353-т шаардсан холбооны системүүд нь ажиллагаатай байх;

969.а.2) энэ зүйлийн (b)-д хамааралтайгаар, тухайн нислэгт шаардлагатай хөөрөх, хөөрөлтийн нөөц, буух, буултын нөөц, чиг шулууны EDTO нөөц аэродром зэрэг бүх аэродромуудын талаарх мэдээллээр агаарын хөлгийн даргыг хангадаг байх;

969.а.3) нөөц аэродромоос 180 минут хүртэл (180 минутыг оролцуулсан) холдох EDTO нислэгт сонгосон, маршрутын дагуух EDTO нөөц аэродромын жагсаалтаас хамгийн ойр аэродромд нисэн хүрэх хугацаа нь (стандарт атмосферийн нөхцөлд, тогтуун агаарт нэг хөдөлгүүр нь татгалзсан үеийн хурдаар тооцсон) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан хамгийн эрсдэлтэй, хугацаанаас хамаарах хязгаарлагдмал систем (хамгийн хязгаарлагдмал хугацаатай ачаа болон тээшний хэсгийн галтай тэмцэх хугацааг оролцуулан)-ийн боломжит хугацаанаас 15 минут хасаж тооцсоноос хэтрэхгүй байх.

(969.б) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй аэродромыг энэ зүйлийн (а)-ийн 2/-т заасан EDTO нислэгт сонгосон маршрутын дагуух нөөц аэродромын жагсаалтад оруулж болохгүй:

969.б.1) тухайн аэродром нь EDTO нөөц аэродром байх бөгөөд ИНД-119.15-ын (d)-ийн 3/-т заасны дагуу гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод тусгагдсан байх;

969.б.2) Дох хаяж нэг хэрэглэлийн ойртолтын журамтай бөгөөд тухайн улсын НМЭ-д заасан, буух боломжит хамгийн эхний мөчөөс сүүлийн мөч хүртэл хугацаанд ашиглах боломжтой байх;

969.б.3) тухайн аэродромын хамгийн сүүлийн цаг уурын урьдчилсан мэдээгээр буух боломжит хамгийн эхний мөчөөс сүүлийн мөч хүртэл хугацаанд:

- 3.1. тухайн аэродромын цаг уурын нөхцөл нь ИНД-121.977-д заасан маршрутын дагуух EDTO нөөц аэродромоор төлөвлөх хязгаарлалттай тэнцүү эсвэл дээгүүр; болон
- 3.2. буулт үйлдэх зурвасны хөндлөнгийн салхи (өрөвхийлөлтийг оролцуулсан) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан хязгаарлалтаас хэтрэхгүй байх.

(969.c) Онгоцыг EDTO нислэгт гаргах үед энэ зүйлийн (b)-ийн 3/-т шаардсан цаг уурын урьдчилсан мэдээг авах боломжгүй аэродромыг EDTO нислэгийн нөөц аэродромоор сонгож нислэгийг эхлүүлж болох боловч агаарын хөлгийн дарга тухайн нөөц аэродромгүйгээр нисэж болох цэгээс цааш нислэгийг үргэлжлүүлж болохгүй. Хэрэв нислэгийн явцад дээрх цэгт хүрэхээс өмнө энэ зүйлийн (b)-ийн 3/-т шаардсан цаг уурын урьдчилсан мэдээг хүлээж авсан тохиолдолд нислэгийг цааш үргэлжлүүлнэ.

(969.d) Энэ зүйлийн (b)-ийн 3/-т хамааралтайгаар, цаг уурын урьдчилсан мэдээний магадлал 40%-иас доош байвал тооцоонд оруулахгүй байж болох боловч түр зуурын буюу TEMPO үзэгдлийг түлшний тооцоонд зайлшгүй оруулна.

121.971. EDTO нислэг гаргах (dispatch) –нөөц аэродромоос 180 минутаас дээш холдох EDTO нислэгийн нэмэлт шаардлага

Энэ бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх эрхтэй гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй онгоцыг маршрутын дагуух нөөц аэродромоос 180 минутаас дээш холдох EDTO нислэгт гаргахгүй:

13.а.1) ИНД-121.969-д заасан шаардлагууд хангагдсан; болон

13.а.2) тухайн онгоцны дараах системүүд ажиллагаатай байх:

- 2.1. түлшний хэмжээг заагч системүүд;
- 2.2. туслах хөдөлгүүр (APU), (хэрэв EDTO зөвшөөрөл авахад ажиллагаатай APU –тай байхыг шаардсан бол туслах хөдөлгүүрээс ажиллах цахилгааны болон хийн (pneumatic) системүүдийг оролцуулна);
- 2.3. Хөдөлгүүрийн хүчийг автоматаар баригч (auto throttle/auto thrust) системүүд;
- 2.4. ИНД-121.957-ийн (b)-ийн 2/-т шаардсан холбооны системүүд;

13.а.3) хэрэв нислэгийг төлөвлөгөөг нэг хөдөлгүүр татгалзсан нисэхээр тооцсон бол тухайн онгоц нь нэг хөдөлгүүр татгалзсан авто-буулт хийх чадвартай байна;

13.а.4) EDTO нислэг гаргахад сонгосон, маршрутын дагуух нөөц аэродромын жагсаалтаас хамгийг ойр нөөц аэродромд хүртэл нисэх хугацаа нь (бүх хөдөлгүүр ажиллагаатай чиг шулуун нислэгийн салхи болон температурын засвар хийгдсэн хурдтайгаар) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан хамгийн хягаарлагдмал ачаа болон тээшний хэсгийн гал эсэргүүцэх боломжит хугацаанаас (fire suppression time) нислэгийн аль ч үед 15 минут хасаж тооцсоноос хэтрэхгүй байх;

13.а.5) EDTO нислэг гаргахад өгөгдсөн нөөц аэродромын жагсаалтын хамгийн ойр нөөц аэродром хүртэл нисэх хугацаа (салхи болон температурын засвар

хийгдсэн, нэг хөдөлгүүр татгалзсан чиг шулуун нислэгийн хурдаар) нь тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тусгагдсан хамгийн хязгаарлагдмал боломжтой системийн хугацаанаас (ачаа болон тээшний хэсгийн гал эсэргүүцэх системийг оролцуулахгүйгээр) 15 минут хасаж тооцсоноос хэтрэхгүй байх.

121.973. EDTO маршрутын нислэг

(973.a) Энэ бүлгийн дагуу EDTO нислэг үйлдэх эрхтэй гэрчилгээ эзэмшигч нь EDTO нислэг гаргахад сонгосон маршрутын дагуух EDTO нөөц аэродромуудын нөхцөл байдалд EDTO нислэг гарсны дараа ноцтой өөрчлөлт гарсан тохиолдолд дараах нислэгийн үе шатуудад агаарын хөлгийн даргад мэдэгдэнэ:

